

ОЮУН САНААНЫ

дадал бясалгалын

НУУЦ

ХЯЛБАР АРГУУД



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэн нэгнээс болж Өөрийнхөө уг чанарыг алдаж болохгүй. Ийм байж чадаж гэмээ нь бид жинхэнэ өөрөөрөө, ердийнхөөрөө сэтгэл татам, дур булаам бөгөөд гоо сайхан нэгэн байж чадна. Бусдыг хуулбарлах нь сайн зүйл биш.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай





Та хүмүүсийг хайрлаж байвч хүмүүс таныг хайрлахгүй байж мэднэ. Тиймээс тэднээс хариу горьдохгүй зүгээр л хайрлаж байвал дээр.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани



Эрхэм хайрт та нартаа,

Урам зориг дүүрэн шинэ оны
мэндийг дэвшүүлж, энэ он оюун санааны аугаа
бөгөөд цоо шинэ сэхээрлийн эхлэлийг тавих
болтугай хэмээн хүсэн ерөөе.

Өдөр бүхэн тань гайхамшиг, аз жаргал,
хайр энэрэл болон билиг ухаанаар бялхаж байг.

Амьдралын энэхүү шинэ хуудсанд
Оройн Дээд Бурханы өршөөл, адислал хамгийн
нандин эрдэнэ болон гэрэлтэх болтугай.


Ching Hsi

(Их Багшийн 2003 оны шинэ жилийн илгээлт)





**Авшиг авмагц бид цаг
хугацаа, орон зай, дэлхий
ертөнцийн зүй тогтлоос
ангид, зүтгэл чармайлтгүй
үйлдэх тэр л оршихуйд
хөл тавьдаг юм.**


**Огтоос санаанд оромгүй
зүйлс тохиолдож, амьдрал
маань үнэхээр л Дэлхий
дээрх Диваажин болдог.
Бид угаас ингэж л амьдрах
ёстой юм, учир нь бид
Оройн Дээд Бурханы
хүүхдүүд.**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар

Тэнсэлгүй Үнэхээр Туулсан Төгс Их Багш Чин Хай төв Ау Лакт мэндэлжээ. Залуу насандаа Тэрбээр Англид суралцахаар явж, улмаар Германд суурьшин, Улаан Загалмайн орчуулагч хийж, дүрвэгсдэд тусалж байв. Тэндээ нэгэн герман эмчтэй гэр бүл болсон бөгөөд амьдралынхаа туршид тэмүүлсэн оюун санааны гэгээрэл гэдгийг айлын эзэгтэй байхдаа ч зогсолтгүй эрэн хайсаар байжээ.



Эцэстээ нөхөр нь Түүний энэ мятаршгүй чин эрмэлзлийг дэмжиж, Тэрбээр Үнэн Ёсыг хайж олохоор алдарт Гималайг зорьсон юм. Олон жил хайсны эцэст хүмүүн бидний жинхэнэ мөн чанар болсон дотоодын Гэрэл ба Аялгууг бясалгадаг Арьяабалын номын цогцыг Түүнд уламжлан өгсөн, амьд сэрүүн Багшаа олж, төгс гэгээрэлд хүрчээ.



Тэр цаг үеэс эхлэн Чин Хай Багш, чин сэтгэлт олны Үнэн Ёсыг хайсан их эрэлд хариу барьж, дэлхийн өнцөг булан бүрт номоо уламжлахын сацуу дүрвэгсэд, байгалийн гамшигт нэрвэгдэгсэд болон ядарсан олонд тусламжийн гараа сунган, Өөрийгөө болон номын шавь нараа уран бүтээл, ном хэвлэл, дуу хөгжим, нуу найргийнхаа үр шим, хөлс хүчээр тэжээн тэтгэсээр ирлээ. Хүн төрөлхтний оюун санаа болоод амь амьдралын аль сайн сайхны тусын тулд цуцалтгүй зүтгэж буй Түүний хөдөлмөрийг олон орны засгийн газрууд болон төрийн бус байгууллагууд үнэлж, шагнаж ирсэн юм.

Бидний олонхийн нэгэн адил, Чин Хай Багш төрөхөөсөө л эхлээд гэгээнтний амьдралаар амьдраагүй, харин эгэл хүний амьдралыг олон жил үзэж туулсан билээ. Хэдий тийм боловч, Тэр гэгээрснийхээ дараа Бурханы Орныг өөрийн биеэр оноон таньсан юм. Тэрбээр бусад хүмүүсийг жинхэнэ Бурханлаг оршихуйд хүргэх хөтөч болж, Арьяабалын аргыг хүссэн бүхэнд үнэ төлбөргүйгээр уламжлахад хэзээ ямагт бэлэн байдаг юм. Түүний өөр нэг номонд өгүүлсэнчлэн, Тэр таныг “гэрт тань хүргэж өгөхөөр ирсэн” билээ.

ӨМНӨХ ҮГ

Арьяабалын бясалгалтнууд бол энэ дэлхийн хамгийн их хувь заяатай хүмүүс юм. Бид нэгэн төрөлд гэтэлгэх агуу их бясалгалын аргатай учирсан төдийгүй, түүнийгээ амьд сэрүүн жинхэнэ Их Багшаас уламжлан авсан билээ. Гэсэн хэдий ч Бурханы Оронд гэртээ хүрэх аян замаас маань уруу хойш татах саад бартаа их ажгуу. Тиймээс ч та “Амьдралынхаа төөрөг зургийг би яаж саадгүй сайн гүйцэлдүүлэх вэ?” гэж олонтаа асуудаг байж мэднэ. Тийм байх аваас санаа зоволтгүй. Өршөөлт Их Багш маань Өөрийнхөө туршлагад үндэслэн бидний оюун санааны зам мөрийг хялбар дөхөм болгож туслахуйц үр нөлөө, өгөөж сайтай олон сайхан зөвлөгөөг айлдсан байх юм. Бид эдгээр зөвлөгөөг санаж, өдөр бүрийн бясалгал дадалдаа хэрэгжүүлбээс Гэртээ сайн явж очих тэр цагийг хүртэл Маяагийн арга мэхээс зайлж, ертөнцийн бусад асуудал бэрхшээлийг давж гарахад асар их тус дэмжлэг болно.

Ердийн бүх л ажлыг сайн хийх нууц гэж байдгийн адил оюун санааны ажил хэрэгт ч нууц гэж байна. Тэдгээр нууцыг мэдсэнээр, бид бясалгал дадалдаа цаг, хүч бага зарцуулж, ижил үр дүнд илүү түргэн хүрнэ. Бидний хүчин чармайлтад нэмэр болохын тулд, олон жилийн турш Их Багшийн айлдаж ирсэн сургаалын охь шимийг өөрсдөдөө сануулахын үүднээс энэхүү эмхтгэлийг бэлтгэсэн юм. “Би хэдийнээ хаа сайгүй эрэн хайсан учраас миний та нарт уламжилснаас дээр гарах арга үгүй гэдгийг мэднэ” хэмээн Их Багш маань айлдсан билээ.



Бидэнд оюун санааны ийм үнэлж баршгүй нандин эрдэнэ хайрласан Их Багш Тандаа баярлалаа.

Гарчиг

Сүнсний аяны арван нууц

- Үнэнийг дээдэд барихуй 19
- Багшдаа бүрэн итгэхүй 35
- Дияаны үед сэтгэлийн уяагүй төвлөр 43
- Оюун санааны хөтөч Багш нарын дэргэд байхын ач тус 56
- Төлөв даруу байдал Үнэн Ёсонд ойр 67
- Чин ариун сэтгэлтэн илүү түргэн дэвшдэг 83
- Тайвшрал 95
- Аз жаргалтай бай 119
- Гэр бүлээ хайрла 133
- “Би” үзэл ба Аялгууны бясалгал 145



Зарим өчүүхэн нууцаас хуваалцах нь

Этгэлээ хамтад нь хөгжүүл	165
Уур бидний бясалгалд саад болно	168
Өөрсдийгөө үргэлж өөдрөг бөгөөд ариун авч яв	170
Цэвэр ариун хоол идэхийг хичээ	176
Өргөл барьцанд шунахын үр дагавар	180
Зерэг энергийн гэрлэн хүрээ үүсгэ	183
Бэлгийн дур хүслийг багасгах арга	185
Эн ном, видео бичлэг нь оюун санааны шилдэг тэтгэгч мөн	191
“Ba Guan Zhai Jie” буюу найман сахилын жинхэнэ утга учир	194
Бясалгал зутрах ахуйд тамиржуулах эм заримдаа хэрэгтэй	198



■ л хийхэд хамгийн тохиромжтой цаг 203

Өглөө эртийн бясалгалыг хэрхэн дадуулах вэ 207

Хоёр цаг хагасыг цаглашгүйд урвуулахуй 213

Маш их бясалгаад ядрахгүй байх арга 217

■ к байхад саад тотгор тохиолдвол 221

Билиг ухааныхаа төв дээр дотооддоо төвлөрөх 226

Бясалгах үедээ чичирхийлэхийг яаж зохицуулах вэ? 232

Зориг хатуужлаа хүчтэй болгож саад бэрхшээлийг
давж гарах нь 235

Бодол сэтгэлийг номхотгохуй 239

Адислал хэдийд ч санаандгүй ирж болно 245

н дэвшихийг хүсэгчдэд 249

Гашуун бясалгалаар үйл лай арилахгүй 251

Үнэн зөв аргаар бясалгахуй 253

Гэгээрэлд хүрэх зам мөр 256

Амь биеэ хайрлахгүй тусыг бүтээх 258

Хэдий их ажиллана төдий чинээ гэгээрдэг 261

Их Багш байхын утга учир нь өөрийгөө хөгжүүлж, төгс төгөлдөр
болгоход оршино 266

Сэтгэлээ дадуулж, өөртөө итгэж сур 270

Хэлбэлзлийн хурдтай болох 272

Олны тусыг бүтээх нь үйлийн үрийг арилгах хамгийн
хурдан арга 276

Өөрийгөө золиослох, үнэн хайрын тод жишээ бай 283

ийтийн бясалгалаас ер бусын ашиг тусыг
287

Яаж сайн төвлөрч, сайн бясалгах вэ? 291

й гэдгийг ойлгохын тулд л бид хичээж

Эзэн Бурханы нигүүлсэл бялхсан эрин үе 301

Бясалгах боломжийг нандигна 304

Бид бол хамгийн азтай бясалгагчид 308

Ашигласан материал 314

Хэвлэл 322

Бидэнтэй хэрхэн холбогдох вэ 332

Эзэн Бурхан болоод Дээд Оюун Санааны тухай ярихдаа Эзэн Бурхан эр эсвэл эм хүйстэй алин болох маргаанаас зайлсхийж, хүйсний ялгаа заадаггүй өвөрмөц нэр томьёо хэрэглэж байхыг Багш бидэнд зөвлөсөн юм.


She + He = Hes (Bless гэдэгтэй адил дуудна.)

Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)

Hers + His = Hiers (Dear гэдэгтэй адил дуудна.)

Жишээлбэл: Эзэн Бурхан хүсвэл юмыг Тэрээр (Hes) Өөрийн (Hirmself) тааллаар, Түүний (Hiers) хүсэл зоригт нийцэж байхаар хийдэг юм.

Оюун санааны багш, уран бүтээлч дизайнер Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоодын гоо сайхныг илэрхийлсэн бүхий л зүйлд дуртай байдаг юм. Тиймээс ч Тэр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” хэмээн нэрлэдэг. Ау Лак гэдэг нь эртний вьетнам хэлээр “аз жаргал” гэсэн үг бол, Формоса буюу “үзэсгэлэнтэй” гэсэн үг нь Тайваний арлын байгаль болоод ард түмний сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн нутаг орон ард түмэнд нь аз жаргал, оюун санааны дэвшил авчирна гэж Их Багш үздэг юм.





Сүнсний

аяны

арван


нууц



Их Багш энэ Дэлхийд
залрахуйд билиг увдисыг нь
зөвхөн шавь нар нь хүртэж
гэгээрээд зогсохгүй хамаг хүн
төрөлхтөн ариусч, ухамсар
нь тодорхой түвшинд өөдлөн
дэвшдэг.

Үнэнийг дээдэд барихуй

Их Багш хэрхэн Төгс Үнэнийг оноосон тухайд



Оюун санааны зам мөрт зориг
шулуудсан миний сэтгэлд бодогдох
юм, шаардах зүйл, санагдах хүн огт
байгаагүй. Энэ дэлхийн юунд ч үл
хүлэгдэх намайг тэр үед Үнэний төлөө
амиа өг гэсэн бол өгөхөөр л байсан.



Надад байгаагаас ердөө дан ганц чин сэтгэл л байлаа

Одоо ингээд бодоход миний Үнэнийг оноосонд ямар нэг нууц гэх юм үгүй аж. Надад байгаагаас дан ганц чин сэтгэл л байлаа. Оюун санааны зам мөрт зориг шулуудсан миний сэтгэлд бодогдох юм, шаардах зүйл, санагдах хүн огт байгаагүй. Би угаасаа л тийм байв. Энэ дэлхийн юунд ч үл хүлэгдэх намайг тэр үед Үнэний төлөө амиа өг гэсэн бол өгөхөөр л байсан. Хоолтой ч байсан, хоосон ч хоносон би дан ганц оюун санааны бясалгал дадлаа л эрхэмлэн хичээж байв. Хоол хөөцөлдөж Үнэнээс сатаарч байсангүй, хоолноос болж гомдоллож ч байсангүй.

Энэтхэгт байх үедээ би уулзсан Их Багш гэгдэгч нарт хамаг мөнгөө өргөл болгож өгчихөөд өөрөө сохор зоосгүй үлддэг байснаа санаж байна. Би өөрийгөө хэзээ ч хэдхэн ширхэг боов, чихэр

зайрмагны мөрөөс болж явах хүн гэж бодож байгаагүй. Тэр үед би хоолонд сайн, арвин ч иддэг байлаа. Гэтэл улаан мөнгөгүй хүн яах вэ дээ. Өдөр бүр жаахан жигнэмэг олж идэхсэн гэж галзуу юм шиг мөрөөдөвч юу ч олдохгүй. Хааяа зөвхөн бусад хүмүүстэй хамт гадуур гарч хоолловол, юу өгснийг нь бирд шиг залгичихдаг байв. Гэвч энэ бүх байдал намайг Үнэнийг хайсан хүсэл тэмүүллээс минь салгаж чадаагүй юм даа. Өөрийн зан чанараас санах юм ердөө энэ л байна. Тийм ч болохоор Эзэн Бурхан намайг өрөвдөж хайрлаад “Үнэн” гэдгийн амтыг мэдрүүлсэн биз.

Иймд би энэ нууц аргыг та нарт ойлгуулья гэсэн юм. Үнэнийг үтэр түргэн онооё гэвэл бид туршлагатай Багшийг эрж олохын сацуу Үнэнд чин сэтгэлээсээ тэмүүлэх хэрэгтэй; тэгвэл л болох нь тэр. Эзэн Бурхан биднээс өргөл барьц нэхэхгүй, үргэлж мацаг (цагаан) хоол идэхийг ч шаардахгүй. Цагаан хоолны дэглэмийг бид зам мөрийнхөө саад барцадыг багасгах болон амины өр төлөөсөнд үл



орохын тулд л сахиж байгаа юм шүү дээ. Түүнээс биш Эзэн Бурхан хэзээ ч, хэнд ч хатуу нөхцөл болзол тулгаагүй.

Үлгэрлэвэл, сургуульд байхад багш нар биднийг орой унт, эрт бос, үүнийг ч сурч, түүнийг ч мэд гэж шаарддаггүй. Тэд бидэнд хатуу шаардлага тавьдаггүй хэдий ч сурагч бид орой унтаж, эрт босч байхгүй бол амжилттай сурч чадахгүй гэдгээ ухамсарладаг. Мөн сурч байхдаа бид элдэв зугаа цэнгэлээс зайлсхийцгээдэг. Оюутан цаг хэний ч хувьд хатуу байгаагүй гэж үү? Бид хамгаа золиослон суралцаж, зугаа цэнгэл гэдэг юм бараг мэддэггүй. Бүжиг, цэнгээнд хааяа нэг явахаас биш өдөр бүр явдаггүй байсан нь л лавтай. Багш профессорууд биднийг хорьж цагдаад байсан юм байхгүй шүү дээ. Бид л харин өөрсдийгөө залхуурч болохгүй, зөвхөн ингэж байж л амжилттай суралцана гэдгээ мэдэж байсан хэрэг. Лазан хойрго байвал бид анги улирч, эсвэл шалгалтандаа унаж мэдэх байсан.

🌀 Үнэнийг дээдэд барихуй 🌀

Оюун санааны бясалгалыг дадуулагч бид зарим нэг нууц зааварчилгааг дагаж мөрдөж байх учиртай. Тухайлбал, бие, хэл, сэтгэлээ ариун байлгахын тулд цагаан хоолтон байх ёстой. Өчүүхэн ч гэсэн гэм буруутай мэдрэмж санаа зовоогоод байхгүй бол сэтгэл амар байдаг юм. Бид бас гэр бүлээ сайтар харж хандан, хань ижилдээ үнэнч байх учиртай. Яагаад тэр билээ? Яагаад гэвэл, гэр бүл нь хямарсан, сэтгэлийн зовлонтой хүн оюун санааны бясалгалаа үргэлжлүүлэхэд хэцүү. Сэтгэл санаа нь сатаарч, улмаар оюун санааныхаа хөгжилд хамаг анхаарлаа төвлөрүүлж чадахгүйд хүрнэ. Тиймээс эдгээр сахилууд нь бидэнд тус дэм болох гэж, сургуульд сурч байгаа мэт бясалгалдаа голлон анхаарах цаг бидэнд илүүтэй гаргаж өгөхийн тулд байгаа юм шүү дээ. Цаашилбал бид мөн олиггүй кино



үзэх, садар самуун юм уншихаас зайлсхийж байх нь зүйтэй. Энэ нь биднийг элдэв сэрэлд автан өөрсдийн дотоодын Мөн Чанар болон Үнэнд хүрэх гэсэн чин эрмэлзлээ умартахаас сэргийлнэ. Гэхдээ зөвхөн сахил сахиснаараа бид Бурханы хутгийг олохгүй. Тиймгүй шүү! Тэгэхгүй! Өөр нэг жишээ авъя л даа. Ердөө ч бүжиг, цэнгээнд явдаггүй оюутан байлаа гээд бод. Тэр хичээлээ давтахгүйгээр сургуулиа төгсөж чадах уу? Чадахгүй! Сахилгатай бол зөвхөн нэмэртэй л дээ. Үүний нэгэн адил, та нар зөвхөн сахил сахиж, цагаан хоол идэж, судар тарни уншсанаар Бурханы хутгийг олно гэж үгүй. Хамгийн сайндаа л зарим нэг талын мэдлэгтэй болж, ёс суртахууныг илүүтэй ойлгодог болно. Бурханы хутагт хүрье гэвэл нандин эрдэнээ дотоодоосоо нээн илрүүлэхэд чиглэсэн тэс өөр дадлага сургуулийг бид хийх ёстой юм.

❧ Хамгаа даамгахуй ❧

Би та нарын юу хийх ёстойг зааж хэлдгээ Бурханы хутагт хүрсэн хойно чинь л болино, харин одоо бол арай болоогүй. Одоохондоо та нар дүрэм журмыг дагаж мөрдөж, сахилга батыг өөрсдөдөө дадуулах шаардлагатай. Эс бөгөөс та нарын анхаарал сарниж, эцсийн гол зорилго дээрээ төвлөрч чадахгүйд хүрнэ. Оюун санааны замд шинээр хөл тавьж буй та бүхэн Үнэнд итгэх сэтгэлээ батжуулахын тулд сахилаа чандлан сахисан нь өлзийтэй. Тиймээс “Та яагаад ийм хатуу юм бэ?” гэж надаас бүү асуугаарай. Гол нь миний хатууд байгаа юм биш ээ! Би та нарт нууц тарнийн бясалгалыг зааж өгье л гэсэн. Бясалгалдаа бид хэт энгийн байдлаар хандвал энэ төгс аргыг сурч эзэмшихэд хэцүү байх болно. Иймд шинэ авшигтнууд багшийнхаа зааврыг дагаж байх ёстой. Багшийн зааврыг дагах тун хэцүү. Та



нар цөм чадна гэж бодож байгаа. Гэвч сорилго ирэхийн цагт унаж мэднэ шүү.

Нэгэн Энэтхэг сударт бичсэнчлэн: Лалын шашны сахилд архи уухыг зөвхөн хориглох төдийгүй хувцас хунар, мөргөлийн олбог сэлтээ архины ойр хавьд ч байлгаж болохгүй гэдэг. Гэтэл өөр нэгэн сургаалд “Гэгээн Багш чинь чамайг хамаг хувцсаа архинд дэвтээ гэж хэлсэн ч чи түүнийг дагах л ёстой” гэсэн байдаг. Энэ бол Багш юу л хэлнэ, түүнийг хий гэсэн үг. Ингэх тун хэцүү! Мөн эртний Хятадын сургаалд: “Сүмд орохдоо өөрийн бие, хэл, сэтгэлээ Луу Бурханы Номын Ёсыг Хамгаалагчдад даатгасугай” гэсэн байдаг нь хамаг бүхнээ даатга гэж хэлж байгаа хэрэг. Өөрийн гэх санаа, “би” хэмээх ойлголт, хувь хүний хувьд хэдийн төлөвшсөн үзэл болон бодлоос чөлөөлөгдсөн бол та бүхнийг огоорогчийн төлөвт хүрчээ гэсэн үг. Гагцхүү ингэх нь туйлын бэрх, миний ажсанаар хэдхэн л хүн энэ сорилгыг давж гарчихаад байгаа юм даа.

Сэтгэл тань хүүхдийнх шиг аруун байх учиртай

Би Энэтхэгт байхдаа дэлхий дахинаа алдартай нэгэн багштай уулзсан юм. Би тоосны харшлаас болоод ч юм уу, маш айхавтар ханиалгаж байлаа л даа. Тэнд байхдаа би өдөр бүр хог шүүрддэг байлаа. Хэн ч тийм ажлыг хийх хүсэлгүй, шат нь бохир заваан, тун их тоос шороонд дарагдсан байхыг би ажсан юм. Цонхны торон хаалтнууд ч хүртэл асар их тоосонд дарагдсан байсан тул би бүгдийг нь сайтар цэвэрлэв. Би өөрийгөө сайн хамгаалаагүйгээс хог, тоос шүүрдэж байхад миний уушги руу орчихсон бололтой, хэдэн сарын турш ханиалгав. Уушги минь дэлбэрэх нь үү дээ гэж бодогдтол ханиалгаж, үхэх гэж байгаа юм шиг бүр тэсвэрлэхийн аргагүй боллоо. Өдөр шөнөгүй ханиагаад, унтаж чаддаггүй, бясалгаж ч чаддаггүй. Тэгтэл багш



маань дуудуулав. Би тэгэхэд түүнд маш их итгэдэг байв, ер нь би багш болгонд л итгэдэг байв. (Багш инээв.) Сонирхолтой нь би гойд сүжигтэй байлаа. Хүмүүс хэн нэгнийг Гэгээрсэн Багш гэв үү үгүй юу, би шалгаж үзэх ч үгүйгээр итгэчихнэ. Уулзсан багш бүрт л би ингэж ханддаг байлаа.

Тухайн үед би энэ багшид итгэдэг байж таарч. Намайг маш хүнд ханиалгаж байхыг анзаараад тэр дуудуулжээ. Би түүнийг надад ямар нэг нууц жорын эм тан өгч ханиалгыг минь намдаачих болов уу, ид шидээр эмчилчих ч юм билүү гэж бодлоо. Орж очвол тэр намайг нэг аягатай шингэн зүйлийг уу гэж байна. Намайг уучихсан хойно лонхон дээрх хаягийг нь тэд шалгав. Тэгснээ тэр болон түүний туслах хоёрын царай сандарсандаа нов ногоон болоод явчихав. Юу болсон гэж бодно! Тэр нь иллэгний тос байжээ! Би нэг том аягаар уучихсан байдаг. Үхээгүй минь л аз болсон юм даг. Миний амьдрах чадвар асар их байсан байж таарна. Тэд хоёул зөвхий царайлаад,

айж сандарсан байсан ч надад хэлээгүй, би сүүлд олж мэдсэн юм. Тэгчихээд өдөр бүр ирээд л “Бие чинь зүгээр биз?” гэж асуухад нь би “Яагаа вэ? Би зөв зүгээр” гэж хариулна. (Багш инээв.) Гэхдээ яг тэр эмийг уухад надад хачин эвгүй санагдаж, бөөлжчихмөөр байсан ч зориглоогүй. Багшийн өгсөн эмийг бөөлжөөд гаргачихаж яаж болох вэ дээ? Би хэд дахин гулгиж, залгиж байж бүгдийг нь тогтоосон юм даг. Пүү, пай! Үнэхээр муухай! Наалдамхай, дарвигнасан халуун, гашуун амттай, тосорхог. Бүү үзэгд! Тийм муухай амттай эм хэзээ ч ууж үзээгүй. Нэлээн сүүлд би тэднийг надад буруу эм өгсөн гэдгийг олж мэдсэн. Тэгсэн ч би багшдаа эргэлзэлгүй хэсэгтээ л тэнд үргэлжлүүлэн суусан юм. Энгийн хүмүүс бол “Хэзээ тийм Гэгээрсэн Багш байдаг юм? Тийм байсан юм бол яахаараа чамд буруу эм өгч алахаа шахдаг юм?” гэх байсан. Харин надад эргэлзэх сэрдэх сэтгэл огт төрөөгүй юм даа!



Тийм эгэл, тийм тэнэг болохоор минь л намайг Эзэн Бурхан өрөвдөөд Үнэнийг эртхэн харуулж өгсөн болов уу. Надад нууц арга гэхээр юм тун цөөхөн бий. Бийгээс энэ маш энгийн хялбар аргууд л байна, бүгдийг нь би та нарт хэлээд өгчихсөн. Үнэнд хүрье гэвэл хүүхэд шиг ариун сэтгэлтэй байх ёстой, ямар ч зүйлийг цэвэр ариун, эгэл даруу сэтгэлээр үйлдвэл Үнэнд мөдхөн хүрнэ. Хэрэв та өөрөө ярвигтай хүн бол, зарга маргаан тун их хийдэг, зөв буруун тухайд хэтэрхий байнга боддог, хожил болоод ялагдлыг хэт ноцтой хүлээж авдаг бол Үнэнд хүрэх замаа удаан байна гэж намайг бүү буруутгаарай. Та өөрөө л өөрийгөө цөхрөөж байгаа шүү.

🌀 Бурханы Оронд байна гэж сана 🌀

Энэ дэлхий дээр үнэндээ тийм ноцтой зүйл гэж байхгүй. Эрт орой хэзээ нэгэн цагт бид нас нөхцөж, булш маань яах ийхийн зуургүй л ургамал ногоогоор хучигдах нь гарцаагүй. Тэгэхээр нас нөхцөхөөсөө өмнө бид аз жаргалтай амьдарч, дуртай зүйлээ хийж, түүндээ хамаг сэтгэлээ зориулан, дэлхий ертөнцдөө тусыг бүтээн, өөрийгөө болон гэр бүлээ асран халамжилж, энэ дэлхийн бидэнд хайрласан бүх сайн сайхныг эдлэн жаргахын тулд чадлаараа хичээн зүтгэх ёстой. Заримдаа бас муу муухай зүйлс ч бидэнд сургамж болдог, Тийм зүйлст ч мөн сайн сайхан тал бий. Арай илүүтэй гэгээрсэн байр сууринаас харахад аливаа юм бүхэнд гоо сайхан чанар байдаг юм. Мэлхийнүүд хэчнээн хөөрхөн болохыг анзаарсан уу, та нар? Тэд ёстой хөөрхөн, тийм биш гэж үү? Бид юм бүхнээс дур булаам



чанарыг нь олж хардаг. Муухай юмс ч сайн сайхан талтай, мөн бидэнд сургамж болж байдаг.

Тиймээс энэ дэлхийг Бурханы Оронд санаж, эргэн тойрныхоо хүмүүсийг Бурхад, гэгээнтнүүд гэж хандаж явахын тулд хамаг чадлаараа хичээцгээе. Тэд өөрсдийгөө тэгж бодохгүй байсан ч хамаагүй, тэднийг хүндэлсээр л, бид өөрсдөдөө яаж хандах вэ - тэр л маягаар хандаж, хатуу ч уучлангуй, хайрлавч сэтгэлийн хүлээсгүйгээр харьцах ёстой. Тэгж гэмээ нь бидний үйлдэл, үг яриа, сэтгэл санаа илүү тайван болно, үүнийг дадуулснаар бид аяндаа Үнэнд хүрнэ.

Адгаж яарах хэрэггүй, албадаж өөрийгөө хүчлэх ч хэрэггүй. Аль түвшинд хүрсэн бэ гэдэг чухал биш, учир нь хувь хүн бүрийн тухайд энэ өөр байдаг. Аажим аажмаар хүн бүр л ойлгож ухаарна. Та нар энэ дэлхийд эргэж ирж зовохгүй, тамд унахгүй, амьтны төрөл ч авахгүй, гарцаагүй дээшсээ явна гэдгийг л би амлах байна. Гагцхүү таны хүрэх



түвшин нь Үнэнийг хайсан эрэлдээ та хэр их итгэл, чин сэтгэлтэй хандаж буйгаас шалтгаалах болно. Та надад хариуцлагыг оноож болохгүй, би зөвхөн танд зааж замчилж л чадна. Хурдан удаан, зөв буруу зүг үрүү явах нь таны л сонголт.¹

¹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1991 оны 4 сарын 9, (Хятад хэлээр)



Бид бясалгал үйлдэхдээ чин сэтгэлтэй байх ёстой. Хамгийн сүүлчийн удаа бясалгаж буй мэт, маргааш эсвэл таван мөчийн дотор нас нөхцөх гэж буй мэт тийм чин сэтгэлтэй байх ёстой. Ийм сэтгэлээр бясалгалдаа ханддаг бол бид амжилтанд хүрнэ.

Багшдаа бүрэн итгэхүй

Би өөрийгөө бүхлээр нь -
үзэл бодол, үг хэл, үйл хөдлөлөө,
бүх амьдралаа - өнгөрсөн, одоо,
ирээдүйгээ Багшдаа даатгасан.
Тиймээс ч би нялх хүүхэд шиг
амар амгалан байв.



Гэнэн байсан минь л миний ганц нууц

Би өөрийнхөө оюун санааны бясалгал дадлагын нууцын тухай ярьж чадахгүй. Үнэн хэрэгтээ надад нууц гэж байхгүй. Миний ганц нууц гэвэл гэнэн зан минь л байх! Эзэн Бурхан гэнэн хүмүүсийг харж хандаж байдаг. Тийм хүмүүс хүүхэд шиг арчаагүй байдаг учир хүн бүр л тэднийг хамгаалахыг хүсдэг. Ганцаараа хаягдчихсан нялх хүүхдийг харахаараа бид эцэг эх нь биш хэдий ч хурдхан өргөж тэвэрдэг биз дээ. Уйлахыг нь хараад бид аргадна. Өлссөнийг нь мэдээд хооллоно. Нялх хүүхэд хэтэрхий гэнэн, бүтэлгүй болохоор л тэр шүү дээ. Тийм л болохоор хүн бүр түүнийг асарч хандах гэдэг.

Миний нууц гэвэл “гэнэн зан” минь л байх. Бид гэнэн цайлган байвал Эзэн Бурхан

биднийг харж хамгаална. Бид байнга л Түүний дэргэд байх болно, учир нь Тэр биднийг хэзээ ч орхихгүй. Бид ердөө л хэтэрхий гэнэн учраас тэр. Тэр биднийг орхичихвол бид үхчихнэ. Өөдөсхөн жаахан гэнэн хүүхдийг юу ч хийж чадахгүй болохоор нь бид 24 цагийн турш хажууд нь байж хамгаалж байдаг биз дээ. Хэрвээ бид нялх хүүхэд шиг бол байнга л Эзэн Бурхантай хамт байна. Бүх зүйлийг “томчууд” хийгээд өгнө.

Та нарт Үнэнийг дамжуулахдаа би Эзэн Бурханы хүчинд даатгадаг. Миний хийж буй бүх зүйлийг Эзэн Бурхан хийдэг, энэ эгэл хүний бие хийдэг юм биш. Ингэсэн нь ч найдвартай. Учир нь эгэл хүн алдаа хийж мэднэ, харин Эзэн Бурхан алдахгүй. “Билиг ухаант хүн тэнэг харагддаг” гэж ярьдагчлан бид тэгтлээ тэнэг байх юм бол Эзэн Бурхан биднийг анзаарахгүй байхын аргагүй. Тэр бүхнийг хийж өгнө, бид харин хэзээ ч алзахгүй, алдахгүй.



🌀 Багш минь бүхнийг харж байгаа 🌀

Шавь байхдаа би бусад шавь нар намайг үл ойлгох, гадуурхах үе гарахад тэднийг зүгээр л орхичихдог байв. “Багш минь бүхнийг харж мэдэж байгаа. Тэр учрыг нь олно биз” гэж боддогсон. Би асар их сүжигтэй байсан бөгөөд гомдоллож эсвэл тайлбар тавихыг оролддоггүй байлаа. Би өөрийгөө тэр чигт нь - үзэл бодол, үг хэл, үйл хөдлөлөө, бүх амьдрал - өнгөрсөн, одоо, ирээдүйгээ Багшдаа даатгасан. Тиймээс ч би дураараа юу ч хийхгүй, нялх хүүхэд шиг амар амгалан байв. Энэ л миний нууц байх. Үүрэг хариуцлага хүлээхгүй надад тун ч амар байлаа. Тийм болохоор надад гуних, санаа зовох юм ер гарахгүй тун ч тайван амьдарч байж. Би “Яагаад гэвэл миний Багш бүхнийг мэднэ. Тэр бол хамгийн агуу их багш” гэж боддог байв.



Одоо болтол харамсах зүйл надад ер
гараагүй. Урьд өмнө нь хамаг зүйлийг Багш



зохицуулна гэж даатгачихаад бүх юм төгс сайхан байсан. Сэтгэл зүрхэндээ би Багш минь намайг хамгаална гэдгийг мэдэж байсан учир гомдоллоод байх юм ер байгаагүй. Миний ганц нууц юу вэ гэвэл: Бүрэн итгэл. Хэрэв та нар надад итгэхгүй байгаа бол хамгийн дээд Эзэн, Оройн Дээд Бурханд итгэх хэрэгтэй. Тэр хамаг амьтны үйл амьдралыг харж болгоож байдаг тул бүхнийг зохицуулна. Үнэхээр тэгнэ шүү! ²

² Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, зургаа хоногийн дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1989 оны хоёрдугаар сарын 13-наас 18, (Хятад хэлээр)



Гэгээрсэн Багш бидний хаана нь доголдол буйг хармагцаа таньж, хатуу зөөлөн аль аргаар хэрхэн яаж засч залруулахаа тэр дор нь мэддэг. Иймд бид аливаа Багшийг оюун санааны хөгжлийнхөө төлөө шүтэх аваас Түүний зааварчилгааг хүндэтгэн дагаж, бие, хэл, сэтгэлээ Түүнд бүрэн өргөвөл зохино. Өөрийгөө хагас зориулчихаад үр дүнд хүрсэнгүй гэж Багшийг буруутгах хэрэггүй. Хагас хугасыг хүсвэл Багш бидэнд хагас хугасханыг л хүртээнэ. Бүгдийг хүсвэл бүгдийг өгнө.



Багшийнхаа тухай бодсоноор та Багштайгаа нэг болж, Багш бол та өөрөө юм гэдгийг ойлгоно. Багш гэдэг бол таны жинхэнэ Мөн Чанар юм. Гэвч одоохондоо та үүнийг ойлгоогүй тул яаж ч чадахгүй Багшийг бодож байна. Энэ чинь та өөрөө шүү дээ. Багшийг бодох замаар аажмаар Багшийн тань бүх чанарууд танд дамжин ирж, Багшаараа дамжуулан та Мөн Чанараа таньж олно. Тэгээд хожим нь "Өө, Багш би өөрөө юм байна. Би өөрөө л байсан байна шүү дээ" гэж ухаардаг. Тиймээс ч хүмүүс эрт дээр үеэс эхлэн мэргэн ухаантнууд, Гэгээрсэн Багш нарыг тэдний биш өөрсдийнхөө тусын тулд шүтдэг байжээ.

Дияаны үед сэтгэлийн уяагүй төвлөр

Учир нь хэрэв та энэ дэлхийн хувьд
үхсэн мэт биш бол Эзэн Бурханы хувьд
амьд байх аргагүй. Иймд бид нэгэн
үзүүрт сэтгэлийг барих нь зүйтэй. Энэ
дияаны турш миний хийж буй бүхэн та
нарыг хамгаалж, тэрхүү ганц зорилго
өөд хөтлөхийн төлөө юм.



∞ Дияаны үед сэтгэлийн уяагүй төвлөр ∞

Дэвшсэн хүмүүст баяр хүргэе. Та нар чадах бүхнээ хийлээ. Та нар маш олон зүйлийг огоорч хаясан. Тэгж байж л та нар дэвшлээ шүү дээ. Дэвшээгүй хүмүүсийн хувьд: та нар дэвших нь дэвшсэн, гэхдээ хэтэрхий бага ахицтай байна.

Та нар “Багш аа, би яаж хурдан дэвших вэ?” гэж байнга асууж, үргэлж л үүнийг хүсч байдаг. Яаж үтэр түргэн дэвших вэ гэсэн асуултанд би “Хамаг юмаа хая, бүхнийг хая” гэж хэлдэг ч та нар тэгдэггүй. Та нар энд өч төчнөөн найз нөхөд, хамаатан садан, үр хүүхдээ (сэтгэлдээ тээн) чирээд ирдэг. Та нар чинь тэдэнтэйгээ амьдралынхаа туршид, өдөржин шөнөжин хамт байдаг, харин энд

ердөө энэ л тавхан
 өдрийг Эзэн Бурханд
 зориулах гэж ирсэн
 баймаар. Гэтэл үгүй
 юм аа. Энэ Залууг
 та нар хоёрдугаар
 зэрэгт л тавиад
 байх юм. Иймдээ
 ч та нар дэвшихгүй
 байна. Цорын ганц
 нууц бол бүхнийг
 огоорч орхих юм
 шүү дээ. Эзэн Бурхан
 бүхнийг зохицуулна.



Бидэнд хийж чадах юм
 гэж ер байхгүй. Эзэн Бурханы а в р а л
 энэрэл гэж байдаггүйсэн бол бид юу ч хийж
 чадахгүй. Мэдээж, та нар энд ирчихээд намайг
 хувь тавиланд чинь хутгалдахыг гуйдаг. Заримдаа
 би Эзэн Бурханаас үүнийг гуйж болно. Гэтэл
 энэ чинь миний асуудал биш шүү дээ. Би хэрэгт



чинь оролцож, та нарын төлөө юу ч хийсэн болохоор байна. Гэтэл энэ та нарын асуудал биз дээ. Та нар энд ердөө энүүхнийг л хүсч ирсэн бол түүнийгээ л авна. Хүү чинь дээрдэж, охин чинь гайгүй хүнтэй гэрлэж мэднэ, та нарт олдох юм чинь ердөө л тэр. Харин хамаг нандин эрдэнэсээ та нар орхичихлоо гэсэн үг. Ингэдэг чинь харамсалтай.

Тийм ч учраас би та нарыг янз бүрийн, тэр байтугай бүр үл ялих өдөр тутмын амьдралын юм асуухад чинь түвэгшээхгүй хариулж байдаг. Би та нарт аль ч талаар тусалж чадна. Гэвч та нар өрөвдөлтэй байна. Энд ердөө тавхан хоногоор ирчихээд Эзэн Бурханыг бүр дурсдаг ч үгүй.

Ердөө ганц удаа ч атугай та нар Түүнийг гэж, зөвхөн Эзэн Бурханыг л гэж энд зорьж ирэх хэрэгтэй! Гэтэл тэгдэггүй, та нар энд дандаа л элдэв шалтаг тоочихыг оролдон, янз бүрийн тус дэм гуйх гэж ирдэг. Иймэрхүү тус дэмийг та нар гэртээ байхдаа гуйж байх ёстой юм шүү

дээ. Нээрэн шүү, би та нарт хэлж байна: Эзэн Бурхан болоод Их Багшийн хүчинд залбирах тоолонд түүнийг чинь сонсож л байгаа. Бид ямар дүлий биш! Биднийг та нар дүлий гэж бодоогүй л баймаар юм. (Хүмүүс алга ташив.)

Мөн “би” энд суучихаад (Багш өөр лүүгээ заав.) би өвчтэй, би ядарч байна, би өчүүхэн, би том, би ийм, би тийм гээд сууж байна гэж та нар боддоггүй байх гэж найдаж байна. Үгүй шүү дээ, үгүй! Энэ чинь би биш, би энэ хүн биш. Бид дүлий биш, бид мулгуу биш, бид сохор биш, бид тэнэг ч биш. Тиймээс энд ирж гэр бүлийнхээ болоод найз нарынхаа тухай, өөрийнхөө асуудал, азгүй явдлын тухай гомдоллох гэсний хэрэггүй. Болох л доо, та нар юугаа ч ярьсан хамаагүй. Мэдээж, та нар намайг ээжийгээ, найзыгаа гэж бодож зовлон зүдгүүрээ хуваалцъя гэвэл болж л байна. Гэхдээ энэ бүхэн чинь зөвхөн хоёрдугаар зэргийн асуудал гэдгийг л санаарай.



Дияан болох бүрт саад болох юмгүй, гэр бүл найз нөхдийн зүгээс нэхэл суралгүй, хийх ажил бизнесгүй, дарга, хамтран ажиллагсад тань ч байхгүй, эхнэр нөхөр ч байхгүй - бид салгаад байрлуулчихаж байгаа болохоор - хүүхэд шуухад хэрүүл уруул гэх юмгүй байгаа энэ л цаг боломжийг ашиглах ёстой юм шүү дээ. Төвлөрөх хэрэгтэй. Энэ дияаны дараа л яг үхэх гэж байгаа юм шиг энд буй цагаа нандигнах хэрэгтэй. Тэгж чадвал та нар гэр бүлийнхээ тухайд санаа зовох аргагүй болно, та нар тэднийгээ орхих л байсан биз дээ! Үхэж байгаа хүн гэр бүлдээ зовоод байх боломж гарах уу? Гарахгүй! Та нар намайг маргааш амьд байх эсэхийг ч мэдэхгүй, тав хоногийн дараа би энэ дияаныг удирдаад сууж байх уу гэдгийг бүр ч мэдэх аргагүй. Тэгэхээр та нар үнэхээр тэнэг л байна даа.

Дэвшихгүй байгаа нөхөд үнэхээр ухаан муутай байна. Дияанд ирэх тоолонд чинь бид та

нарыг ганц л Хүн дээр төвлөр гэдэг: ганц Нөхөр, ганц Эхнэр. Үүнийг л үнэнч сэтгэл гэдэг юм. Энэ дэлхий дээрх ханьдаа үнэнч байх тухай би яриагүй байна. Та нар Бурханы Оронд байгаа Ханьдаа үнэнч байх ёстой юм шүү дээ. Энэ л хамгийн чухал. Учир нь энэ дэлхий дээрх эхнэр нөхрүүд та нарыг хэзээ ч орхиод явчихаж чадна. Царай зүс чинь доройтоод, өвчтэй, хөгшин болохоор чинь эсвэл тэр аль нэг илүү дээр хүнтэй нийлээд, эсвэл үйлийн үрийн холбоо тань сулраад, тэр чинь урьд төрлөөс барилдлагатай хэн нэгэнтэй таарчихаад, тэр хүн нь илүү санагдвал та өнгөрөх нь тэр. Бурханы Орон дахь Хань маань харин биднийг хэзээ ч орхихгүй. Бид гэтэл тун ч үнэнч биш байдаг нь муу хэрэг. Ямар ч атугай, дэвшээгүй нэг хэсэг чинь энэ удаагаас сургамж авсан байх гэж найдаж байна. Хэзээ ч юм, бид дахиад дияан зохион байгуулбал тэр боломжийг ашиглахыг хичээгээрэй, за юу? (Хүмүүс алга ташив.)



Би та нараас болж уурласан юм алга, цөхөрсөн ч юм алга. Би яагаа ч үгүй байна. Тухайн үед хийх ёстой юмаа л хийж байна. Тиймээс мэдэрч буй хорон муу бүхнээ одоохон над уруу буцаачих. Гэртээ харихаараа та нар эрх чөлөөтэй болно. Нөгөө төгс сайхан хэн байсан тэр хэвээрээ л байна. Харин энд байх хугацаанд чинь би та нарыг засч залруулж, ариусгаж угаахаас өөр аргагүй. Энэ үйл явц заримдаа хэн хэнд маань нэлээн шаналгаатай байх нь бий. Гэхдээ зүгээр ээ. Тав хоногийн эцэст энд болж буй сайн муу бүх зүйл дуусгавар болно. (Хүмүүс алга ташив.)

Та нар төгс төгөлдөр, бусдаар хүсэмжлэгдэн хайрлагддаг хүмүүс, дияаны үед ч тийм хэвээрээ. Гэхдээ ийм маягийн эмчилгээг та нарт хайргүй, дургүй байгаагийнх гэж санадаг. Тийм биш ээ. Энэ бол ердөө тухайн үед тэр эмийг өгөх шаардлагатай байсан л гэсэн үг. Иймд хэрэгцээгүй гэснээ буцааж, яг энд үлдээчихээд

гэртээ эрх чөлөөтэй харьцгаа. Дэвшиж гавьсангүй хэдий ч та нар урьдын адил төгс төгөлдөр хэвээрээ. Та нар өөрсдийнхөө зардлаар өөр сургамж авлаа гэсэн үг. Мөнгөний тал дээр ч бас. (Багш болон бусад бүх хүн инээв). Энд асар их зардал гаргаж ирчихээд юу юу ч үгүй буцлаа гэсэн үг л дээ.³

³ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, зул сарын таван өдрийн дияан, Флорида, АНУ, 2002 оны арван хоёрдугаар сарын 28 (Англи хэлээр)



❧ Бүхнийг огоорч чөлөөтэй бай ❧

Бид дээд хэмжээст очвол, тоолж баршгүй болон ертөнцөд юм бүхэн нь хөөс адил хормын өчүүхэн хэсэгт үүсэн бүрэлдэж, үгүй болохыг олж хардаг! Хормын зуур болж өнгөрлөө ч гэж хэлэх аргагүй. Юмс зөвхөн үзэгдэх төдийхнөөр л алга болно. Дээд хэмжээсүүдэд бидний олж үздэг хуурмаг ертөнцүүд бүгд мөн адил байдаг.

Бид урт хугацааны явцад, үе үеийн турш зовлон туулсан мэт санагддаг нь мунхаглалаас болжээ. Бид орон зай, цаг хугацааны урхи торонд баригдчихсанаас болж цаг хугацаа урт удаан мэт санагдаж байгаа юм. Бодит байдал дээр энэ тийм ч удаан биш юм. Бурханы хувьд энэ нь нэг секундээс ч бага буюу хормын өчүүхэн нэг хэсгээс ч богино. Цаг хугацаа гэхийн ч аргагүй, үнэхээр үтэр түргэн болж өнгөрдөг. Гэтэл та нар нэг буланд гацчихсанаасаа болж



ерөнхий зургийг бүхэлд нь харж чадалгүй өөрийгөө зөвхөн тэрүүхэн тэндээ л байна гэж бодоцгоодог. Энэ тийм биш, та нар хаа сайгүй оршиж байгаа. Та нар ердөө л нэг газраа гагцчихаад гарч чадахгүй байгаа хэрэг. Тэгээд өөрийгөө тэндхийн тэр хүн, эндхийн энэ хүн гэж боддог.



Заримдаа өчүүхэн шувууд эсвэл шавьж цонхон дээр маань гацчихаад, цонхны шил тунгалаг бөгөөд өрөө гэрэлтэй болохоор, цонх байгаа гэдгийг ойлгохгүй шил мөргөдөг. Тэгсээр толгой нь хавдаж, нүд нь харанхуйлаад хэсэг зуур ухаан алдан газар унана. Тэд нээлттэй газраар нь нэвтрэлгүй яг цонх уруу чиглэн нисэцгээдэг.

Бид үүнтэй эгээ л адил авирлаж байдаг юм. Бид аливаа бүхнийг, бүр аз жаргалыг ч огоорох хэрэгтэй, тэгвэл л болоод явчихна. Бид амар амгалан, эрүүл мэнд, амжилт, нэр хүнд, эд хөрөнгө, гэр бүлийн алиныг нь ч горилон хүсэмжлэх хэрэггүй. Ер нь юу ч гуйж хүсэмжлэхгүй байвал зохино. Ингэвэл бид зовохгүй. Бид хэтэрхий их зүйл хүссэнээсээ болж л энд тэнд гацаж, тэндээ хамраасаа дөрлүүлчихдэг. Тэгчихээд аврал эрж хашхирна. ⁴

⁴Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгал, Шихү, Формоса 1990 оны есдүгээр сарын 28-с аравдугаар сарын 3 (Хятад хэлээр)

Оюун санааны хөтөч Багш нарын дэргэд байхын ач тус

Заримдаа тэдний ойр байх төдийд л
бидэнд их таатай санагдан,
ертөнцийн хэрэг явдлын тухайд дахин
бодохоо болихын тулд бясалгах хүсэл
эрмэлзэл төрдөг.



❧ **Боломж олдвол Багшаа өдөр бүр хар** ❧

Бясалгал дадлаа мартчихгүйн тулд бидэнд оюун санааны бясалгал дадлын ач тусыг сануулж байх хэн нэгэн хүн хэрэгтэй байдаг юм. Эс тэгвээс бид өдөр тутам ертөнцийн жирийн төрөлтнүүд буюу тийм ч өндөр бус дэсийн хүмүүстэй харьцдаг учир бясалгалгүй тэдний гэрлэн бие бидний түвшинг бага багаар доош татан, улмаар бид тэдний нэгэн адил хорвоогийн ердийн ажил хэрэгт автсан завгүй нэгэн болж, хамгийн чухал зорилгоо умартдаг.

Тиймээс ч оюун санааны багш нар, Гэгээнтнүүдтэй хамт байх нь үнэхээр тустай юм. Энэ нь номын ахан дүүс болон Гэгээрсэн Багшийнхаа хүрээлэлд байх нь чухал гэсэн үг. Зөвхөн тэдэнтэй уулзаж, яриаг нь сонсож байгаа учраас л чухал байгаа юм биш. Тэдний яриаг сонсохгүй байсан тохиолдолд ч, тэдний



оюунлаг гэрлэн бие нь бидэнд сануулагч болж, оюун санааны урам зориг хайрладаг. Тэгэхээр бид оюун санааны дадал бясалгалынхаа талаар аяндаа бодно. Заримдаа тэдний ойр байх төдийд л бидэнд их таатай санагдан, ертөнцийн хэрэг явдлын тухайд дахин бодохоо болихын тулд бясалгах хүсэл төрдөг.



Тиймээс ч Энэтхэгт хэрэв боломжтой бол өдөр бүр, эс бол ядахдаа хоёр гурав хоног тутамд Багшийгаа хар гэдэг билээ. Хэрэв ингэх боломжгүй бол ядахдаа долоо хоногт нэг удаа, бүр боломжгүй бол ядахдаа хоёр долоо хоногт нэг удаа, хэрэв үгүй бол сард нэг удаа хараарай. Ингэх ч аргагүй бол хэдэн сард нэг удаа, чадахгүй бол жилд нэг удаа харахыг хичээ. Хэрэв энэ нь бас л боломжгүй байвал амьдралдаа ядаж л ганц удаа харахыг хичээгээрэй. Хэрэв огт боломжгүй бол та үхэх үедээ Багштайгаа уулзах нь лав. Тэр цагт Багш тань таныг авахаар ирэх нь гарцаагүй. Тийм болохоор эцэстээ та Түүнтэй уулзах л болно. Гэвч Багш бидэн дээр ирэхийн тулд бид Түүнтэй барилдлагатай байх ёстой.

Тийм ч учраас “Бурхантай уулзах хялбаргүй” гэсэн яриа байдаг. Бид Багштай нэг гариг дэлхийд, эсвэл нэг эрин үед амьдарсны зоргоор Түүнийг харж, сургаалыг нь заавал сонсдог юм биш. Бид Багштай нас чацуу, эсвэл

нэгэн улс оронд, нэг хот сууринд амьдардаг байлаа гээд Түүний адислалыг авна гэсэн ч үг биш. Яагаад гэвэл зарим хүний зүрх сэтгэл хаалттай байдаг. Сэтгэл маш чухал шүү!

Тиймээс ч Багштайгаа уулзах боломжгүй, Багшийнхаа биеийг хэзээ ч хараагүй зарим хүмүүс, жишээлбэл Хятад болон Ау-Лакийн номын ахан дүүс дотооддоо Их Багшийн Гэрлэн хувилгаан дүрийг олж үзжээ. Учир нь тэд Багштайгаа зүрх сэтгэлээрээ хамт байдаг юм. Энэ мөн л оюун санаа хөгжиж буй хэрэг. Зүрх сэтгэл тун чухал!⁵

⁵ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1992 оны арвдугаар сарын 10 (Хятад хэлээр)



🌀 Зүдрэлгүйгээр бясалгахуй 🌀

■ Хүн Гэгээрэхийн тулд хэр удаан хугацааны турш бясалгах ёстой вэ?

Б: Гэгээрэл даруй ирдэг. Та Их Багшийн хамт суун, гэгээрлийг чин сэтгэлээсээ хүссэн даруйд гэгээрэл ирнэ. Заримдаа бүр авшгийн өмнө, эсвэл намайг зааварчилгаагаа хараахан хэлж дуусаагүй байхад хүмүүс хэдийн гэгээрлийг хүртдэг. Зарим хүмүүс их яаруу, тэдэнд хүлээх цаг байдаггүй. (Инээлдэв.)

Гэхдээ бид гэгээрсэн байдалдаа үргэлж байж, гэгээрлийн ойлголтоо байнга шинэчилж байхыг хүсдэг тул өдөр бүр бясалгадаг юм. Бид бас гэгээрлээ батжуулан, хязгааргүйд хүртэл тэлэхийг хүсдэг. Гэхдээ бүтэн зуун жил бясалгаад ч хүн гэгээрэхгүй.

Бясалгалаар бус, Их Багшийн Хүчээр гэгээрдэг. Авшгийн үед ч тэр, ер нь манай энэ аргаар хичээллэж байгаа хүн бясалгадаггүй. Учир нь бясалгана гэдэг хөдөлмөрлөнө гэсэн үг. Харин манай аргаар хичээллэхэд хөдөлмөрлөх хэрэггүй. Заримдаа та тэнд нойрмоглож суух үед ч гэгээрэл ирэх нь бий. Эсвэл та унтаж байхдаа гэгээрнэ. Учир нь Их Багшийн хүч таныг сэрээж, унтах зуур сүнсийг тань хөгжүүлнэ. Сэтгэл тань унтаж, бие тань амарч байх зуур Гэрэл болоод билиг ухааны ертөнцийг сүнс тань таньж мэднэ.

Иймд бясалгал бол уг нь гэгээрэх арга хэрэгсэл биш юм. Даанч энэ ертөнцийн үг хэл дутагдалтайгаас болж бид энэ аргаа бясалгал гэж нэрлэдэг. Мөн чанартаа бол та зүгээр л сууж байгаад Эзэн Бурханы адислалыг хүлээн авч, мөн өөрийн төгс дээд хүчээ танин мэдэж байгаа хэрэг юм. Угтаа



бол үүнд ямар ч бясалгал оролцдоггүй. Учир нь энэ дэлхий дээрх хөдөлмөрийн үр дүн буюу аливаа нэг үйлдлийн үр дүн нь зөвхөн дэлхий ертөнцийн бүтээгдэхүүн байх бөгөөд



Эзэн Бурханы сайн сайхан, агуу их хүч болон өөрсдийн өдөр тутмын бясалгалын тусламжтайгаар бид сэтгэл санаа, сүнс оюунд хор нөлөөтэй ямар ч мэдээллийг саармагжуулах, магадгүй бүр мөсөн арилгах боломжтой.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Оюунлагийг дадуулна гэдэг хамаг баяр цэнгэлээс татгалзана гэсэн үг биш. Энэ бол буруу үзэл. Хэрэв бид тийнхүү хэт туйлширч, хэт чухал загнаж байгаа бол оюун санааны дадал бясалгалын утга учрыг буруу ойлгож байна гэсэн үг. Эзэн Бурхан энэ бүх зүйлсийг бидний ойг гутаах гэж бүтээгээгүй. Харин биднийг тав тухтай байлгаж, Үнэнд итгэх итгэлийг маань улам хүчтэй болгох гэж бүтээсэн юм.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ~



материаллаг ертөнцийн хүрээнд л оршино.
Тиймээс бидний бясалгал бол бясалгахгүй
бясалгал, энэ бол зүдрэлгүй бясалгах арга юм. ⁶

⁶ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Сиагл, АНУ, 1993 оны дөрөвдүгээр сарын 7 (Англи хэлээр)



Сайн сайхан зүйлийн талаар бидэнтэй өдөр бүр ярилцан зөв чигт явахад маань биднийг итгүүлж чадах буянтай, сайн санаатай, хүнлэг найз нөхөдтэй байх чухал. Тэгвээс бид зөв замаараа замнан улам бүр сайжирч, сайн чанарууд маань тодрон гарч хөгжсөөр бүр илт болно. Аль зүгт хандах нь зөв болохыг бид илүү сайн мэддэг болно.

Төлөв даруу байдал Үнэн Ёсонд ойр

Даруу төлөв хүмүүс Бурхан болоод
Гэгээнтнүүдэд тун ойр. Цэвэр ариун
сэтгэлтнүүд Үнэн Ёсонд илүү ойр.

Бардам байхын хэрээр бид
Үнэн Ёсноос холддог.



❧ Нам жим бясалгахуй ❧

Оюун санааны дадал бясалгалд олон түвшин байх агаад гэгээрлийн зам мөрт удаан. Тиймээс шинэ бясалгагч бардамнан сайрхах хэрэггүй. Ахуй ойлголтоо бусдад бүү илчил гэж миний хэлдэг нь миний тусын тулд бус та нарын төлөө юм. Хэрэв хүсвэл орон даяар зарласан ч болно. Надад нөлөөлөхгүй. Өөрийн эрдэнэсээ илчилснээр зөвхөн та өөртөө л зовлон удна.

Тиймээс нам жим бясалга. Учир нь бид өөрийн түвшинг хамгаалж, аажмаар өсөн дэвшсээр, Бурхад, Махасатва, дээд Бодисатва нарын (гэгээрсэн төрөлтнүүд) дэсэд хүрэх хэрэгтэй. Хэрвээ хэн нэг ид шидийн хүчтэй шинэхэн бясалгагч дотооддоо тогтворгүйгээс болж өөрийгөө сурталчлан зарлаж байгаа бол

энэ мэт хүмүүс найдваргүй гэдгийг та нар ойлгох хэрэгтэй.

Ийм хүнийг харсан өндөр дэсийн бясалгагч хэн боловч, түүнд барцад тулгарч –бидний олонтаа дурддаг “Зэн шинж тэмдэг”-ээр өвчилсөн болохыг таньж чадна. Зэн шинж тэмдгээр өвчлөөгүй хүмүүс гадуур тэгж сайрхдаггүй.

Оюун санааны бясалгал дадалтнууд даруу төлөв байх ёстой. Тэдний түвшин өндөр болох тусам тэд илүү энгийн даруу байж, дэс болоод хүчийг нь хүмүүс илрүүлэхээс болгоомжилж байдаг.

Зарим хүмүүс бясалгаж эхлэх үедээ зүгээр байснаа ялимгүй дэвшиж, ахуй ойлголттой болмогцоо хаа сайгүй сайрхаж явдаг. Тэд их ярьснаасаа болж хор хөнөөлтэй олон саад тотгорт орооцолдох нь бий. Түвшин өндөр болох тусам



учрах саад тотгор нь илүү хор нөлөөтэй байдаг.

Тиймээс оюунлагийн бясалгал дахь хамгийн ноцтой алдаа бол өөрийн ахуй ойлголтын талаар бусдад ярих явдал мөн. Хүн хэт их яриваас ахуй ойлголт нь гажиж эсвэл дахин хялбар ирэхээ больж зөвхөн хий хуурмаг л үлдэнэ. Учир нь төвлөрлийн хүч үрэгдэж, оюун санааны орчин нь гэмтдэг. Угтаа бол оюун санааны орчин гэдэг нь хамгаалалтын хана юм. Гэтэл хүн гадагшаа хэт их гоожуулж ярьснаас чөтгөр түүнийг нүхлэн дотор нь ордог. Бид оюун санааны бясалгал дадалдаа сагсуурах болон бардамнахаас болгоомжилдог юм. Бардам байх тусам илүү их асуудал бэрхшээлтэй тулгарах болно.⁷

⁷ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Тайпэй, Формоса, 1986 оны арванхоёрдугаар сарын 17, (Хятад хэлээр)

❧ Амжилтандаа бардсан хүн амьдралаа сүйтгэнэ ❧

Авшгийн үед би та нарт хэлж байсанчлан, чин сэтгэлтэй боловч хянамгай бус, сэрэмж болгоомж муутай бясалгагчдыг төөрөгдүүлэхийн тулд Хий Хуурмагийн Хаан, Маяагийн Эзэн эсвэл чөтгөр өөрөө, Бурхан Багш, чөтгөр, сахиулсан тэнгэр, Эзэн Бурхан эсвэл өнгөрсөн, одоо, ирээдүйн аль нэг гэгээнтний дүрд хэзээ ч хамаагүй хувиран ирдэг. Чөтгөр бясалгагчдыг отоож замаас нь төөрүүлэхдээ тавин төрлийн урхи зангыг олонтаа ашигладаг тухай Бурханы шашны сударт дурдсан байдаг. Чөтгөрийн тухай элдэв олон юм мэдэх шаардлагагүй. Ердөө л цэвэр ариун, чин сэтгэлтэй бас өөртөө үнэнч байвал та хэзээ ч ямар ч урхи занганд унахгүй, ямар ч бэрхшээлтэй цагт хэн ч, хэзээ ч, тэр бүү хэл чөтгөрийн хаан өөрөө ч таныг мэхэлж чадахгүй.



Нэр хүнд, ашиг хонжоо, дээгүүр албан тушаалд шунаваас оюун санааны ертөнцөд ч ялгаагүй бид сөрөг хүчний урхи занганд байнга унах болно. Учир нь тэд үүнийг л хүсэн хүлээж байдаг юм. Тэд бидний сонор сэрэмжээ алдах мөчийг отож байгаад дараа нь биднийг мунхруулж, биднийг аль хэдийн Бурхан болчихсон гэх буюу, агуу их хүмүүс, бидэнд үүрэг даалгавар бий, бид бол энэ тэр чухал хүн гэдэгт итгүүлнэ. Тэгээд бид омог бардам болдог. Хуурамч бахархал, ихэмсэг зангийн занганд урхидуулсан бид тэгээд л дуусдаг. Магадгүй бид даруу төлөв байдалдаа эргэн ирж, урьдын адил бясалгалаа үргэлжлүүлж болох ч ингэх нь их хүнд байж мэднэ. Бид бүр хол төөрөөд явчихсан байж болох тул буцаж ирэхэд их хугацаа зарцуулна. Маш их хичээл зүтгэл, цаг заваа бид ингэж дэмий гарздах нь бий. Тиймээс бясалгагч хүний хувьд бид анхаарал болгоомжгүй байх, бясалгалаараа бардамнах, оюун санааны ертөнцөд байр суурь түргэн эзлэхийг хүсэх нь байж болохгүй зүйл юм.

Сахилаа тийм ч сайн сахидаггүй, цагаан хоол нь ч нэг тиймэрхүү хэрнээ жаахан бясалгачихаад, төөрөгдүүлсэн хэдхэн ахуй ойлголтоос болж өөрсдийгөө Их Багш, Бурхан боллоо гээд итгэчихдэг хүмүүс олон бий.

Та хэн байхыг хүснэ, түүндээ хүрэх эрхтэй. Та ололт амжилтаараа сайрхаж болох ч, үр дагавар нь харуулаад өгнө. Энэ нь зарим тохиолдолд амьдралыг маань сүйтгэх нь ч бий. Бид өөрсдийгөө баллаж, урьд байсандаа буцаж очъё ч гэсэн чадахааргүй хэт оройтсон байдалд орно. Тиймээс оюун санааны дадал бясалгалд даруу төлөв байдал маш чухал. Бид зөвхөн гаднаа даруу загнаад зогсохгүй дотроо ч даруу байх ёстой. Зарим хүн тийм ч даруу загнадаггүй ч дотроо даруу байдаг. Зарим нэг хүн даруу дүр эсгэдэг ч үнэн хэрэгтээ дотроо маш их бардам байдаг. Гадна төрх байдал хүмүүсийг төөрөгдүүлдэх нь бий.⁸

⁸ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын дөрөв хоногийн дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1996 оны хоёрдугаар сарын 20 (Англи хэлээр)



🌀 Лин Чи Багшийн тухай түүх 🌀

Хятадын Их Багш Лин-Чи-гийн тухай бас нэгэн түүх бий. Их Багш Лин-Чи шавь байхдаа үргэлж унтаж байдаг байжээ. Тэр хаа ч байсан унтаж л байдаг байв. Нэг өдөр тэр бясалгалын танхимын буланд унтаж байгаад Багшийгаа орж ирэхийг харжээ. Тэгээд айсан дүр үзүүлэн, олбог, хөнжлөө авч өөр нэг буланд очоод дахин унтажээ. Багш нь Лин-Чиг мэддэг байв. Үнэндээ тэд бие биеэ маш сайн мэддэг байж. Тэгтэл Багш бясалгалын танхим дундуур шулуухан явж бясалгаж суусан нэгэн хуврагийг өшиглөн “Унтамхай шавь бэ, чи! Ямар дүр эсгээд байна вэ? Чи тэнд байгаа Лин-Чи шиг яаж бясалгахад суралцвал таарна” гэжээ. (Бүгд инээлдэв.)

Нөгөө хувраг бүр чихэндээ итгэсэнгүй. Та нар тэр хуврагийг уг нь яаж сууж байсан гэж бодно? Нөмрөгтэйгөө, ёс журмыг сахиад Бурхан

Багшийн баримлын өмнө сууж байсан хэрнээ л тэр өгзөг үрүүгээ өшиглүүлжээ. (Бүгд инээлдэв.) Урдаа нэг хүж тавьчихаад уугиж дуустал нь тэр огтхон ч хөдлөөгүй. Гэхдээ сэтгэлдээ бол хөдлөөд байжээ. Тиймээс хөнжилдөө унтаж байсан Лин-Чиг бясалгасан, харин сууж байсан ламыг унтлаа гэсэн аж. Ойлгож байна уу? Дэс өөр байж шүү дээ.

Тийм ээ, Лин-Чи унтдаг байсан, гэхдээ хэзээ ч унтаж байгаагүй. Түүний бие унтаж байсан ч сэтгэл нь цаг ямагт гэрэлтэж байлаа. Тэр юу ч хийж байсан үргэлж дотоод Мөн Чанар дээрээ төвлөрдөг байв. Хэзээ ч төвлөрлөөс гарч байсангүй. Харин модон хавтан мэт сууж байсан нөгөө хуврагийн бодол нь зүг бүрт хэсүүчлэн тэнэхэд тэр яаж ч чадахгүй байлаа. Тиймээс өөрөө төвлөрөлтэй байхыг хичээж, бусдыг гадаад байдлаар нь шүүмжлэх хэрэггүй.⁹

⁹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Коста-Рика, 1991 оны зургадугаар сарын 2 (Англи хэлээр)



❧ **Омог бардам байхын хэрээр** **Үнэн Ёсноос холдоно** ❧

Даруу төлөв хүн Бурхан болоод Гэгээнтэнд тун ойр, Цэвэр ариун сэтгэлтэн Үнэн Ёсонд ойрхон байдаг. Бардам байхын хэрээр бид Үнэн Ёсноос холддог. Бид яагаад Үнэн Ёсноос ийм хол байна вэ? Учир нь бид материаллаг ертөнцөд найддаг. Хэрэв материаллаг ертөнцөд найддаггүй байсан бол бид ийм бардам байхгүйсэн. Бид мөнгө, эрх мэдэл, оюун ухаан эсвэл нийгэмд эзлэх байр суурьтаа найдаж тэдгээрээс хамаарч байгаа бол материаллаг ертөнц ба мөнх бус зүйлд найдаж байгаа хэрэг. Үнэн Ёс гэдэг энэ ертөнцөд харьяалагддаг ч юм биш, мөн мөнх бус ч биш. Тиймээс инагуухи ертөнцөөс хэдий чинээ хамаарна, чанагуухи ертөнцөөс төдий чинээ

холдох болно. Энэ бол учир зүйд нийцэх тайлбар бөгөөд ойлгоход тийм төвөгтэй байж таарахгүй.

Мөнгө, эрх мэдэлгүй харах, хандах хүнгүй өндөр настнууд илүүтэй даруухан байдаг. Тиймээс би тэдгээр хүмүүс болон шоронгийн хоригдлуудад их сайн ханддаг юм. Харин та нарт заримдаа тийм ч сайн ханддаггүй. Үүндээ хүлцэл өчье. Гэвч байдал ийм л байна. Би тэдэнд зориуд сайн, та нарт албаар муу хандаж байгаа хэрэг биш. Би ердөө л та нарын байгаа байдлын тусгал юм. Иймд миний та нарт хэрхэн хандаж байгааг буруутган, “Багш яагаад тэр хүнд тийм сайн хэрнээ, надад ингэж хандана вэ?” гэж харьцуулах хэрэггүй. Хэрэв би хэн нэгэн хүнд сайн байвал та нар тэр хүнийг зүгээр л нэг харчихаарай, яагаад гэдгийг нь та нар тэгээд мэдэх болно. Тэр заавал танаас царайлаг байх албагүй. Үгүй шүү. Магадгүй огт шүдгүй, ганц ч садан төрөл, найз нөхөр байхгүй, сохор зоосгүй, би бүр түүнд



мөнгө өгч байж ч мэднэ. Гэвч түүний зүрх сэтгэл нь цэвэр ариун, бас даруу учраас л би түүнд сайн байгаа хэрэг. Түүний зан нь эвдрээгүй. Мөн юунд ч хаагдаж боогдохгүй, ямар нэг зүйлд хүлэгдэж найдах юмгүй. Түүний зүрх сэтгэл хязгааргүй уужим, тэрбээр орчлон ертөнцтэй бараг нэгдмэл.

Бид ганц нэг зүйлд найдаж түүнээс хамаарвал, зөвхөн ямар нэг албан тушаалтан, эсвэл буянтан, эсвэл Үнэнийг оноосон нэгэн болж өөрсдийгөө түүгээр хязгаарладаг. Биднийг хязгаарлах хил, нээгдээгүй өнцөг булан оршсоор л байх болно. Даруу болоод ариун сэтгэлтэн юунаас ч үл хамаарч байдаг. Юу ч үгүй байна гэдэг нь юм бүхэнтэй байна гэсэн үг.¹⁰

¹⁰ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1989 оны наймдугаар сарын 13 (Хятад хэлээр)

❧ Даруу төлөв байж бусдыг бүү шүүмжил ❧

Бясалгалын өдрийн тэмдэглэлээ өдөр бүр шалгаж, хийсэн зүйл тань зөв сайн байсан эсэхийг тунгаа. Сайн нь цөөн, муу үйл нь олон, шунал хүсэл, уур хилэн, үзэн ядалтаар дүүрэн байвал өөрсдөөсөө бид ичих болно. Өөрсдийгөө нүүрс мэт хар гэдгээ бид ойлгосон учраас аажимдаа даруу төлөв болж, бусдыг шүүмжлэх санаагүй болно. Өөрсдийн маань хөл шаварт шигдээстэй байвал бид яаж бусдын хөлхөх замыг гэрэлтүүлэн тусалж чадах вэ? Ингэснээр бидний “би” гэх үзэл багасдаг.

Эсвэл та нар энд үлдсэн ч болно. Та нарт энд нуугдах газаргүй болохоор надад өдөр бүр зэмлүүлэн загнуулахаараа “би” үзэл чинь засарна. Би өдөр бүр дутагдлуудыг чинь гарган ирж, ахин дахин сайтар засах болно. Тэгснээр та нар “би”



үзлээ дэвэргэж зүрхлэхээ болино. Гэвч даруу байдал болон биеэ дорд үзэх нь хоёр өөр зүйл юм. Биеэ дорд үзэх зуршил бол өөр. Энэ нь хүн өөрийгөө асар дорд үзэж, хэрэгцээгүй амьтан мэт санахыг хэлдэг юм. Би та нарыг хашхирч загнадаг ч тэр нь хайр, дэмжлэг, адислалыг тээж байдаг.

Харин ердийн амьдрал дээр хүмүүс та нарыг нэр хүнд, эд хөрөнгөнөөс болж дарамталдаг. Хувийнхаа ашиг сонирхлын төлөө тэд бидний амьдралыг золгүй, өрөвдмөөр болгон зүрх сэтгэлийг маань шархлуулж, өөртөө итгэх итгэлийг бүрэн нухчин дардаг.

Тиймээс дээрх хоёр зэмлэл нь хоорондоо ялгаатай. Нэг нь бидэнд өрсөлдөөн болж, нөгөө нь биднийг “би” үзлээсээ ангижрахад туслахын тулд юм. Хоёр дахь маягийн зэмлэлд хайр нуугдаж байдаг. Тиймээс заримдаа бид тайвшруулах маягийн уур амьсгал, тайтгарал, энэрэнгүй байдлыг үүнээс мэдэрдэг юм. Загнуулсан ч тэр хүнээ үргэлж санаж



үгүйлэх маягтай. Түүнийг та мартаж ч чадахгүй, үзэн ядаж ч чадахгүй. Гэтэл ердийн амьдрал дээр хүмүүс хэчнээн эелдэг сайхнаар ярьсан ч бид тэднээс болгоомжилсоор байж мэднэ. Биднийг мэхлэх төлөвлөгөөг гаргаад ирэх вий гэж, тэд бидний эсрэг ашиглахад хэзээд бэлэн хутга нууж яваа мэт бидэнд аймаар санагддаг. ¹¹

¹¹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1990 оны аравдугаар сарын 10 (Ау-Лак хэлээр)



Дорд хүмүүс маш даруу, сэтгэл ариун бас энгийн байдаг. Тэдэнд түшиж тулах юу ч үгүй. Тэдэнд татагдаж хүлэгдэх зүйл юу ч үгүй. Тэд юу ч үгүйгээ мэддэг болохоор зүрх сэтгэл нь ч маш ариун, энгийн байдаг. Цэвэр ариун бөгөөд энгийн цайлган зүрх сэтгэл үрүү агуу адислагч хүчин илүү хялбар нэвтрэн орно.

Чин ариун сэтгэлтэн илүү түргэн дэвшдэг

Тэд гадаад байдлаараа ялгарч харагддаггүй
ч гэлээ надад үнэнээсээ сайн байдаг, надад
хамгаас хүчтэй итгэж,
миний төлөө хамгаас илүүтэй санаа тавьдаг.

Миний хэлсэн бүхнийг тэд биелүүлдэг.

Дотроо надад эргэлздэггүй,
гаднаа намайг эсэргүүцдэггүй.

Тийм хүмүүсийг харахад тэд маш түргэн
дэвшдэг нь ойлгомжтой байдаг.



Чин ариун сэтгэлтэн илүү түргэн дэвшдэг

Яагаад цэвэр ариун сэтгэлтэй, энгийн бодолтой хүмүүс оюун санааны дадал бясалгалд маш түргэн дэвшдэг вэ? Учир нь “тэнэг” хүмүүс маргахыг мэддэггүй. Тэд яг л хүүхэд шиг, ямар ч эргэлзээгүйгээр надад бүрэн итгэдэг. Энд тийм хүмүүс олон бий. Иймээс л тэд түргэн дэвшиж байгаа юм. Тэд гадаад байдлаараа ялгарч харагддаггүй ч гэлээ надад үнэнээсээ сайн байдаг, надад хамгаас хүчтэй итгэж, миний төлөө хамгаас илүү санаа тавьдаг. Миний хэлсэн бүхнийг тэд биелүүлдэг. Дотроо надад эргэлздэггүй, гаднаа намайг эсэргүүцдэггүй.

Тийм хүмүүсийг харахад тэд маш түргэн дэвшдэг нь ойлгомжтой байдаг.

Дуулгавартай байж, намайг хүндэтгэдэг мэт харагддаг өөр хэсэг хүмүүс байдаг. Гэвч тэдэнтэй хэсэг зуур ярилцсаны дараа тэд “би” үзэл ихтэй, надад бүрэн итгэдэггүй нь ойлгомжтой болно. Заримдаа тэд үүнийгээ нуухгүй. Та нар олон хүнтэй уулзахынхаа хэрээр миний сургаалыг хэн үнэхээр ойлгож надад бүрэн төгс итгэдгийг ялгаж сурна. Гэвч тэднийг гадаад төрх байдлаас нь мэдэхийн аргагүй.

Та оюунлагийн бясалгалдаа хурдан, удаан дэвших эсэх нь дан ганц Багшаас хамаарахгүй. Хэр их дэвшил гаргах нь мөн та Багшдаа хэр их итгэж, бас Багшдаа яаж хандаж байгаагаас тань хамаарна. Оюун санааны бясалгал дадалдаа хэрхэн дэвшил гаргах тухай нэгэн нууц хэлж өгье. Гэхдээ өөр хүмүүст битгий хэлээрэй. (Бүгд инээлдэж, алга ташив.)



Хүйтэн сэтгэлийн ханаар саатуулагдах нь

Хурдан эсвэл удаан дэвших эсэх нь бидний сэтгэлийн цэвэр ариун байдлаас их хамаардаг. Заримдаа бид цэвэр ариун байхыг маш их хүсдэг ч чаддаггүй. Учир нь бидний өнгөрсөн үйлийн үр хүйтэн сэтгэлийн үрийг тарьжээ. Тэгээд хүйтэн сэтгэлийн тэр хана одоо бидэнд саад болж байна. Бид зүгээр л Багшдаа бүрэн итгэж, өөрийн бие, хэл, сэтгэлээ Түүнд бүрэн зориулж чаддаггүй.

Зарим хүмүүс маш хичээнгүй бясалгадаг. Тэд өдөрт 4-5 цаг бясалгадаг ч тэдний сэтгэл дэлхий ертөнцөд татагдсан хэвээр, нэр хүнд, эд хөрөнгө хүссээр л байдаг. Үүний дүнд тэд ямар ч дэвшилд хүрдэггүй. Тэд энэ дэлхийд байхыг хүссээр байгаа учраас дахин нэг удаа төрөл авах

хэрэгтэй болж магад. Тэдгээр хүмүүсийг би нэг удаа буцаан ирүүлж, тэднийг дэвшүүлэхийн тулд өөр Багшаас суралцуулахаас өөр аргагүй. Энд байгаа манай зарим авшигтнууд урьд төрөлдөө Арьяабалын аргад аль хэдийн суралцсан. Тийм боловч тэд энэ дэлхийд татагдсаар байсан учраас зөвхөн замын хагаст хүрчээ. Эсвэл тэд хангалттай чин сэтгэлтэй байгаагүй, Багшдаа эргэлзсээр байсан болохоор дахин эргэн ирсэн байж болох юм.

Энэ бол миний та нарт урьд ярьсан түүхтэй л адил. Надад захиа бичсэн нэг хүн хэлэхдээ, авшгийн дараа тэр надад өдөр бүр залбридаг байжээ. Тэр надад үнэхээр итгэж байж. Хоёрхон сарын дотор тэр асар их дэвшил гаргаж, бясалгах үедээ хурц гэрэлтэй ертөнцөд хүрч чаджээ. Гэвч дараа нь надад эргэлзэж эхэлсэн. Хэрэв бясалгах үед сүнс биеэ орхивол чөтгөрт



эзлэгдэнэ гэж түүний өмнөх багшийн хэлснийг тэр санасан байна. Тэгээд миний сургаал, зааж сургасан аргад эргэлзэх болжээ. Үүнээс болж түүний дэс тэр даруйдаа унасан. Тэр одоо хүртэл буцаж өгсөж чадаагүй хэвээр байгаа. Тэгэхээр Маяа бидэнд ямар том саад бэрхшээл үүсгэж чаддагийг та нар ойлгож байгаа буй за.¹²

¹² Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1988 оны аравдугаар сарын 29 (Хятад хэлээр)

❧ Ариун сэтгэлтэй хүмүүс Эзэн Бурханд түргэн хүрдэг ❧

Цэвэр ариун сэтгэлтэй хүмүүс илүү энгийн байдаг. Тэд Бурханд түргэн хүрдэг юм. Учир нь тэдэнд хэт их бодож, хэт их харьцуулж, хэт их зүйлийг сурч дуусгах шаардлага байдаггүй. Эрдэм мэдлэгтэй эсвэл зарим чадвар ололт сайтай хүмүүс амжилт гаргахын тулд тодорхой нэгэн салбарт байх хэрэгтэй болдог учраас илүү ярвигтай байдаг. Тиймээс давуу болон сул тал, амжилт уналтаа шинжлэн бодох зуршилтай болж: “Хэрэв би бясалгаж суувал Эзэн Бурханаас юу олж авах бол? Ер нь юм олж авах юм уу? Ингэх ашигтай гэж үү? Цаг бол алт!” (Бүгд инээлдэв) гэж заримдаа бодно. Тэгээд далд ухамсар нь тэднийг Бурханы Оронд хүрэх



замаас нь холдуулж байдаг. Үүнийг л бид “би” үзэл гэдэг бөгөөд үнэндээ бол тийм юм байдаггүй. ¹³

¹³ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Хавай, АНУ, 1994 оны есдүгээр сарын 6 (Англи хэлээр)

Хүүхэд шиг үргэлж гэнэн цайлган бай

Энгийн хүмүүс бүгд Үнэнийг оноож чадна. Хамгийн чухал нь цэвэр ариун сэтгэл, алагчлал үгүй сэтгэл, аз жаргал хийгээд зовлон шаналалд ялгаваргүй хандах сэтгэл юм.

Зэн Их Багш Сэнг-Цан (Зэний 3 дахь өвөг) юу хэлснийг та бүхэн мэдэх үү? ”Алагчлан үзэх сэтгэлтэй хүмүүсийн хувьд Агуу Зам Мөрийг эрж олох нь туйлын хүнд”. Үүгээр Тэр, тэгш шударга агаад энгийн, хангалуун сэтгэлтэй хүмүүс Үнэн Ёсонд хүрэхэд илүү амархан байдаг гэсэн санааг хэлжээ.

Түүнчлэн Лууз хэлэхдээ хүн хүүхэд мэт болсон цагтаа л Дао-д хүрч чадна гэжээ.



Есүс Христ хэлэхдээ хүүхэд шиг гэнэн цайлган болоогүй цагт та Эзэн Бурханы Вант Улсад нэвтрэн орж чадахгүй гэсэн байдаг. Ийнхүү Бурханы шашин болоод Бумбын шашинд ижил зүйл, Библид бас төстэй зүйлийг өгүүлжээ.

Лалын шашин ч мөн адил зүйлийг номлодог байна. Тэд бусдыг шүүмжлэхгүй байхыг сүсэгтнүүддээ сургадаг. Хүн ямар байх нь хамаагүй, түүний ямар байгаа нь Эзэн Бурханы таалал мөн гэдэг. Энэ нь хүүхэд мэт байж, бусдыг бүү шүүмжил гэсэн санаа юм. Тэгвэл зөв болно!¹⁴

¹⁴ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айдвар, Пингун, Формоса, 1988 оны арванхоёрдугаар сарын 1 (Хятад хэлээр)



Хамгийн сайхан бөгөөд ариун сэтгэл нь орчлонгийн бүх сайн сайхан зүйлийг, хамгийн цэвэр ариун болгоныг, бүр бидний хүссэнээс ч илүү ихийг өөртөө татдаг.



Хэрэв бид сайхан сэтгэлтэй бол бүх юмстай нэгдмэл байхад хялбархан бөгөөд Эзэн Бурхантай холбогдоход ч амархан болно. Сэтгэл маань хөндий байвал бид өөрсдийгөө тойруулж хана өрсөнтэй адил болдог. Бид зөвхөн Багшийн дэргэд байснаар л зүрх сэтгэл маань Түүнд илүү ойр байдаг юм биш. Хэрэв сэтгэл тань ойрхон байхыг хүсвэл түмэн бээрийн зай ч хол санагдахгүй. Бид Түүний хажууд нь байлаа ч зүрх сэтгэл маань Түүнтэй хамт биш байвал бид үнэхээр хол байх болно.

Тайвшрал

Хэрэв та бясалгахдаа, намайг харж
байгаа шигээ тайван байдаг бол тэр
жинхэнэ бясалгал мөн.



❧ Жинхэнэ бясалгал ❧

Та нар бүгд л бясалгаж суух үеийн үзэгдлүүдийг жинхэнэ оюун санааны ахуй ойлголт хэмээн татагддаг хэрнээ бясалгаагүй үедээ хардаг үзэгдлүүдийг ерөөс тооцдоггүй. Гэвч үнэн хэрэгтээ яг энэ мөчид та жинхэнээр бясалгаж байдаг. Учир нь “Зэн бүх зүйлд оршдог.” Бясалгал гэдэг нь чанга хатуу сууж өөрийгөө зохицуулахын нэр биш юм. Энэ бол буруу арга зам, учир нь ийм үед бид “би” үзлийн үүднээс бясалгадаг бөгөөд тиймдээ ч ахуй ойлголтгүй байдаг. Гэгээрэлд хүрэхийн тулд бид энгийн байдлаар л бясалгавал зохино.

Хэрэв та бясалгахдаа намайг харж байгаа шигээ тайван байдаг бол тэр жинхэнэ бясалгал мөн. Түлээ хагалж байгаад гэгээрсэн болон мөн Гэгээрсэн Багшаас хэдэн үг сонсонгуутаа

гэгээрсэн хүний тухай түүхийг бид сонссон. Тэр л юм шүү дээ. Яагаад та нар хэдэн цагаар бясалгаж суусныхаа дараа ахуй ойлголтгүй байдаг вэ? Учир нь та өөрийн “би” үзэл, тархи бодлоороо бясалгадаг. Анхаарлаа хэт хүчтэй төвлөрүүлэн, өөрийгөө дэндүү хүчилж, түүндээ хүлэгдэж, бухимддаг. Таны ахуй ойлголтгүй байгаагийн шалтгаан энэ юм. Энэ бол жинхэнэ бясалгал биш, харин ердөө л нэг төрлийн дасгал.

Жинхэнэ бясалгал хэзээ ч явагдаж байдаг. Тиймээс та нарын зарим чинь унтаж байхдаа эсвэл над уруу анхааралтай харахдаа сайн ахуй ойлголттой болдгийн учир нь энэ юм. Анхаарал чинь тэр цаг үе дээр төвлөрч байгаа нь бясалгал юм. Намайг харж, сонсож байгаадаа баярлах тэр үед та мухар сүжгээ орхисон байдаг учраас төвлөрч чаддаг. Энэ бясалгал биш гэж үү? Энэ үед та ердийн ахуй ойлголттой болдог.



Та “Би бясалгамаар байна. Өө, яахаараа би ахуй ойлголтгүй байна вэ? Яагаад одоо болтол ирдэггүй юм бэ? Хэзээ ирэх юм бол оо?” гэж бодон, хөмсгөө зангидан сууж байна гээд бод. (Инээлдэв.) Та өөрийгөө болон гэгээрлийн ахуй ойлголтыг яаруулж байна. Гэтэл ахуй ойлголтууд хэзээ ч яардаггүй. Тэд ирэх үедээ ирж, хүссэн үедээ явна. Тэд юунд ч хүлэгдэхгүй. “Билгийн чанадад очроор огтлогч” сударт өгүүлсэнчлэн бид юунд ч хүлэгдэхгүй болсон тэр цагт гэгээрэл ирдэг гэжээ. Бид гэгээрэлд хүрэхийн тулд оюун санааны энэхүү үлгэр жишээг дагаж мөрдөх хэрэгтэй.

❧ Ариун Орон дэргэд маань байдаг ❧

Маш цэвэр ариун, өчүүхэн ч үймээгүй сэтгэлээр над уруу ширтэхэд та, байвал зохих бүх ахуй ойлголттой болдог. Та нарын зарим чинь намайг ном тайлах үед танхим туйлын гайхамшигтай гэрлийн ертөнцөд хувирахыг олж харж байсан. Энэ бол Ариун Орон юм. "Ариун Орон дэргэд маань байна" гэж ярьдаг нь үүнийг хэлжээ. Манай дэлхий материаллаг, гэвч бид оюун санаагаар төвлөрөх даруйд энэ дэлхий Ариун Орон болж, чөтгөрүүд нүдний өмнө Гэгээнтэн болж чадна.

Та нарын зарим чинь нийтийн бясалгалд оролцсоны дараа тийм сайхан ахуй ойлголттой болсонгүй гэж надад гомдоллодог. Үнэн хэрэгтээ энэ нь та нарын би үзэл ихэсч, хайр багассанаас болжээ. Номын ахан дүүсээс болсон хэрэг



биш. Та бусдыг зэмлэхийн оронд өөртөө дүн шинжилгээ хийвэл зохино. Би тэр бүр хэлээд байдаггүй л болохоос ийнхүү гомдоллодог хүмүүст дургүй. Намайг бусдыг буруутгаасай гэж тэд хүсдэг ч, би ташаа бодлоор юм хийхгүй.

Та нарын зарим чинь над уруу харж байхдаа толгойдоо дүүрэн бодолтой байдаг. Харж байгаа юм шиг хэрнээ үнэндээ хардаггүй. Тэгснээс харахгүй байх нь дээр. Харж байсан ч толгой дотор нь өдий төдий бодол эргэлдээд л. Намайг зайлуулах гэсэн мэт Ариун Нэрсээ унших уу, байх уу гэж эргэлзэнэ. (Инээлдэв.) Над уруу харахдаа ингэхийг санаж байгаа нь намайг зайлуулах гэж байгаа мэт тул энэ нь надад таагүй байдаг. Та нар над уруу яг л эцэг эхээ удтал хараагүй хүүхэд шиг харвал танд олдож болох хамгийн сайхан дотоод ахуй ойлголттой болно.

Бид нүдээ аньж
 хөмсгөө зангидан
 цухалдан суугаагаа
 л бясалгаж байна
 гэж бодох ёсгүй.
 Үгүй шүү, үгүй.
 Энэ бол ердөө
 л нэг төрлийн
 дасгал төдий.
 Бид чин сэтгэлээ
 илэрхийлэн нам
 жим сууна. Заримдаа
 тайван сууж чадахгүй
 ч үргэлжлүүлнэ. Бид



бясалгалдаа Эзэн Бурханыг хүлээж
 байдаг. Чин сэтгэлтэй байвал заримдаа бид ахуй
 ойлголттой болно. Харин заримдаа төвлөрч
 чадахгүй болохоор “Би чин сэтгэлтэй ч, үгүй ч яг
 одоо миний хийж чадах зүйл энэ л байна. Надад
 тусална уу, Бурхан минь” гэж хэлдэг.



Тиймээс бид өдөр бүр бясалгахаа үүрэг гэж ойлгох ёстой. Идэх дургүй байлаа ч бид иддэгтэй адил. Бид дөнгөж өглөө сэрмэгцээ, мөн ажлаас тарж гэртээ ирмэгцээ Эзэн Бурханыг дурсдаг хэвшилтэй болох ёстой. Учир нь бид өдөр бүр маш завгүй байдгаас Эзэн Бурханыг чин сэтгэлээсээ дурсаж чаддаггүй. Тиймээс бид өглөө эрт боссоныхоо дараа, бас орой гэртээ харьж ирээд үүнийг хийх хэрэгтэй. Гэвч энэ нь бид Эзэн Бурханыг бүрэн санан дурсаж байгаа гэсэн үг биш. Бид ердөө чадах чинээгээрээ л хийж байгаа хэрэг. Бид ажиллаж байхдаа ч Эзэн Бурханыг бас дурсаж байвал зохино.

Их Багшийг ном тайлах үед гэгээрэх нь

Гэгээрсэн багшийн ном тайлахыг сонсох нь бидний хувьд маш их буян адислал болох юм. Учир нь тэр үед Их Багшийг 2-3 цаг тасралтгүй харах болохоор Түүний давтамжийн ачаар бид дэвших буюу Түүний гэрэлд бидний муу үйл түйтгэр тодорхой хэмжээгээр угаагдаж, улмаар дотоод ахуй ойлголттой болно. Та бүхэн энд ирэхээрээ намайг 2-3 цаг тасралтгүй харж чаддаггүй учраас ном тайлах үетэй адил их адис хүчийг авч чаддаггүй. Их Багшийг тасралтгүйгээр 2-3 цаг харах боломж олдоно гэдэг нь маш их буян хариулал юм шүү дээ! Хүн бүхэнд ийм боломж олдохгүй. Хоёроос гурван цаг харж суух нь бүү хэл, эрин галвуудын туршид ганцхан удаа харахад л хангалттай! Өөр бусад гаригийн



төрөлхтнүүд Их Багшийг харж, бас сонсож байсан удаагүй. Тэд Их Багштай барилдлагатай байсангүй. Тийм болохоор жинхэнэ Их Багшийг хэдэн цагийн турш харах боломжийг та бүхэн алдахгүй ашиглах хэрэгтэй. Маш олон авшигтан болоод авшигтан бус хүмүүс намайг ном тайлах үеэр гэгээрсэн юм.

Тиймээс бясалгал гэдэг нь зөвхөн суухыг хэлдэггүй. Хүн хамаг зүрх сэтгэлээрээ төвлөрөх үед бясалгал болдог. Та нар ажиллаж байх үедээ ч ахуй ойлголттой болж байдгийн учир энэ. Бид “би” үзлээрээ бясалгадгаас зарим үед бясалгалдаа ахуй ойлголт ололгүй гонсойдог. Энэ нь бясалгах зөв арга зам биш ээ. Гэхдээ зүгээр. Та ямар ч гэсэн буян хураах л болно. Зүгээр л чин сэтгэлээсээ бясалга. Үр дүн нь хамаагүй.

Та нар бясалгах үедээ яагаад дотоод ахуй ойлголтгүй байдгийг би хэлж өгье. Учир нь та нар тэр үед сэтгэлийнхээ хүлээснээс бүрэн салаагүй, жинхэнээсээ төвлөрч чадаагүй байдаг. Тэгсэн хэрнээ төвлөрч байна гэж санаад, хөмсөг зангидан “Яагаад Багшийн хувилгаан бие одоо болтол ирэхгүй байна вэ?” хэмээн гайхширч суудаг. Чин сэтгэлийн эрмэлзэл гэдэг сэтгэлийн хүлээснээс өөр хэдий ч, анхлан суралцагсдын хувьд эдгээрийг ялгаж салгах нь хэцүү. Гэхдээ энэ хамаагүй, зүгээр чадахаараа л хичээ. Сайн бясалгаж байна уу, үгүй юу, анхаарал сарниж байна уу, үгүй юу, ялгаагүй. Зориуд бясалгаж Багшийгаа дурсаж байгаа цагт тооцогдох л болно. Та нарын зүтгэл баримт болж, ямар ч байсан дэвшинэ. (Алга ташицгаав).

Жишээлбэл: Та хувцасны дэлгүүрт ажилладаг гэж бодъё. Заримдаа худалдан авагч



байхгүй үед та сууж байгаад унтчихдаг. Гэсэн ч эзэн чинь, дэлгүүр дээр өнгөрөөсөн цагт чинь мөнгө төлнө. Бусад өдөр бүхэл өдөржин завгүй ажилласан байхад эзэн бас л ижил хэмжээний цалин төлдөг. Дэлгүүр дээрээ очиж байсан цагт та сарын цалингаа авах л болно. Бясалгал ч мөн үүнтэй адил. Ахуй ойлголтыг үл харгалзан та бясалгах хэрэгтэй. Таны хичээл зүтгэл тооцогдож, нэг л өдөр би танд хөлсийг тань өгч, та түүгээрээ Бурханы орон луу явах тийзээ авна. (Алга ташив.)¹⁵

¹⁵ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Илан, Формоса, 1988 оны наймдугаар сарын 12-18 (Хятад хэлээр)



Та нарын олонхи нь асуудал үүсгэн өөртөө саад болдог. Тайван байж хөгжих боломжийг өөртөө олгодоггүй. Ийнхүү тайван бус байснаар таны бодол санаа түгжигдэж, үүний улмаас хийж буй үйлдэл тань төгс бус байдаг.



❧ **Тэнцвэртэй амьдралаар амьдрах нь Дао мөн** ❧

Та бүхэн оюун санааны зам мөрөөр замнахдаа хэр хэмжээг нь тааруулах хэрэгтэй. Маргааш Гэгээнтэн болж болох байтал өнөөдөр болох гэж юунд яарах вэ? Та нар урьд урьдын олон төрөлдөө хүлээж болсон юм чинь хэдэн өдөр илүү хүлээхэд тийм сүртэй юм юу байна? Хэдий их яаран бачимдах тусмаа та нар өөртөө төдий чинээ саад болдог.

Эрт үед Төгс Гэгээрсэн Багшид нэг хүн шавь оржээ. Нэг өдөр шавь нь багшаасаа: “Багш аа, та над шиг чин сэтгэлтэнг энэ дэлхийд хэдийг тоолж чадах вэ?” гэж асуужээ. Багш нь: “Чам шиг шавь орчлон ертөнцөөр дүүрэн байна” гэж хариулж гэнэ (Багш болоод бүх хүн инээв.) Үүнд үл итгэсэн шавь үргэлжлүүлэн:

“Багш аа, би үнэхээр чин сэтгэлтэй. Хэрэв би эцэг эх, эхнэр хүүхэд, садан төрөл, найз нөхдөө бүгдийг огоорвол Гэгээнтний дэсэд хэдэн жилийн дараа хүрэх вэ?” гэж асуужээ. Багш нь: “Хэрэв хичээнгүй байж чадвал 5-15 жилийн дотор хүрнэ” гэв. Шавь үргэлжлүүлэн: “Энэ чинь хэтэрхий удаан байна. Хэрэв ууж идэхээсээ татгалзан, унтахаа ч больж, хоногийн 24 цагийн турш завилан сууж, зөвхөн бясалгавал би хэзээ Гэгээнтэн болно гэж та бодож байна” гэхэд Багш нь түүнд “Ийм замаар бол 30-50 жил болох байх” гэжээ. (Багш болоод бүгд инээлдэв). Яагаад гэдгийг та нар мэдэж байна уу? Тэр хэтэрхий их сандруу байна. Тэр өөрийгөө хэн гэж бодсон хэрэг вэ? Түүний Гэгээнтэн болох үгүй нь хэнд хамаатай вэ? Түүн шиг хүн ер нь хэнд хэрэгтэй байх вэ?



Хамгийн шилдэг зам бол төв үзэл

Шагжамуни Бурханд шөнө ч унтдаггүй нэгэн шавь байжээ. Тэр шавь өдөр нь бясалгаж, шөнө нь судар номоо уншсаар бараг сохрохоо шахаж гэнэ. Тэгээд Шагжамуни Бурхан: “Энэ янзаараа бол чи удахгүй Гэгээнтэн биш Маяа болох нь. Ятга тоглоход утас нь хэт чанга байвал ямар нэг аялгуу гаргаж чадах уу?” гэхэд шавь: “Үгүй” гэж хариулав. “Хэрэв утас нь хэтэрхий сул байвал ямар нэг дуу гаргаж чадах уу?” гэж асуухад шавь: “Үгүй ээ, ямар ч дуу гарахгүй” гэж хариулав. Тэгэхэд Шагжамуни Бурхан: “Дундыг барих л хамгийн сайн” гэж хэлжээ.

Тиймээс тэнцүүртэй амьдрал бол Үнэн, энгийн бодол санаа бол Үнэн мөн. Бид юуг ч хүсч, юунд ч шунаж болохгүй. Гэгээнтэн болох

гэж яаран хүсэх нь бас нэг төрлийн шунал мөн. Бид юу ч хийсэн дундыг л барих хэрэгтэй. Дөнгөж төрсөн нялх хүүхдээс дугуй унахыг шаардаж яаж болох вэ? Түүнийг өсч томрон чадварлаг хүн болохыг харахсан гэхээс тэсэн ядаж байж болох ч, түүнийг яаруулж болохгүй. Тогтвортой алхаж ч чадахгүй хүүхдээс гүйхийг яаж шаардах вэ? Тэр хүчлэн гүйсэн ч удахгүй унах болно. Хөлд орж байгаа хүүхэд гүйхийг оролдвол хэд алхаад унах биш үү? Ингэснээрээ хамраа хугалж, биеэ бэртээнэ, хэтэрхий их сандарснаас л хамаг юм болно гэсэн үг.



Юун түрүүнд бодлоо иэгиэл

Бид эхлээд өөрсдийн бодол санаандаа сайтар анхаарал тавих хэрэгтэй. Бид эрхэм ариун зарчимтай билүү, шунал уур хилэнгээ номхотгож чадсан уу, бусдыг хайрлан энэрч, хүлцэнүй хандаж, алдаа дутагдлыг нь тэвчиж чадахаар хэмжээнд сайхан сэтгэлтэй, бусдыг ойлгодог өгөөмөр билүү гэдгээ шалгах хэрэгтэй. Бид энэ бүх чанарыг бүрдүүлсэн цагт Гэгээрсэн Их Багш эсвэл Гэгээнтэн болоход хэзээ ч оройтохгүй. Төгс төгөлдөрт хүрээгүй цагт бидний Гэгээрэл хэнд тустай юм бэ? Бид буруутай мэдрэмж, тогтсон үзэл бодол, мунхаг сэтгэлээсээ гүйцэд салж амжаагүй хэвээр байна. Явцуу бодолтойгоосоо болж бусдыг хүлцэн тэвчиж чадахгүй байна. Олон хүнийг хайрлахад бидний хайр хэтэрхий багадна. Тиймээс Гэгээрсэн Их Багш болох гэж яарах хэрэг юунд

байна? Ахар бодолтой, адгаж тэвдсэн мунхаг хүмүүст бүх Гэгээнтэн, Их Багш нар хамаг адис хүчээ цутган хийж өгсөн ч ямар тус болох вэ?

Хайраар биш, адис хүчээр дүүрсэн тийм хүн зөвхөн Маяа л болж хувирна. Маяа ба Гэгээнтний хооронд гойд их ялгаа байхгүй. Аль аль нь хүч ойролцоо, Гэхдээ Маяад байдаггүй хайр Гэгээнтэнд байдаг. Маяа маш аминч, юм бүхнийг нэхэн шаардаж, бүгдийг өөртөө хаман авдаг. Тэр зөвхөн шүүмжлэхээс л биш хэзээ ч уучилж өршөөдөггүй. Харин Гэгээнтэн шүүмжилдэг ч, бас уучилдаг. Тэр хүмүүсийг өсч дэвшихэд нь, өөрийн дутагдлаа ойлгоход нь туслах гэж цагаа олж шүүмжилнэ. Цаг нь болоход уучилж, гэм буруутай гэсэн ачаа дарамтгүйгээр цааш амьдрах урам зоригийг тэдэнд хайрладаг.



❧ Арга билиг тэнцэж Гэгээнтэн болно ❧

Зөвхөн тодорхой нэг биш, бүх л талбарт бид төгс төгөлдөр болсон цагт жинхэнэ Гэгээнтэн болно. Бид зөвхөн ууч өршөөнгүй, хэзээ ч шүүмжлэхгүй байгаад байх нь сайн хэрэг биш! Жишээлбэл: Шүүмжлэн сургах цагт нь хүмүүсийг магтаад байвал тэднийг эвдэж, оюунлагийн зам мөр дэх шүүн тунгаах чадварыг нь сүйтгэх болно. Тиймээс “Арга (Эерэг) Билиг (Сөрөг) тэнцэж Гэгээнтэн болно гэж Би хэлдэг. Бид энэ амьдралын бүх талбарт гарамгай болох хэрэгтэй. Энэ дэлхийд бид амьдарч байгаа учраас идэж, унтаж, бусад хүмүүстэй харьцаж байна. Тиймээс ч бид энгийн байх ёстой. Бид өөрсдийн түвшин, оюунлагийн ахиц дэвшлээ дотооддоо хадгалж, үйл хөдлөлөөрөө түүнийгээ бусдад задруулахгүй байх хэрэгтэй.¹⁶

¹⁶ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1990 оны аравдугаар сарын 19 (Хятад хэлээр)

❧ Үр дүнд бүү хүлэгд ❧

Ганц алхаад Бурханы Оронд хүршгүй. Оюун санааны бясалгагчдын хувьд энэ мөн адил. Өдөр бүр чармайн бясалгаж байвал цаг нь ирэхэд үр дүн нь аяндаа гарах болно. Энэ нь бид хүүхдүүдээ яаж өсгөн торниулдагтай адил юм. Тэднийг өдөр бүр сайтар харж хандаж л байвал тэд аяндаа том болно. Бид өмнөхтэй нь харьцуулж үзээд “Хөөх, эд хэчнээн том болоо вэ!” гэдэг. Зарим хүүхдүүд эцэг эхээсээ ч өндөр болдог. Тэгтэл нэг мэдэхнээ бидний үс бууралтаж эхэлнэ, бид харин хэзээнээс эхэлснийг нь ч санадаггүй. Надад ч хүртэл хэдэн цагаан үс ургасан. (Бүгд инээлдэв). Тоолсон чинь гурав байна билээ. (Багш болон бүгд инээлдэв). Тиймээс ямар ч үр дүн ажиглагдахгүй байгаа бол бүү санаа зов. Зүгээр л чармайн бясалга, үр дүнд бүү хүлэгд. Зарим авшигтнууд бясалгалдаа юм



олж харсангүй гэж надад ярьдаг. Би тэдэнд юм олж үзэх нь тийм чухал биш гэж хэлсэн. Бидний бодол санаа илүү тайван тогтвортой болж, илүү амар амгалан байдлыг мэдэрч, бид илүү итгэл бишрэл, аз жаргалтай болж, Бурханы аврал нигүүлслийг мэдэрч байвал угаасаа хамгийн сайхан ахуй ойлголттой болжээ гэсэн үг. Гэрэл харж, юм үзнэ гэдэг юу ч биш. Зарим хүмүүс бясалгалдаа юм хардаг хэдий ч, бодол санаа нь тогтвортой бус, итгэл бишрэлээр дутмаг байх нь бий. Тэгээд тэд бясалгалаа орхидог. Харин зарим хүмүүс надад чин итгэл сүжигтэй байж, намайг дагах нь зөв зам мөр мөн гэж мэддэг. Энэ арга дээр оюун бодлоо төвлөрүүлсэн тэд замаасаа хазайдаггүй. Тийм хүмүүсийн ахуй ойлголт хамгийн дээд нь юм. (Бүгд алга ташив). Тиймээс бусад хүмүүс ахуй ойлголтынхоо талаар ярихыг сонсоод сэтгэлээр унах хэрэггүй. (Бүгд инээлдэж, алга ташив). Бид амар амгалан, аюулгүй байдлыг мэдэрч байвал хамгийн дээд ахуй ойлголттой байна гэсэн үг. Гэхдээ дотоодын дуу аялгууг олж



сонсоогүй бол амгалан байхад амаргүй л дээ. Энэ тийм амар биш.¹⁷

¹⁷ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1989 оны долдугаар сарын 29-с наймдугаар сарын 6 (Хятад хэлээр)



Энэ дэлхий дээр бид хэт тэвчээргүй байж болохгүй. Ямар нэг зүйлийг хүсвэл түүнийгээ хүсэхгүй байхыг хичээх хэрэгтэй. Тэгвэл тэр зүйл биднийх болно. Энэ нь их хачин. Бид юмыг хэдий их хүснэ, төдий чинээгээр тэр холдох болно. Гэгээрэл болоод Үнэний хутгийг олоход ч мөн адил. Ямар ч тохиолдолд адган сандарч, өөрсдийгөө Гэгээнтэн болгоодох гэж Бурханд тулгах хэрэггүй юм. Үүний оронд аядуу тайван байж, өдөр тутмынхаа ажил үүргийг гүйцэлдүүлэх хэрэгтэй.

Аз жаргалтай бай

**Инээж чаддаггүй Гэгээнтнүүд
өрөвдөлтэй.**

**Тэд хэтэрхий уйтгартай бөгөөд
хангалттай илэн далангүй байж
чаддаггүй.**



“Инээдэг шашин”

Инээд бол аливаа өвчнийг анагаадаг сайн эм гэж би сонслоо. Хятадад “Өдөрт гурван удаа сэтгэлээсээ инээх хэрэгтэй” хэмээн хэлцдэг. Ингэхэд бид өнөөдөр хэдэн удаа инээсэн билээ? (Багш болон бүгд инээлдэв.) Тоолоход хэтэрхий олон байх, тийм үү? Намайг ажил хэрэгч биш байна гэж зарим хүмүүс шүүмжилдэгт гайхах зүйл үгүй. (Багш болон бүгд инээлдэв.) Тэд намайг ариун ном судрыг тайлбарлаж өгөхийн оронд өдөржин наргиан ярьдаг гэх юм. Энэ нь бид наргиан наадмаар мэргэшсэнээс тэр юм. (Бүгд инээлдэв). Тиймээс хэн нэгэн нь танаас аль бүлгэмийнх вэ гэж асуувал ердөө л “Инээдэг шашных” гэж хэлэхэд болно. (Багш болон бүгд инээлдэж, алга ташив). Хэрэв Будда гунигтай бол, тэр өрөвдөлтэй Будда. Түүний хэрэг ч гэж байхгүй. Инээж ч чадахгүй

юм бол Будда болохын ашиг юу байна?

Баруунд “Гунигтай Гэгээнтэн бол өрөвдөлтэй Гэгээнтэн” гэж ярьдаг.





🌀 Инээдээрээ бид өөрсдийн дэсийг хэмжиж болно 🌀

Бид өдөрт хэр их инээдгээ анзаарвал хэр өндөр дэстэй гэдгээ мэдэх боломжтой. (Багш болон бүгд инээв). Бид өөрсдийн дэсийг инээдээрээ хэмжиж болно, тиймээс Багшийн дор Арьяабалын номын цогцсоор бясалгаж эхэлтлээ хүлээх ч албагүй. Инээж чаддаггүй Гэгээнтнүүд хөөрхийлөлтэй. Тэд хэт уйтгартай, мөн хангалттай нээлттэй, илэн далангүй байж чаддаггүй.

Заримдаа та нар надаас “Бусад сүм хийдийн хувраг, гэлэнмаа нар яагаад инээж чаддаггүй юм бол? Тэд бүгд л их чухал, сүрхий, бас гунигтай харагдах юм” гэж асуудаг. Тэд “уйтгартай Гэгээнтнүүд” болоод л тэр. Тэдний зүрх сэтгэл нээлттэй биш болохоор инээгээд байх шалтгаан ер гардаггүй.

Бид оюун санааны бясалгалаа хэдий чинээ их хийх тусам төдий чинээ хөнгөн дэврүүн зантай болдог. Бид улам илүү чөлөөтэй сэтгэж эхэлдэг. Өө сэв эрээд байх зүйл ер нь үгүй болохыг мэдэрч, аливаа зүйлийн сайн мууг хамаарахаа больдог. Тийм ч учраас Их Багш байна гэдэг маш хэцүү. Тэрбээр иймэрхүү зүйлсийг тоож хамаарахаа больсон хэрнээ л, хүмүүсийн дутагдлыг засах шаардлагатай болдог. Юунд ч санаа зовохоо больсон Тэрбээр энэ ажлыг яаж хийсээр байх вэ? Энэ үнэхээр яршиг түвэгтэй, бас залхмаар. Иймд Тэр дургүй ч байсан өөрийгөө хүчлэн хийх хэрэгтэй болдог.

Урьд нь ганцаараа амьдардаг байхдаа би их аз жаргалтай байлаа. Би юу ч хүсдэггүй, надад юу ч хэрэггүй байсан. Одоо олон шавьтай болсноос надад бэрхшээл зовлон мундахгүй болжээ. (Бүгд инээлдэв). Нээрэн шүү! Та нар бүгдээрээ асуудал бэрхшээлээ надад тоочдог.



Хүн бүр өөрийн гэсэн нэг янзын асуудал ярина. (Багш болон бүгд инээлдэв). Та нарын ийм хөөрхийлөлтэй байгааг хараад миний санаа зовниж, зовлон шаналлыг тань нимгэлэх гэж оролддог. Ингэсний дүнд би уруугаа та нарт татагдана. Та нарын бүх асуудлыг шийдвэрлэсний дараа л Би буцаж хэвэндээ ордог, Учир нь Би та нартай нэг юм шүү дээ.

Эцэг эхчүүд хүүхдээ өвдөхөөр зовдог биз дээ? (Бүгд “Тийм” гэж хариулав.) Тийм ээ. Тэд унтаж ч чаддаггүй. Хүүхдийнхээ дэргэд суугаад аргадаж тайтгаруулан, анхаарал тавина. Хүүхдийнхээ өвчин шаналлыг хуваалцаж чадахгүйдээ өөрийгөө зэмлэнэ. Энэ нь та хэдий эрүүл ч гэсэн хүүхдийнхээ зовлон шаналлыг адилхан мэдэрч байгаа хэрэг юм. Хүүхэд чинь жижиг, сул дорой, хаана өвдөж байгаагаа ч хэлж чадахгүй, тасралтгүй уйлах болохоор танд их хэцүү байдаг. Тийм биш гэж үү? (Бүгд “Тийм” гэж хариулж байна). Ердийн эцэг

эх ч хүртэл ийм байхад бясалгагчдын оюун санааны эцэг эхийн тухайд бол ярилтгүй. Тэд шавь нарынхаа төлөө үнэхээр шаналдаг. Гэвч нөхцөл байдал хэдийн ийм их зовлонтой байхад, өөртөө гуниглах боломж өгөөд байвал цаашид яаж амьдрах вэ? Тиймээс алив зүйлсийн гэрэл гэгээтэй талыг үргэлж харж байх хэрэгтэй байдаг юм. Би угаас инээх дуртай болохоороо та нарыг инээлгэх хошин шог зүйлсийг ярьдаг. Чадвал инээж л байх хэрэгтэй. Учир нь энэ дэлхий дээр инээнэ гэдэг амаргүй зүйл шүү. (Багш болон бүгд инээж алга ташив). Надтай цаг нөхцөөхөөр энд ирчихээд ч бас л инээж чадахгүй хэвээр байгаа бол та найдлагагүй болсон хүн байна. Таныг анагаах аргагүй болжээ. Та хаана ч аз жаргалыг олж чадахгүй.

Тиймээс хэрэв та Будда болохыг хүсч байгаа бол “Инээдэг Будда” болно гэдгээ энд ирэх үедээ санах хэрэгтэй. Будда болж чадахгүй юмаа гэхэд ядаж л сахиус- “Инээдэг Сахиус”



болж чадна. (Багш болон бүгд инээлдэв.) Зүрх сэтгэл нээлттэй, өгөөмөр байж сурахгүй л юм бол Будда болохын сайхан нь юунд байна?

☞ **Бид тэнгэр огторгуй, тэнгис далай мэт уужим болно** ☞

Бид хэдий чинээ илүү бясалгах тусмаа төдий чинээ илүү амирлангуй болж, гэм буруутай мэдрэмжээс ангид байх болно. Бид юунд ч үл хүлэгдэн, ямар ч үзэл санаанд дарамтлуулахгүй, тэнгэр огторгуй, тэнгис далай мэт уужим болно. Бид ямар ч явцуу үзлээр хязгаарлагдаж, ямар ч ёс заншилд хүлэгдэхгүй, зүрх сэтгэл маань маш нээлттэй болдог юм. Тиймээс ч бидэнд инээх хэцүү биш.

Инээх ямар ч шалтаг шалтгаан байхгүй ч бид инээж чаддаг, учир нь бид дотооддоо маш их аз жаргалтай байдаг юм. ¹⁷

¹⁷ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1989 оны долдугаар сарын 29-нөөс наймдугаар сарын 6 (Хятад хэлээр)



❧ Инээд баяслын орон ❧

Илүүхэн чармайлт, чин сэтгэл гаргасны дараа Эзэн Бурхан биднийг Инээд Баяслын оронд хүргэх болно. Тэнд хөгжил наргиан дүүрэн, бидэнд юм бүхэн баясгалантай санагдана. Гунигтай Будда нар гэж тэнд байхгүй. Шургуу хөдөлмөрлөснөө болон Багшдаа үнэнчээ харуулах гэж үүгээр түүгээр гүйн, Багшдаа маш их хайртайгаасаа болж Багшийгаа харах гэж хамгаас түрүүнд харайлгадаг чухал царайлсан Гэгээнтнүүд тэнд байхгүй. Тиймээс олонхи Их Багш нар маш их хошин, тэд юуг ч, тэр байтугай Эзэн Бурханыг ч, өөрсдийгөө ч элэглэж чаддаг гэж та нар олонтаа сонсоо биз дээ. Энэ бол гэгээнтэн хүний шинж тэмдэг юм. Бүх юм угтаа тоглоом төдий гэдгийг тэд мэддэг учраас л Баясгалант оронд хүрцгээсэн байна.¹⁸

¹⁸ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Пном Пен, Камбож, 1996 оны тавдугаар сарын 14 (Англи хэлээр)

☞ Тайвшрах цэгт хүрэх л гэж бид шургуу бясалгадаг ☞

Хэрэв Би үхэх болвол инээж байгаад л үхнэ. Энэ бол үнэн. Үнэнийг ухаарахаараа хүн бүх талаар хөгжөөнтэй болж чаддаг. Бид ямар ч нөхцөл байдалд байсан инээж баясахаа зогсоож болохгүйн шалтгаан нь энэ юм. Үнэндээ, тайвшрах цэгт хүрэхийн тулд л бид шургуу бясалгадаг. Тиймээс бид өөрсдөө хэн байсан ч, юмтай ч, юмгүй ч аливаа нөхцөл байдалд баясаж чаддаг. Ингэж бид





өөрсдийн зүрх сэтгэлээ нээж, бүхнийг ойлгон тэвчиж, улмаар бүхий л төрөлтөнд байх Бурхан Чанарыг мэдэрч чадах юм. Иймд бид хэнийг ч дорд үзэхгүй болдог. Магадгүй бид хүмүүсийн дадал зуршлууд, эсвэл хураасан муу араншинг нь олиггүйд бодож болох ч, өөрсдийг нь бол дорд үздэггүй. Дадал зуршилд нь дургүй байлаа ч хүнийг нь хэзээд хайрлаж байдаг.¹⁹

¹⁹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Сангимен, Пингун, Формоса, 1992 оны арван хоёрдугаар сарын 24 (Англи хэлээр)



Бид нарны гэрэлтэй талыг, алив зүйлийн гэгээтэй талыг харах хэрэгтэй. Энэ бол миний та нарт уламжилсан нууц номлолын нэг хэсэг юм. Ингэж байж гэмээ нь бид аз жаргалтай, сэтгэл хангалуун байж, өөрийн бүтээлч авьяас чадвар мөн эерэг, аз жаргалтай байх чанараа хөгжүүлдэг. Бид алив зүйлийг өөрсдийнхөөр болно гэж дандаа бодолгүй, Бурханы таалан зохицуулсныг хүлээн авах хэрэгтэй. Ингэх нь үргэлж хөгжилтэй, санаанд оромгүй, бас амттай байдаг, тийм үү? Энэ нь амьдралыг илүү сонирхолтой ч болгодог.



Инээмсэглэхээр бүхий л бие оршихуй маань тэр чигтээ инээж ухамсрын маань түвшин тодорхой хэмжээнд аяндаа л дээшилдэг. Иймээс сайн инээж байгаарай. Зовлон жаргалын алинд нь ч инээцгээ. Хэрэгтэй бол уйл, гэхдээ уйлж байхдаа ч инээ. Нулимс тань урсаж л байг, харин сэтгэлдээ инээ. Болж л өгвөл инээж байхыг хичээ.

Гэр бүлээ хайрла

Энэ хайрын ачаар бид сэргэлэн цовоо бас аз жаргалтай байх болно. Хүний хүнийг ойлгож, хүлээн зөвшөөрч өрөөл бусдыг хайрлахад илүү хялбар болно. Гэртээ хариад хичээгээд үзээрэй.

Энэ бол аз жаргалд хүрэх арга зам мөн.



❧ Сэтгэл хөдлөлөө хамгаал ❧

Н амайг гэрлэлт, хайр сэтгэлийн талаар ярихаар өөрт хамаатай зүйлээс хэтэрч байна гэж та нар битгий бодоорой. Тийм биш! Хэрэв та нарын гэрлэлт аз жаргалгүй, хань ижилтэйгээ сайхан харилцаатай биш байвал бясалгал самадид орж чаддаггүй учраас л би энэ тухай ярьдаг юм. Та нар дотроо шаналж, сэтгэл тань үймрэн, бодол санаа тань энэ бүх зүйлсээр дүүрсэн байдаг. Самадид орох нь бүү хэл Ариун Нэрсээ ч уншиж чаддаггүй! Ийм үед ижил хос тань танд Багшаас чухал болсон байдаг. Гэсэн ч би та нарыг буруутгахгүй. Учир нь энэ бүхнээс зугтах аргагүй юм. Ийм үед та нар бүр Нирванд орохыг ч хүсдэггүй. Орё гэсэн ч аз жаргалгүй учир та чадахгүй. Энэ бүхнийг би урьд нь өөрийн биеэр туулж өнгөрүүлсэн учраас одоо та нарт сургаж чадна. Иймэрхүү нөхцөл

байдлаас зайлсхийж, хянахад хэцүү. Мэдээж хэрэг, бид оюунлагийн хувьд дэвшсэнээр гэр бүлийн нандин харилцаагаа хэрхэн авч явахыг мэддэг. Гэсэн хэдий ч сэтгэлийн дарамтанд орж, дотооддоо шаналж буй зарим нэг бясалгагч байна. Оюун санааны бясалгал дадалд чинь ийм хамаатай учраас л би та нарт ертөнцийн энэ явдлын талаар ярих хэрэгтэй болж байна. Хүн аз жаргалтай байхдаа Нирванд байдаг. Хэн ч тан дээр ирсэн та аз жаргалтай байж хэнийг ч хайрлаж, хэнийг ч уучилж, хэнд ч юуг ч өгч чаддаг. Харин та аз жаргалгүй байвал юу ч хийхийг, эсвэл ямар ч үүрэг хариуцлага үүрэхийг хүсдэггүй. Та хүссэн ч чадахгүй, учир нь ингэх урам зориггүй болсон байдаг. Ийм үед та бүх зүйлээс залхаж бүхий л ертөнцийг мартахыг хүсдэг. Тийм ч учраас “Үнэний Зам Мөр ертөнцийн хэрэг явдалд оршдог” гэсэн үг бий. Миний хэлж буй зөв үү? (Бүгд “Тийм” гэж хариулав) Тийм ээ. Та нарт ийм юм тохиолдож байсан. Тиймээс оюунлагийн зам мөрөөр цаашид



саадгүй замнахыг хүсч байвал өөрийн сэтгэл хөдлөл, мөн гэрлэлтээ хамгаалах хэрэгтэй гэж би та нарт олонтаа хэлдэг. Гэрлээгүй байгаа хүмүүс нь бие биедээ үнэхээр хайртай бол хайр сэтгэлээ хамгаалах хэрэгтэй. Нэгэнт салж холдсон хойноо алдаагаа засах гэвэл хэтэрхий оройтно шүү. Жаргалтай цаг мөч мөнх үргэлжилдэггүй. Үнэхээр хайрлаж амьдралаа холбох нэгэнтэй үргэлж таараад байдаггүй. Нэгэнт түүнийгээ олсон бол халамжилж байх хэрэгтэй.

Үүнийг хэрэггүй, энгийн, ертөнцийн зүйл гэж бүү бод. Тийм биш шүү, тийм биш. Хань ижилгүй хүмүүс их ганцаарддаг. Зарим нь болоод байдаг ч ихэнх нь чаддаггүй. Танд энэ зүйл яавч хэрэгтэй бол түүнийгээ хамгаалах тал дээр анхаар.

Хайр сэтгэлийг бүү хэл, өчүүхэн сувдыг ч эрдэнэ мэт хамгаалж хайрладаг. Хайр танд тун тустай байж чадна. Түүнд хүлэгдэж хэрэггүй

хэдий ч, тоохгүй орхиж бас болохгүй. Машин тантай адил хүн биш, эсвэл таны нэг хэсэг биш байж болох ч, Шихүгийн төв орё гэвэл танд машин хэрэгтэй. Явган явж очих нь хэтэрхий тухгүй, цаг барсан хэрэг болно. “Би бясалгаж гэгээрэхийн тулд Шихү рүү явж байхад надад машин ямар хэрэгтэй юм бэ? Ердөө л машин төдий шүү дээ. Замын хажууд хаячихъя!” гэж болохгүй. Тэгж болохгүй. Машин таныг энд, над дээр хамаагүй богино хугацаанд түргэхэн хүргэж ирдэг. Ингэснээр та бясалгалдаа илүү цаг гаргах болно. Мэдээж та явган явж ирж болох ч, хэдэн сар зарцуулан таныг энд ирэх үед Би явчихсан байх магадгүй.²⁰

²⁰ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1991 оны тавдугаар сарын 5-наас 12 (Хятад хэлээр)



🌀 Гэрээ диваажин болго 🌀

Зрим бясалгагчдын толгойд нь юу ч тээглээгүй байдгаас тэд маш сэтгэл хангалуун, сэргэлэн цовоо, энгийн байдаг. Тэд илүү ухаалаг байдаг бөгөөд ямар ч хаалт дарамт шахалтыг мэдэрдэггүй. Тийм ч учраас тэдэнд их унтахын хэрэг байхгүй, маш амгалан тайван, их эрч хүчтэй л байгаад байдаг. Үнэхээр ийм байдаг.

Хэрэв та нар санаж байгаа бол бид баяр хөөртэй байхдаа ямар шалтгаанаар хамаагүй найз нөхөд, эхнэр, нөхөр хүүхдийнхээ хэнтэй нь ч байсан ялгаагүй бүхэл шөнийг жаргалтайгаар ярьж өнгөрүүлдэг. Дөнгөж нэг, хоёр цаг унтлаа ч эрч хүчээр дүүрэн байгаагаа мэдэрч байдаг Харин гэтэл гунигтай үедээ, эсвэл буруу юм хийчихсэн мэт санагдах, эсвэл үйл түйтгэр гарч ирэх үед хэчнээн унтсан ч маш их ядарч буйгаа мэдэрдэг. Тийм

учраас л өнөө өглөө Би та нарт тайвшир, тайвшир,
тайван бай гэж хэлсэн юм.

Гэр бүлээ хайрла, тэднийг үнэн сэтгэлээсээ хайрла. Тэгвэл тэд бас таныг хайрлах болно. Энэ хайрын ачаар бид сэргэлэн цовоо, аз жаргалтай байх болно. Гадны хүнийг ойлгож, бусдыг хайрлахад бидэнд амархан болно. Гэртээ хариад оролдоод үзээрэй. Энэ бол аз жаргалд хүрэх зам мөн. (Бүгд алга ташив.)

Олонхи хүмүүс тайван, амар жимэр гэр бүлийнхээ ачаар ажил төрөлдөө амжилт гаргасан байдаг. Тэдний гэр бүлийн гишүүд бие биедээ илүү хайр халамжтай байдаг. Тэд илүү эвтэй хамтач бөгөөд түвэггүй зантай. Эхнэр нөхөр хоёул эв найртай уур амьсгалыг бий болгодгоос гадны нөлөөнд амар автдаггүй. Тэд бас сэтгэлээр ч амархан унадаггүй. Аз жаргалтай хүмүүс бусдын алдаа дутагдлыг тэгтлээ их хайхрахгүй. Санаа зовж, сэтгэл түгших ч үгүй.



Бид гэр бүлийн болон ойр дотны хүмүүсийнхээ хайраас татгалзвал юу ч хийсэн амжилт олохгүй. Тэгээд өөрийгөө тэсвэрлэж чадахгүй өрөвдөлтэй байдалд орж, мэдээж, бас бусдыг ч тэвчиж чадахгүй.

Нийгмийн эмх замбараагүй байдал түгшүүр нь айл гэрийн үл зохирлоос үүсдэг. Энэ нь бие биеэ хүндлэн хүлээн зөвшөөрч, сэтгэлээ хуваалцан өөрийгөө зориулахад бэлэн тийм сайн анд нөхрөөр бид дутагдсанаас тэр. Биднийг жинхэнээсээ сайтар ойлгож, насан туршид маань анд нөхөр байж чадах хүн бидэнд байхгүйгээс тэр. Ойлгож байна уу? (Бүгд “Тийм” гэв.)

Тиймээс гэр орноо битгий там болгон хувиргачихаарай гэж би та нарт хэлдэг. Бид тэнд амьдарч байгаа учраас гэрээ харж, цэгцэлж, засан сэлбэж, сайхан болгож Диваажин болгон хувиргах хэрэгтэй. Энэ нь бид бусдыг энэрэн нигүүлсэж, эсвэл ахан дүүсийн хайраар хайрласандаа тэгж



байгаа юм биш. Өөрсдийн амьдралыг аз жаргалтай, тав тухтай болгохын үүднээс бусдыг хайрлаж байгаа юм. Өрөөл бусдад хайраа хэдий чинээ зориулна, тэд биднийг төдий чинээ хайрлах болно. Хэрэв хүн бүр бие биеэ хайрладаг байсан бол хэчнээн амгалан байхсан бол!²¹

²¹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1989 долдугаар сарын 29-нөөс наймдугаар сарын 6 (Хятад хэлээр)



Энэ дэлхийд гэрлэлт болоод нөхөрлөлийн аль алинд нь сайн тал байдаг. Хамгийн агуу давуу тал нь бид нэг нэгэндээ харилцан тусалж, Өөрсдийн Мөн Чанар, оюун санааны бясалгал дадлын чухлыг бие биедээ харилцан сануулдаг явдал юм. Бидэнд бясалгал болоод дотоодын Мөн Чанарыг маань үргэлж сануулж байдаг аливаа нөхцөл байдал буюу аливаа харилцаа нь сайн сэтгэл барилдлага бүхий сайн харилцаа мөн.





Бурхан биднийг эхнэр нөхрөө дассан сурснаараа хайрлахыг хориглохоор тийм явцуу бодолтой нэгэн биш юм. Өөртөө ирүүлэхийн тулд хайртай хосуудыг хагацуулах тийм харгис нэгэн ч биш. Бурхан болоод бусад төрөлтнүүдийг, түүний дотор өөрийн гэр бүлээ хайрлахын тулд бид зүрх сэтгэлээ уужим болгох хэрэгтэй. Бид харь холын хүмүүсийг хайрлаж чадаж байгаа юм бол яагаад гэр бүлийн гишүүд, ойр дотны хайрт хүмүүсээ хайрлаж чадахгүй гэж?

“Би” үзэл ба Аялгууны бясалгал

Биеэ тоохоос хэрхэн зайлсхийх вэ?
Би та нарт Аялгууны бясалгал илүүтэй
хийхийг зөвлөж байна.
“Би” үзлээ мэдэж байвал өөрийгөө
шалгаж хянах гээд үз.
Түүнийгээ улам ихэсгэх юм уу, дадал
зуршлаа давтах хэрэггүй.
Зайлсхийх боломжтой бол түүнийг бүр
зогсоо.



❧ “Би” үзэл ба Аялгууны бясалгал ❧

Б и үзэл юунаас гаралтай вэ? Би үзэл гэдэг нь хувь хүний зан төлөв, аливаад хандах хандлага гэж хэлж болох юм. Хувь хүний зан төлөв юунаас бүрэлддэг вэ? Хувь хүний зан төлөв гэдэгт тийм сүртэй юм байхгүй; энэ бол бидний жинхэнэ Мөн Чанар биш, бидний гэгээрсэн Бурхан Чанар ч бас биш юм. Энэ бол бидэнд зогсолтгүй хуримтлагдаж ирсэн дадал зуршлаас төрж гарсан хувь хүний зан төлөвийг л хэлж байгаа юм. Бид хүн төрөл авсан ч бай, зэрлэг амьтан, Диваажингийн төрөлтөн, тамын амьтан, гэрийн тэжээвэр амьтан эсвэл чөтгөрийн төрөл авсан ч бай ялгаагүй, тодорхой дадал зуршлыг эзэмшдэг. Төрөлтөн болгонд өөрийн гэсэн дадал зуршил байдаг бөгөөд тэд бүгдэд бид суралцдаг.

Бид урьд өмнө нь маш олон дадал зуршлыг хуримтлуулсан. Төрөл арилжих бүртээ бид дэндүү олон харгис хэрцгий үйлдлийг дуу бичлэгийн хуурцагт хураах шиг бичиж тэмдэглэсээр явдаг. Товчлуур дармагц тэр нь эргээд тоглодог. Товчлуур гэж юуг хэлж байна вэ гэхээр тэдгээр бичлэгүүдийг аяндаа эргэж тоглоход хүргэж буй аливаа боломж, тохиолдлыг хэлж байгаа юм.

Тиймээс зарим үед бид хүмүүст ширүүн ханддаг ч яагаад гэдгээ мэддэггүй. Энэ нь товч дарагдсанаас болсон хэрэг. Урьд нь хэн нэг хүн таныг гомдоохоор зүйл хэлсэн байлаа гэхэд одоо түүнтэй төстэй зүйлийг сонссон даруйдаа уурлан гонсойдог. Эсвэл биднийг урьд төрөлдөө хүн эсвэл амьтан байх үед хэн нэгэн нь бидэнд урхи тавьсан байж болох. Үүнээс болж урхи харагдах л бол юу ч байсан бидэнд айдас төрүүлдэг. Зарим нэг төрлийн хайрцаг бидэнд яагаад айдас төрүүлдгийг бид ойлгодоггүй. Гэтэл тэр



хайрцгууд урьд төрөлд маань учирсан урхитай төстэйгээс бид айж зэвүүцдэг байна. Тиймээс зарим хүмүүс дугуй тавилгыг илүүд үзнэ, дөрвөлжин тавилгыг үзэн ядна эсвэл гурвалжин тавилгад дуртай байна. Энэ бүхэн урьд төрөлд төрж байсан сэтгэгдэлтэй холбоотой.

Бидний дуртай эсвэл дургүй, жигшин зэвүүцдэг эсвэл ихэд дурладаг нөхцөл байдлууд нь би үзэл гээчийг бүрдүүлдэг. “Би” зөвхөн ийм л байвал дуртай, энэ “миний” таашаалд нийцэж байна гэдэг. Үүнийг л “Би үзэл” гэдэг юм. “Би үзэл” гэдэг нь хувийн зан чанар гэсэн үг юм. “Миний” дадал зуршил ийм тийм, “би” ингэж боддог, “би” өөрчлөгдөж чадахгүй, “би” өөрчлөгдөхийг хүсэхгүй байна, эсвэл “би” ийм л хүн, “би” өөрчлөгдөж чадахгүй гэх. Үүнийг л “би” үзэл гээд байгаа юм. Гэвч үнэндээ “би” үзэл нь хувь хүний шинж чанар бөгөөд ямар нэг нууц тайлагдашгүй зүйл биш билээ.

Бид ямар нэг зүйл хийх, эсвэл шинээр юм сурах бүрт бидний тархинд шинэ материал хадгалах шинэ суваг үүсдэг. Өш хонзон дайсагналд энэ сувгийг, хайр дурлалд үүнийг, атаархал хардалтанд үүнийг, нэр хүнд ашиг хонжоог хадгалахад үүнийг. Цэг бүр өөр өөр шинж чанарыг хадгална. Дадал зуршлыг хэдий их цуглуулна төдий олон хайрцаг буюу сувгууд бидний тархийг дүүргэж байдаг.

Угтаа эдгээр хайрцаг буюу сувгууд өөрсдөө устаж үгүй болох боломжтой. Энэ нь маш энгийн. Хэрэв тархинд юу ч байхгүй бол тэр сувгууд бүгд уусч, юу ч үгүй болно. Гэхдээ бидний тархинд тэдгээр хайрцаг сувгуудыг дүүргэгч саарал эд хэмээх бодис байдаг. Бүх шинэ санаа, үйлдлүүд энэхүү саарал эдэд тэмдэглэгдэж, тархин доторх хоосон сувгуудыг дүүргэдэг бөгөөд энэ нь тэмдэглэлээ хадгалж үлддэг компьютертэй тун адил юм.



🌀 Зөвхөн Аялгууны бясалгалын хэлбэлзэл л үйлийн үрийг угаадаг 🌀

Бид шинээр сурсан зүйлс болон шинж чанаруудаа хэзээ ч арилгаж чадахгүй. Тиймээс дотоод дахь муу дадал зуршлаа угааж урсгахын тулд Арьяабалын аргаар хичээллэх хэрэгтэй. Тэдгээрийг цэвэрлэх өөр арга байхгүй! Хүний тархийг угаана гэж та нар олонтаа сонсож байсан. Гэхдээ дан үг хэлээр тархийг угаах нь хангалтгүй. Бидний тархи маш жижиг ч бүх зүйлийг бичих хязгааргүй их санамжтай. Гай нь үүнд л байгаа юм. Хэтэрхий их зүйлийг биччихсэн болохоор тэдгээрийг хангалттай хурдан арилгах боломжгүй. Бид өдөр бүр анхаарал сарниулсан зүйл бодож байдаг нь хэтэрхий олон зүйл бичиж авснаас болжээ.

Аръяабалын бясалгалын арга нь үг хэл биш бөгөөд тэр бол бидний будлиантай бодол, буруу үзлийг угаан цэвэрлэдэг хэлбэлзэл, цахилгааны урсгал, Бурханлаг хүч юм. Тэр бидний дотор шинээр ямар нэг хайрцаг, сувгийг нэмэхгүй. Үүний учир нь хэрвээ бид тодорхой нэг бодлыг устгахаар өөр нэгэн бодлыг ашиглавал эсэргүүцэлтэй тулгарна. Хуучин бодол чинь устчихлаа гэсэн үг биш! Үгүй, харин ердөө л дахиад нэг бодол нэмсэн хэрэг болно. Үүний дүнд бидний тархи улам их юмаар дүүрч сэтгэл илүү тавгүй болно. Тиймээс ч “Хэдий чинээ их юм сурч мэднэ, Бурханы хутгийг олоход төдий чинээ хэцүү болно” гэж оюун санааны бүх агуу их Багш нар сургаж байжээ. Их мэдэх нь бидний дотоодод элдэв юмсыг овоолж, чихэхээс өөр нэмэргүй, юу ч хөгжих боломжгүй болгодог. Сайн муу хоёр холилчихоод, сайн нь хөгжихөөргүй, муу нь арилахааргүй бүр илүү бөглөрөн түгжигддэг. Их юм мэддэг хүн гэгээрэхэд илүү хэцүү байдаг гэдгийг та нар одоо ойлголоо!



Тиймээс зөвхөн Арьяабалын арга л учир зүйн ухаанд нийцнэ. Учир нь тархинд маань зөвхөн шинээр юм нэмэхээс цаашгүй Зэн оньсого, уншлага мөргөлтэй энэ арга адилгүй. Үүний оронд бид харин угаан арилгадаг. Тийм учраас би та нарт Ариун Нэрсээ уншиж Гэрэл ажихыг заасан ч Аялгууны бясалгалгүйгээр энэ бүхэн үр дүнгүй гэж хэлдэг. Ариун Нэрсээ уншиж Гэрэл ажих нь бусад юмсыг хяналтын дор авч, ертөнцийн элдэв хямрал бухимдлыг мартуулах ач тустай ч, тэр нэмэгдэл зүйл нь тархинд бас л нэмэгдэн бүртгэгдэж байдагт учир байна. Тухайлбал, Бид хэн нэгэн хүнд уурлаж, түүнээс хариугаа авах эсвэл түүнийг загнахыг хүсч байна гэж бодъё. Харин Ариун Нэрсээ уншмагц бид дайсагналаа мартана. Энэ бол эдгээр ач тустай Ариун Нэрс нь будлиантай бодлоо хянаж, тийм бодлууд бидэнд түвэг удахаас хамгаалж тусалдаг гэсэн үг. Түүнээс биш, Ариун Нэрс эсвэл Авид Бурханыг уншсанаар тэр бодлууд цэвэрлэгдэх буюу ор мөргүй алга болсон хэрэг биш ээ. Тийм биш! Бид будлиантай бодлоо удирдахын тулд Ариун Нэрсийг

өдөр бүр хэдэн арван мянгаар уншиж нэмсээр байдаг. Үүний дараа бид Аялгууны бясалгалаар тэдгээр бодлыг, Ариун Нэрсийг ч хамтад нь арилгах хэрэгтэй. (Бүгд алга ташив.) Та нар ойлгож байгаад би тун баяртай байна.

За одоо та нар “би” үзэл гэж юу болох, түүнийг хэрхэн яаж арилгахыг мэдэж авлаа. Тэр “Би” үзлийг хүчирхэгжин өсч, хана хэрэм мэт өөрийг тань хаших боломж бүү олго. Хэрвээ тэгвэл өөрийгөө та ийм л шинжтэй, тийм л хүн гэж итгэх болдог юм. Тэр чинь нөгөөх “би” хэмээх үзэл юм. Та буруу зүйлсээ үргэлжлүүлэн хийсээр л байх бөгөөд яваандаа улам дордох болно. Хэрэв хэн нэгэн хүн үүнийг тань зогсоохгүй бол та бүр дордоно. Тэгээд үүнийгээ болоод байна гэж бодон баяртай байх болно. Энэ нь эцэстээ яг л архи, тамхины дон адил зуршил болж хувирна. Биедээ муу гэдгийг мэдсээр байж хүмүүс улам их архи, тамхи хэрэглэж, уг зуршилдаа улам хүчтэй хүлэгддэг билээ.



Ийм л учраас бид даруу төлөв байж сурах хэрэгтэй. Бид олон төрөлдөө цуглуулсан дадал зуршлаа улам нэмэгдүүлж, хожим бүр яагаад ч засахын аргагүй болтол нь өөгшүүлэх хэрэггүй. Бидэнд асар олон муу зуршил хэдийнээ хуримтлагджээ. Тэднийг багасгахын оронд улам ихэсгээд байвал яаж хянаж дийлэх юм бэ? Бид хүссэн ч тэднийг багасгах аргагүй. Хэзээ бид тэднийг барж дуусах вэ? Бид маш ихийг цуглуулсан байна. Шинэ дадал зуршилтай болохоос зайлсхийхэд хэдийнээ ийм бэрх байхад, төрөл төрөлдөө хураасан тэдгээр бат бөх дадал зуршил, зан заншлыг арилгахын тухайд бол санасны гарз. Чухам ийм л учраас дээр дурдсан тэрхүү орчлонгийн хэгийдсэн хүч буюу Аялгууны Бясалгалын хэлбэлзлийг ашиглан тэднийг түргэн угааж цэвэрлэх хэрэгтэй байдаг. Ердийн нэг тархи угаалт ямар ч ашиггүй. Зөвхөн Аялгууны бясалгал л жинхэнэ “тархи угаах” арга мөн. “Би үзлээс яаж зайлсхийх вэ? гэж та нар надаас асуудаг. Аялгууны бясалгал илүү хийхийг би та нарт зөвлөж байна.

Хэрэв та нар ухамсарлаж байвал өөрсдийгөө засаж хянахыг хичээгээрэй. Илүү зуршил нэмж эсвэл зуршлаа давтах хэрэггүй. Хэрэв зайлсхийж чадаж байгаа бол түүнийг зогсоо. Харин “би” үзлээ мэдэхгүй байвал бид түүнийгээ яаж ч чадахгүй. Энэ бол бүр ч дор. Бид Аялгууны бясалгалыг илүүтэй хийх хэрэгтэй!

Аялгууны бясалгалыг илүүтэй хий!
Аялгууны бясалгалыг илүүтэй хий! Энэ бясалгал биднийг аяндаа цэвэрлэдэг. Үүнээс өөр ямар ч арга байхгүй. (Бүгд алга ташив.) Арьяабалын арга үнэхээр агуу гэдгийг та бүхэн одоо ойлголоо! Үүнгүйгээр бид өөрсдийн үй түмэн дадал зуршлаа угаан цэвэрлэж чадахгүй юм. ²²

²² Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1989 оны дөрөвдүгээр сарын 29 (Хятад хэлээр)



❧ **Удмын генийн ул мөрийг арилгадаг арга** ❧

Балар эрт үеэс хүн төрөлхтөн тоолшгүй олон муу зүйлийг хийсээр иржээ. Тиймээс ДНХ –гээс муу мэдээллийг арилгах нь тун хэцүү бөгөөд заримдаа бид өөрийн эрхгүй өвлөж авсан энэ маш их хэмжээний муу сайн мэдээлэл тэмдэглэгдсэн биед төрдөг. Бясалгаж, ул мөргүй арилган цэвэрлэхээс өөрөөр бид үүнийг яаж ч чадахгүй. Өдөр бүр ямар нэг хэсгийг арилгаад байвал эд эсэд маань тэрхүү сөрөг зүйлийн ул мөр ч үлдэхгүй. Тэгээд бид сайн зүйлийг хийж чаддаг болно.

Тийм учраас хэдийгээр та Бурхан чанартай, таны дотор Бурхан оршдог ч, эсийн түвшин дэх ДНХ-ийн тэмдэглэлүүдтэй тэмцэх ёстой болдог. Ийм шалтгаанаас болж л та ажилд

хойрго байж; олиггүй загнаж, бүр хүсээгүй байсан хэрнээ л сөрөг муу зүйл хийгээд байдаг. Иймд бид хэчнээн сайн юм хийе гэж хүсээд ч, эд эсийн ДНХ дэх тэмдэглэлүүдийг арилгах Бурханы хүч үгүйгээр, бясалгалгүйгээр, бид дорвитой зүйл хийж чадахгүй.

Тийм ч учраас дэлхийн байдал иймэрхүү байна. Тийм ч учраас сайн үйл хийхийг хүсдэг хүн хэчнээн олон ч, энэ биед ирэхээс бүр өмнө бүрэлдчихсэн байдаг махан биесийн сөрөг ул мөртэйгээ тэмцэж чаддаггүй. Тэдгээр нь аль хэдийнээ тэр биед байж байдаг. Яагаад та нар бясалгаж, цагаан хоолтон байх ёстой, мөн тэгснээр өөрийн угийн муу ДНХ дээр сөрөг ул мөр нэмэхгүй байхын шалтгааныг одоо ойлгож байгаа биз. Та нарт муу зүйл хангалттай байна, түүнээс илүүгийн хэрэг байхгүй. Та удаан бясалгаж чадахгүй байгаа бол бас л ДНХ. Магадгүй та урьд нь бясалгаж байгаагүй удмын



бие авсан байх. Өвөг дээдэс, элэнц хуланцаас чинь аваад гэр бүлд чинь бясалгаж байсан хүн нэг ч байхгүй байх. Түүнчлэн одоо цагт боломжийн гэр бүлүүд үргэлж жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэглэж, үр хөндүүлэх гэх мэт зүйлс хийдгээс болж заримдаа тохиромжтой гэр бүлд төрөх боломж олддоггүй. Тэгээд л та аль олдсон гэр бүлдээ төрж, муу ДНХ авдаг. Даанч харамсалтай. Энэ бол муу мэдээ. Гэхдээ сайн мэдээ бол бид Гэрэл болон Аялгуун дээр бясалгаж тэр бүхнийг арилган устгаж чадна.

Тийм учраас л бид энд байгаа хэрэг. Би та нарт мухар сүсэг яриагүй, намайг шүт гэж хэлээгүй, эсвэл мөнгө өөр юу ч байдаг юм түүнийгээ надад өг гээгүй, надад итгээрэй. Энэ бол зөвхөн таны өөрийн болоод дэлхий ертөнцийн тусын тулд юм.

❧ Өөрийгөө уучилж дахин оролдоод үз ❧

Будда энэ дэлхийд ирэхээсээ өмнө хэдийн Будда байсан ч зургаан жил бясалгах шаардлагатай болсон. Есүс Эзэн Бурханы хүү байсан ч энд ирж Төгс багш болохоосоо өмнө өөр өөр багш нараас суралцаж, цөлд бясалган арав гаруй жилийг өнгөрөөжээ. Энэ бол нөгөө ДНХ-гийн л гай! Бидний сайн муугаас ч болсон юм биш. Зүгээр л, бидний өвлөж авсан багаж зэмсэг заримдаа бодож байсан зүйл маань биш байж таардаг. Тиймээс өөрийгөө уучил, харин хэзээд дахин хичээгээрэй.²³

²³ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Бангкок, Тайланд, 1994 оны арваннэгдүгээр сарын 14, (Англи хэлээр)

Бид илүү эерэг, өөдрөг, зоригтой сэтгэдэг
байх хэрэгтэй. Тэгвэл энэ нь дадал зуршил
болж хувирна, учир нь бүх зүйл бодлоос
үүсдэг.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ~



Жинхэнэ бясалгал байнга явагдаж байдаг.

– Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай





Зарим
өчүүхэн
нууцаас
хуваалцах
нь





БИЕ, ХЭЛ, СЭТГЭЛЭЭ ХАМТАД НЬ ХӨГЖҮҮЛ

Заримдаа та нар бясалгалдаа ямар ч ахиц дэвшил гаргалгүй, цагаа дэмий үрж байгаа мэт санагдаж байж мэднэ. Яагаад гэдгийг мэдэх үү? Оюун санааны дадал бясалгал нь бие, хэл болон сэтгэлийг багтааж байдаг юм. Жишээ нь: Та оюун санааны бясалгалдаа өөрийн сэтгэлийг сайтар хөгжүүлж, атгаг санаа, ариун бус бодлоос ангижирчээ. Тэгээд өдөр бүр амьд сэрүүн Их Багш, ариун сургаалаа санаж, зөвхөн Аръяабалын бясалгалын тухай боддог байж. Ийм тохиолдолд таны сэтгэл маш их дэвшин, “соёлжиж иргэншсэн” байхад бие тань хөгжлөөр



хоцорсон хэвээр, сэтгэлийн хөгжил дэвшилтэй нэгэн түвшинд бус байж болох юм. Энэ үед таны оюун санааны дэвшил зогсонги байдалд орсон мэт санагдаж мэднэ. Зарим тохиолдолд таны бие, сэтгэл ариун байлаа ч үг хэл тань үйлийн үрээсээ хараахан цэвэрлэгдээгүй байж болно. Өөр нэгэн тохиолдолд, та хэсэг үе дуугүй байж, ердийнхөөсөө бага ярьж байж. Гэсэн ч таны бие үйл түйтгэрээсээ цэвэрлэгдээгүй болохоор та ямар ч ахиц, дэвшил гаргаж чадахгүй байх жишээтэй.

Үүнийг хүүхдүүдтэйгээ хамт алхаж яваа эцэг эхтэй зүйрлэж болох юм. Эцэг эх нь маш хурдан алхаж, харин хүүхэд нь замд таарах цэцэг, чулуу, гол горхинд сатаараад цугтаа явахаа мартчихна. Тиймээс эцэг эх нь зогсож, хүүхдээ гүйцэж иртэл нь хүлээх болдог. Бие, хэл, сэтгэл ч үүнтэй адил. Хэрэв аль нэг нь хоцорвол нөгөө хоёр нь цааш явж чадахгүй. Оюун санааны дадал



бясалгалд ахиц дэвшил гаргахын тулд энэ гурав (бие, хэл, сэтгэл) бүгд тэнцвэртэй, харилцан уялдаатай байх ёстой.²⁴

²⁴ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Шинтен, Формоса, 1986 оны наймдугаар сарын 22 (Хятад хэлээр)



Уур бясалгалд саад болно

Арьяабалын аргаар бясалгахад яагаад заримдаа Аялгуу сонсдог ч Гэрэл хардаггүй вэ? Яагаад гэвэл таны зурагт эвдэрчихжээ. Тиймээс зурагтаа маш хичээнгүйгээр өдөр бүр засаж сэлбэх хэрэгтэй. Яаж засах вэ? Бие, хэл, сэтгэлээ цэвэр ариун байлгах ёстой. Бид хэнийг ч үзэн ядалгүй, бүхнийг тэвчиж өнгөрүүлэх хэрэгтэй. Хүмүүсийн бидэнд яаж хандах хамаагүй, бид тэдэнд тэсвэр тэвчээр, хайраар л хандах ёстой. Энэ бол эвдрэлээ засах арга зам мөн.

Бидэнд яагаад эвдрэл байдаг вэ? Яагаад гэвэл, бидний уур уцаартай байдал маш хатуу оршихуйд хувирдаг. Энэ нь биднийг халхлан, Үнэн ёсноос тусгаарладаг. Тиймээс энэ бүх эвдрэл биднээс л болжээ. Бид уурлахаараа маш

нягт бөгөөд тааламжгүй соронзон орныг бий болгодог. Энэ зузаан, харанхуй, тааламжгүй соронзон орон нь биднийг хаалт мэт бүрхэн, сайн сайхан чанараас маань тусгаарлаж байдаг. Энэ нь маш ойрхон, яг хувцас шиг, ихэд хиртсэн өмсгөл мэт биднийг нөмөрч, сайн соронзон оронтой холбогдох аргагүй болгодог. Тиймээс бид Бурханы гэрэлт орныг харалгүй, зөвхөн зовлонг үйлийн үрийг л хардаг юм.

Тиймээс бид бие, хэл сэтгэлээ ариусгаж мөн хэмхэрхий зурагтаа засаад, өдөр бүр үзэхийн тулд сахилаа сахих хэрэгтэй. Биет зурагтыг үзэхэд кабель, суваг, программ хэрэгтэй байдаг бол дотооддоо зурагт үзэхэд эдний аль нь ч хэрэггүй. Бага зэргийн засвар л байхад болчихно. Бид зурагтаа өдөр бүр үзэж байх хэрэгтэй, тэгснээр бид дадлагажиж, түүнийг аль хүссэн үедээ ашиглах боломжтой болно.²⁵

²⁵ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Тайнан, Формоса, 1989 оны тавдугаар сарын 21 (Хятад хэлээр)



Өөрсдийгөө үргэлж өөдрөг ариун авч яв

Бид хэрхэн яаж амьдарч буйдаа тун хянамгай байхгүй бол болохгүй, учир нь бидний бодсон бүхэн биелж, бүтэж байдаг. Олиггүй муу бодлоос сөрөг уур амьсгал үүсч, өөрсдөд маань болоод бидний эргэн тойронд байгаа хүмүүст гай тарьдаг. Бид хаа явсан газраа үүнийгээ тээж явдаг. Зүйрлэвэл, хэн нэгний цүнхэндээ авч яваа хор нь гоожиж байх юм бол зөвхөн өөрийгөө төдийгүй ойр орчмын хүн болгоныг хордуулдагтай адил юм. Хорон санаа бол хор уршигтай кино болоод хорт бодисын аль алинаас нь илүү муу үр дагавартай зүйл. Юу бодож буйдаа тун хянамгай хандаж байгаарай. Хэрэв олиггүй бодол орж ирвэл дор нь тархинаасаа гаргаж хаяад, Ариун Нэрсээ уншиж төвлөрөн, өөрийгөө ариусган, амьдралын тань мөч хором бүрт Эзэн Бурханаас хайрлаж буй

адислалд баяс. Та эрүүл энх, амьд мэнд буйдаа, харьж очоод алжаал тайлах сайхан газартайдаа, эдэн шиг, над шиг сайн найз нөхөдтэй байгаадаа талархаж бай. (Алга ташив.)

Миний хувийн хэрэгцээнд зориулж ямар нэг зүйл хийхийг би та нараас хэзээ ч гуйж байгаагүй. Та нарын төлөө хийдэг бүх зүйлийг би сайн дураараа, хүслээрээ, дуртайяа хийж байдаг юм. Та нар надаас үргэлж “Багш аа, бид яаж Таны ачийг хариулах вэ?” гэж асуудаг. Тэгэх шаардлагагүй. Надад юу ч төлөх хэрэггүй. Ердөө л өөрсдийгөө ариусган, өөрсдийнхөө ажил хэрэгт санаа тавьж, харин надад өөрийнхөө ажлыг хийх боломж олго. Ингэх нь их хялбар. Хэрэв надаас өө сэв хайсаар байвал та нар сайжрахгүй. Хөршийнхөө хог новшийг уудалж байгаа хүн өөртөө хор хүргэж байгаа хэрэг, ердөө л тэр. Та нар хөршийнхөө хог уруу өнгийнө үү, ер юу л хиймээр байна би хорихгүй. Гэвч ингэх нь танд нэмэртэй сайн эсэх талаар та бодож үзэх



хэрэгтэй.

Хэн нэгний тухай сөрөг зүйл бодоход танд тааламжтай байдаг уу? Үгүй. Хэзээ ч сайхан байдаггүй. Гэхдээ миний үгэнд итгэх албагүй. Өөрсдөө шалгаж үзээрэй. Хэн нэгэн хүнд уурлаж түүний тухай муугаар бодох бүрт, үнэн худлаас үл хамааран хамгийн тухгүй байдалд хэн ордог билээ? Хамгийн түрүүнд бид өөрсдөө. Тиймээс энэ нь маш амархан.

Гэхдээ өөрсдийгөө хянахад тун хялбар. Ердөө л шууд дотоод уруугаа хандаж, Ариун Нэрсээ уншин, Багшаасаа тэр даруйд тусламж эрэн, сайн бодол хайрлаач, эсвэл муу бодлыг хайрын сэтгэлээр сольж өгөөч хэмээн залбирч байгаарай.

Гэвч заримдаа уурлах нь зөв гэж итгэсээр байж, уураа гаргах хэрэггүй гэж байгаа юм биш. Итгэлтэй байвал, өөрийгөө шууд илэрхийл.

Жишээ нь: Хэн нэгэнд уурласан бол түүнд шалтгаанаа хэл. Гэхдээ та эхлээд юмыг үнэн эсэх, учир зүйтэй эсэх, үнэхээр тэгэх хэрэг байгаа эсэхийг шалгаж үзэх хэрэгтэй. Тэр хүн таныг уурлуулснаас болж та бухимдсан бол түүнд хэл. Ядаж л танд тайлбарлах, эсвэл тантай учраа олох боломжийг түүнд олгох хэрэгтэй. Тэр хүнийг зөвхөн өөрийнхөөрөө бодож, дээд эсвэл доод дэсийн ухамсраараа шүүж дүгнэхичээд тэр хүн өөрийн чинь юу ярьж явааг мэдээ ч үгүй байхад нь өөр хүнд түүний тухай ярих хэрэггүй. Гуравдагч хүн бүр яаж ч чадахгүй. Зүгээр л тэр хамаг хог новшийг сонсож суухад хүрнэ. Тэр хүн үүний тухай юу ч мэдэхгүй шүү дээ. Тэгээд магадгүй дөрөвдөгч этгээдэд ярина. Ингээд л Төв тэр чигтээ хог новшоор дүүрнэ.

Заримдаа та юу болсныг ярихгүй ч дотроо боддог. Энэ бас л сайн юм биш. Тийм үедээ та Эзэн Бурханд хандан “Надаас энэ хорыг зайлуулж өгөөч” гэж залбирсан нь дээр. Тэгэхгүй



бол та эргэн тойронд байгаа бүх хүнээ хордуулна. Учир нь бодол, үйл, хэл яриа адилхан. Аль аль нь хүчтэй. Ялангуяа төвлөрсөн үед бүр хүчтэй байдаг. Заримдаа үйл түйтгэр илэрч хэн нэгэнтэй сөргөлдөхөд маш их залхаж ядардаг. Өглөө өөрийгөө харахад царай чинь бараан харагддаг. Ямар нэг хортой зүйл дотор чинь оршиж, биеэр чинь тархаж, таныг маш их ядрааж, та түргэн өтөлж, залуу сайхан харагдахаа больчихсон ч юм шиг мэдрэмж төрнө. Тиймээс өөрийгөө өөдрөг бөгөөд ариун авч яв. Ингэвэл танд хамгийн сайн.

Заримдаа яах ч аргагүй үе танд гарна. Жишээ нь: Та хэн нэгэнтэй амьдардаг, тэр хүн танд үргэлж түвэг удаж, та хоёр үл ойлголцдог бол хоорондоо учраа олох хэрэгтэй болно. Гэвч энэ тохиолдол бол таныг ерөөс таньдаггүй, та тэр хүний талаар сөрөг зүйл боддог гэж гадарлах ч үгүй тийм хүний тухай муу юм бодохтой огт адилгүй. Таны бодож байгаа чинь худлаа ч юм билүү. Үнэн байсан ч үйлийн үрийн хууль яаж

үйлчилдгийг та нар мэдэхгүй. Эзэн Бурхан энэ болон тэр хүнд зориулж ямар зорилгоор юуг, яаж зохицуулж байдгийг та нар үл ойлгоно. Та нар юу ч мэдэхгүй. Тиймээс зүгээр л амаа хамхисан нь дээр. Бодоод байгаа юмаа боль. Ариун Нэрсээ уншиж эергээр сэтгэ. Учир нь эерэг юм бодлоо гээд танд алдах юм байхгүй. Та сөрөг юм бодох бүртээ хохирч байдаг. Ердөө л тэр. Энэ бол өөрийн тань л тусын тулд юм. Би танд үүнийг хориглож, эсвэл Бурхан таныг шийтгэх гээд байгаа хэрэг биш. Хүн бүхний тухай үргэлж эергээр бодохыг хичээж байвал амьдрал чинь хамаагүй сайхан байх болно.²⁶

²⁶ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Лос Анжелес, АНУ, 1997 оны долдугаар сарын 5 (Англи хэлээр)



Цэвэр ариун хоол идэхийг хичээ

Өөрийгөө бохирдуулж тархи, эд эсээ самууруулахгүйн тулд юу идэж байгаадаа хянуур бай. Учир нь эдгээр зүйлүүд таны оюун санааны дэвшилд саад болно. Энэ нь бидний юу идэхийг Бурхан хамаарч буй хэрэг биш. Гэхдээ бид мансууруулан согтоох зүйлс, мах эсвэл амьтны гаралтай бүтээгдэхүүн зэрэг бузар хоол хүнсээр өөрийн эрхтэн тогтолцоог хордуулбал бидний бие болоод тархины эд эс бохирдож самуурах болно. Улмаар бид саруул ухаанаа алдаж, аз жаргал билиг ухааныхаа эх сурвалжийг олох гэж амгалан тайван суух аргагүй болно.

Бид эд эс, тархи, цусаа бохирдуулбаас “мэдрэл, эмзэг хэсгүүд” ч бас самуурч будилна. Түүнээс болж эрүүл, саруул сэтгэн бодох

чадвараа алдаж, бясалгаж суух үедээ тэвчээргүй, түгшүүртэй байх болно. Сайн сууж бясалгасан ч байсан, биедээ тээж яваа хортой зүйлийн сөрөг нөлөөллөөс бидний ахуй ойлголт бүрхэг болно. Тиймээс бидний юу идэхийг Бурхан хамаарч байгаа биш, та нарын юу идэхийг би хамаарч байгаа биш, эсвэл бага зэрэг мах идсэнээр шууд тамд тонилох биш. Энэ тийм биш ээ. Харин ердөө, бид Бурхан шиг байя гэвэл үйлдэл бүхнээ анхаарч байх ёстой; бие, хэл, сэтгэлээрээ цэвэр ариун болохын тулд идэж байгаа бүхэн маань цэвэр ариун байх ёстой юм.

Би та нарын юу идэж байгааг хамаардаггүй. Гэсэн ч юу л иднэ, тэр зүйл чинь та нарын бясалгал, сэтгэл санаа, ааш авир, хувь хүний шинж төлөв, зан төрх, амьдралын үнэлэмжинд нөлөөлдөг. Бүх юм үүнээс л шалтгаалдаг. Энэ материаллаг ертөнц дээр бид оршиж л байсан цагт бүх материаллаг зүйлс бидэнд нөлөөлж байдаг юм. Тийм ч учраас бид



өөрсдийн тусын тулд цэвэр, үйл түйтгэр багатай, зовлон бага тээсэн хоол хүнсийг хэрэглэх тал дээр анхаарах ёстой.

Амьтны зовлон маш их. Тэд үхлээс айж амьдралд тэмүүлдэг. Тэд биднээс болж цаг бусаар үхвэл, тэдний айдас түгшүүр, өс хонзон бидний иддэг маханд хадгалагдан үлдэх нь мэдээж хэрэг. Тиймээс ч бид түрэмгий, түгшүүртэй, сэтгэл амаргүй заримдаа догшин хэрцгий болдог нь нөгөө л амьтдын үхлийн өмнөх мэдрэмж юм.²⁷

²⁷ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайр айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Лос Анжелес, Калифорни, АНУ, 1997 оны долдугаар сарын 6. (Англи хэлээр)



Материаллаг ертөнцийн юмс бидэнд их бага ямар нэг хэмжээнд нөлөөлж байдаг. Тиймээс хоол хүнс ч мөн адил бидний бодол сэтгэл, бие махбод, оюун санаанд нөлөөлдөг. Тэгээд ч энэ бол аль эрт дээр үеэс нотлогдсон зүйл юм.



Өргөл барьцанд шунахын үр дагавар

Энэтхэгт таван зуун шавьтай нэгэн Багш байж гэнэ. Тэрбээр жирийн нэгэн багш байснаас биш тийм их өндөр дээд багш байсангүй. Гэсэн хэдий ч ирээдүйг харж чаддаг байж. Хоёрдугаар Түвшний л багш байсан байх. Түүнийг хүмүүс гэртээ залж, зоог өргөл барихад тэр шавь нарыгаа огт дагуулж явдаггүй байж гэнэ. Шавь нарынх нь тэвчээр бүр барагдаж, нэгэн өдөр “Багш аа, та цайллаганд явахдаа дандаа ганцаараа явах юм. Бид зөвхөн ажиллаад л, ажиллаад л, та бидэнтэй тэр сайхан таашаалаас хуваалцаж байгаа юм алга. Энэ удаад та биднийг авч явахгүй бол бид таныг орхиж явлаа шүү” гэжээ. Тэр удаа багш нь тэднийг авч явж, түүнээс цааш ч гэсэн байнга авч явдаг болсон гэнэ.

Гэтэл багш нь хойт төрөлдөө жинхэнэ бөгөөд урьд өмнөхөөсөө илүү өндөр дэсийн

алдартай лам болон төржээ. Тэгээд түүнийг хаа явсан газар нь таван зуун нал шувуу дагаж нисч байдаг байсан гэнэ. Тэр шувуу бол нөгөө урьд төрөлдөө адис хүч, ариусал бясалгал хангалтгүй байснаасаа болж хүмүүсийн өргөл барьцыг шингээх буян дутсан шавь нар нь байжээ.

Зөвхөн Багш шавь нарын хооронд төдийгүй, хүмүүсийн дунд ч ялгаа бий. Тиймээс би та нарт арвич хямгач байх, шуналгүй, өөрийн хувийг хэтрүүлэхгүй байхыг зааж сургасан. Өөрт байгаагаас илүүг хэзээ ч бүү зарцуул. Шаардлагатай үед л зарцуул. Үгүй бол аль болох үрэхгүйг хичээ. Эс бөгөөс бидэнд ямар ч асуудал гарч мэднэ. Өвдвөл яах вэ? Бүр эдгэршгүй өвчин тусч ч магадгүй шүү дээ.

Миний мэдэх нэг бясалгалтан үргэлж бусдын орлогоор амьдрах гэж хичээдэг, тэгээд тэр гортой хоол идчихээд цаг үргэлж сур харваж явдаг байсан юм! Заримдаа ариун бус хүнээс



бэлэг авбал бидэнд бас нөлөөлдөг. Энэ нөлөөг бид бүр мэдэхгүй байж болох ч, тэр хүндээ өртэй ч юм шиг болчихдог. Тэр хүнтэй уяа хүлээстэй мэт санагдаж, чухам яагаад салж зугтаж чадахгүй байгаагаа мэдэхгүй. Тэднээс бэлэг авчихсан болохоор л заримдаа тийм байдалд орчихдог. (Гэрээс гарсан биш, хоорондоо бэлэг байнга солилцож байдаг энгийн хүмүүсийн хувьд яах вэ? гэж хэн нэгэн нь асуув.) Би та нарыг шаардлагагүй бол хүнээс юм битгий авч бай, хүн өөрт чинь юм өгвөл садан төрлийн хүн ч байсан ялгаагүй эргүүлж заавал юм өгч бай гэж сургасан шүү дээ.⁹

⁹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайр айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Коста-Рика, 1991 оны зургадугаар сарын 2 (Англи хэлээр)

Эерэг энергийн гэрлэн хүрээ үүсгэ

Бясалгасан газар бүхэнд чинь энерги үлддэг. Тийм ч учраас өөрийгөө сайн энергээр хүрээлүүлэхийн тулд цаг үргэлж сайн үйл хийж байх ёстой. Бясалгалын тухай, Эзэн Бурханы тухай, Их Багшийн адис хүчний тухай, эерэг сайн сайхан зүйлийн тухай ярихад ч хүртэл сайн энерги үүсч байдаг. Тиймээс та нарыг бясалгахад сайн энерги үүсч, тэндээ үлддэг нь дамжиггүй юм. Тэр газраа хэдий чинээ их бясалгана, энерги нь улам нэмэгдэнэ. Хэдий чинээ эерэг зүйлийн тухай ярина, өөрийг тань хүрээлэх эерэг энергийн хана төдий чинээ зузаарна. Тэгээд ижил зүйл харилцан таталцдагаас болж танд зүг бүрээс зөвхөн сайн энерги улам ихээр ирнэ. Ийнхүү хаа явсан газартаа та энэхүү халаас дүүрэн энерги буюу сайн энергийн гэрлэн бүрхүүлийг тээж явдаг юм.

Хэдий чинээ их эерэг энерги та тээж явна, төдий чинээ сайхан мэдрэмж танд төрж байдаг.



Ингэж сайхан санагдахын хэрээр та эерэг зүйлсийн тухай илүүтэй ярина. Эерэг сайхан зүйлсийн тухай ярихын хэрээр эерэг сайн үйлийг хийж, илүү сайн сайхан энергийг үүсгэж байдаг. Сайн сайхан энергийг та үүсгэх тусмаа танд илүү сайхан санагдана. Тэгээд л та сайн сайхан зүйлийг хийнэ. Ийнхүү энэ нь хэзээ ч төгсөхгүй.

Иймд сөрөг орчилд хэзээ ч бүү ороорой. Эерэг л байгаад бай. Ингэх хэцүү гэдгийг би мэдэж байна. Учир нь заримдаа хүмүүс өөрийг чинь доош татна. Гэхдээ сэрэмжтэй байх хэрэгтэй. Сонор сэрэмжтэй л бай. Тэгээд цаг үргэлж эерэг өөдрөг байхыг хичээ. Чадахын хэрээр эерэг юм хэлж, эерэг зүйл хийгээрэй. Өөрийгөө хамгаалж, гайхалтай сайхан гэр үүсгэн, тэрхүү хөдөлгөөнт гэрийнхээ хамт Гэрэл гэгээ, сайхан энерги, сайн хэлбэлзэл тээж яваарай. Тийм энергийг та хэдий чинээ ихээр тээж явна, төдий чинээгээр эерэг зүйлийг өөртөө татаж, эерэг зүйл өөртөө татах тусам та улам хүчирхэг, улам эерэг болно.²⁸

²⁸ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын гурав хоногийн дияан бясалгалын үеэр, Лос Анжелес, АНУ, 1998 оны арванхоёрдугаар сарын 16-наас 18, (Англи хэлээр)

Бэлгийн дур хүслийг багасгах арга

■ Багш аа, би өөрийнхөө бэлгийн аймаар их дур хүслийг яаж дарах вэ? Надад Бурханы аврал хэрэгтэй байна.

Б: Надад энэ тал дээр туршлага байхгүй юм байна. Олон янзын арга чарга байдаг юм билээ. Гэхдээ ихэнх хүний хувьд хэт их мах идэж, дарс хэтрүүлэн хэрэглэснээс дур хүсэл нь илүү хөдөлдөг. Бидэнд амьтан маягийн хүсэл тачаал хангалттай байдаг болохоор бид амьтан шиг аяглах нь их. Бид үүнийг хянаж чадахгүй. Бид энэ бие махбодын улмаас амьтны ертөнцөд хагас харьяалагдаж, амьтан чанарыг уламжилж авсан.

Иймд одоо үүнийг хяная гэвэл мансууруулах зүйл, өдөөгч хоол хүнсийг багасгах хэрэгтэй болно. Бэлгийн чалх сайжруулдаг хоол хүнс гэж байдаг. Хүмүүс түүнийг эрж хайж байдаг



юм. Зарим хүн үүнд дуртай. Хөгшин хаад олон эхнэртэй байсан учраас иймэрхүү хүнс байнга хэрэглэдэг байжээ.

Харин бэлгийн дур хүслийг багасгах хоол хүнс их бий. Анхны алхам бол цэвэр цагаан хоол идэж - өндөг, загас идэхгүй, архи дарс аливаа мансууруулагчийг хэрэглэхгүй байх. Эгэл хүмүүсийн мөнгөө үрдэг олон зүйл бол зүгээр л цэвэр хор юм. Хүмүүс яагаад өөрийгөө хордуулах зүйлд ийм их мөнгө зардаг юм бол гэж би их гайхдаг. Гэвч энэ тэдний хувийн эрх чөлөөний асуудал юм даа.

Иймд та бэлгийн хүслээ яаж хазаарлах тухай надаас асууж байгаа бол танд хийх зүйл их байна. Цагаан хоолтон болж, тос багатай элдэв хурц амтлагчгүй энгийн хоол ид. Хүйтэн ус их уу. Оргилуун дарс ууж болохгүй! Энэ бол зөвхөн хуримын өдөрт зориулсан хамгийн аюултай эд. Та нар мэдэх үү, тийм ээ? Би бол мэдэхгүй. Тэгж

дуулсан юм. Мэдэхгүй. Хүмүүс л тийм байдаг гэх юм билээ.

Гэвч хамгийн хялбар арга бол завгүй байж, бусдын тусыг бүтээх, тэгвэл өөрийн асуудлыг мартчихна. Танд энэ дур хүслийн тухай бодох цаг зав яаж байдаг юм бол би бүр гайхаж байна. Та над шиг шөнөжин нойргүй юм уншдаг бол бэлгийн дур хүсэл чинь өөрөө алга болчих байх даа. (Хүмүүс инээлдэн алга ташив.) Яагаад гэвэл тэр чинь хулчгар, ажлаас айдаг юм.

Ямар нэг юм хий. Энэ дэлхий дээр зовлон зүдгүүр өчнөөн их байхад чөлөөт цагаараа буяны ажилд сайн дураараа оролцохгүй юм. Бусдын зовлонг мэдэр. Өөрийгөө бусдад зориулахын баяр баясгалан, тэд бүхэнд тус бүтээснийхээ төлөө мэдрэх тэрхүү хязгааргүй баяр жаргалд уусан нэгд. Хүмүүст аз жаргал - эрхэм ариун аз жаргалыг бэлэглэ. Тэр нь танд ч эрхэм ариун аз жаргалыг авчирна.




Олиггүй юм, магадгүй садар самуун мэдээлэл та их уншсан шиг байна. Одоо түүнийгээ уншихаа больж, ариун судар ном унш. Ариун ёсны амьдралын тухай ямар л ном байна, Библи, Буддын шашны судрууд, Коран зэргийг унш. За юу? Хинду ном судар, юу ч байсан болно, ёогийн дасгал, Гэгээнтнүүдийн сургаал гээд унших ном асар их байна.²⁹

²⁹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайр айлдвар, Сингапур, 1995 оны нэгдүгээр сарын 10, (Англи хэлээр)



Бясалгалд чинь саад болохгүй л бол гэрлэж болно. Оюун санааны дэвшилд чинь л саад болохгүй бол секс ч гэсэн байх л зүйл. Гэвч ихэнхдээ эдгээр нь саад болдог. Учир нь санаа сэтгэл үүнийг дийлээд гарчихаж чаддаггүй. Бэлгийн мэдрэмж бол ихэнх хүмүүсийн хувьд зохицуулахад хэцүү, их хүчтэй зүйл. Тийм л учраас ихэнх Багш нар шавь нарыгаа үүнээс зайлсхийхийг зөвлөдөг. Энэ бол архи лугаа адил хортой зүйл, уулаа гээд үхчихгүй, тамд уначихгүй. Харин өнөөдөр бага шиг уучихаад маргааш улам илүү ихийг ууна, тэгсээр бие махбод, тархи, оюун санаагаа гэмтээнэ. Иймд Их Багш “Үүнээс холуур байгаарай” гэдэг. Багш чинь хүмүүсийг хянан дарангуйлагч нэгэн болоод тэгж байгаа юм биш. Тэр зүгээр л чухам юу сайн, юу муу гэдгийг мэднэ. Харин сонголтыг та бид өөрсдөө хийнэ.





**ИХ БАГШИЙН НОМ, ВИДЕО БИЧЛЭГ
НЬ ОЮУН САНААНЫ ШИЛДЭГ
ТЭТГЭГЧ МӨН**

Их Багшийн номыг өдөр бүр унших нь Түүний өөрийн биеэр ном тайлахыг сонсохтой төстэй. Энэ нь таныг адислаж, билиг ухааныг тань нээж байдаг. Та нар мөн Багшийнхаа хуурцгийг аль болох байнга сонсож байгаарай. Жишээ нь, таны нойр хулжих юм уу, асуудал бэрхшээл тохиолдох үедээ Багшийнхаа дуу бичлэгийг тавьж сонсож болно. Унтахынхаа өмнө Багшийн бичлэгийг сонсож, номыг уншвал өглөө сэрэхдээ нэг л өөр байх болно. Багшийнхаа номыг дэрлэж унтаж бас болно. (Бид тэгж болох юм уу? гэж хэн нэг нь асуув.) Болно, ингэх нь таны



билиг ухааныг улам нээх болно. (Шавь нар инээлдэж “Биднийг Луун Бурхан Сахиулсан Тэнгэр ниргэхгүй юу? гэв.) Үгүй ээ. (“Гэхдээ Бурханы шашны сургаалд, ном судраар дэр хийхийг хориглоно гэсэн байдаг биш үү.) Би та нарт болно гэж байгаа бол болно. Би чинь орчин үеийн Багш шүү. (Шавь нар инээлдэв.)

Орчин үеийн хүмүүст цаг чөлөө маш бага болжээ. Миний номнуудыг дэрлэж унтсанаар та нар илүү сайн суралцах болно. Та нар миний номыг уншсанахаа дараа ихэнхдээ тийм ч сайн санадаггүй. Харин дэрлэж унтвал Багш тань зааж өгөх учраас та нар илүү сайн санана. Түүнчлэн тархи чинь гэжиж зүүдлэх нь бага байдаг тул та нарыг унтаагаар чинь зааж сургахад хялбар байдаг юм. (Шавь нар инээлдэв.) Би та нарын тархийг нүхэлж, илүү түргэн нэвтэрч орж чадна. Гэвч мэдээжийн хэрэг та нар номоо унших хэрэгтэй. Зөвхөн дэрлэж унтаад нэмэргүй. Өдөр бүр нэг багахан хэсгийг уншчихаад байх

хэрэгтэй. Нэг удаад дэндүү их унших хэрэггүй. Хүсвэл бүтэн номыг ч нэг өдөрт уншиж дуусгаж болно л доо. Гэхдээ өдөр бүр заавал нэг багахан хэсгийг унших хэрэгтэй. Бие махбод маань өдөр бүр хоол шаарддагийн нэгэн адил оюун санаанд маань ч шим тэжээл хэрэгтэй. Та нар мөн Их Багшийн бичлэгийг сонсож байвал оюун санааны дэвшил тань хурдасна. Та нарын дэвшил хэтэрхий удаан байна.³⁰

³⁰ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Шинтен, Формоса, 1987 оны есдүгээр сарын 6 (Хятад хэлээр)



“Ba Guan Zhai Jie” буюу найман сахилын жинхэнэ утга учир

Хэрэв танд өдөр шөнийн аль ч цагт зав гарахгүй бол унтаж байхдаа Багшийн бичлэгийг тавьж болно. Унтах зуур тань Багш ярьж л байг. Энэ бас л танд үр нөлөөтэй. Бясалгал дадалд нэмэр болох арга хэрэгсэл юу л байна тэр бүрийг бид хэрэглэх нь зүйтэй. Орчин үеийн бидэнд цаг зав бага байхын сацуу гадуур амьдрал дээр бид Маяагийн хүчний нөлөөнд байдаг. Маяа гэдэг бидний боддог шиг чөтгөрийн дүртэй зүйл биш. Маяагийн хүч гэдэг та бидний өөрсдийн үүсгэн бий болгодог уур амьсгал бөгөөд цөмийн бөмбөгийн буюу цацраг идэвхт агаар амьсгалтай эгээ л ижил. Ийм агаар амьсгал бидэнд асар хүчтэй нөлөөлнө.

Чадвал долоо хоногт нэг өдөр хоол сойхыг хичээ. Тэгэх ёстой юм. Хэрэв чадашгүй бол

нэг өдөр тархиа хоосол. “Ba Guan Zhai Jie” гэдэг буддист нэр томъёо (найман сахил) үүнийг хэлдэг. Та нар “Ba Guan Zhai Jie” гэж юу болохыг мэдэх үү? Зөвхөн хоолоо сойж, судар бичиг унших нь хангалтгүй. Арьяабалын бясалгалаар бясалгагчид “Ba Guan Zhai Jie”-г жинхэнэ утгаар нь хэрэгжүүлдэг юм. Бид өөрсдийн үйлийн үр болон гадна орчны нөлөөг цэвэрлэхийн тулд Аялгууны урсгалыг ашигладаг. Тэгээд бидэнд олдох боломж бүрийг бясалгал дадалдаа ашиглана. Бид аль ч цаг үед, хэзээ ч гэсэн оюунлагийг дадуулж байх ёстой. Унтаж байхдаа Багшийн бичлэгийг сонсож хичээллэнэ. Нийтийн унаанд Багшийнхаа бичлэгийг сонсох, бясалгах эсвэл номыг нь уншиж болно. Ингэх нь оюун санааны бясалгал дадлыг илүү түргэн сайжруулахад тус нэмэртэй.³⁰

³⁰ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Шинген, Формоса, 1987 оны есдүгээр сарын 6, (Хятад хэлээр)



“Ba Guan Zhai Jie” буюу Буддын шашны
найман сахил

1. Амь хөнөөхгүй
2. Хулгай хийхгүй
3. Садар самуун явахгүй
4. Худал хэлэхгүй
5. Согтууруулах ундаа хэрэглэхгүй
6. Бүжиг, дуу, хөгжим, цэнгээн, ганган өмсгөл,
үнэртэн, оо энгэсэгнээс татгалзах
7. Өндөр, зөөлөн ор дэвсгэрт унтахгүй
8. Үдээс хойш хоол идэхгүй



Бясалгахын өмнө видео үзэх нь сэтгэлийг тань тайвшруулж, таны олон асуултанд хариулт өгнө. Энэ нь танд маш их ач тустай. Үүнийг нэмэргүй гэж бодож, ийш тийш гүйж, элдэв өөр юм битгий хийгээрэй. Залбирлын дуу сонсож, видео үзэх нь таныг үнэндээ тун их анхаарал тавиагүй байхад ч ихээхэн тус нэмэр өгнө. Зарим өгүүлбэр нь таныг цочроож эсвэл тайвшруулах тул хааяа та анхаарал тавьдаг. Харин дэлгэцээр гарч буй ярианд та анхаарал тавьсан бол бясалгалд тань гарцаагүй ач тусаа өгнө.



Бясалгал зутрах ахуйд тамиржуулах эм заримдаа хэрэгтэй

Жихүүн хүйтэн өвөл ирмэгц бид зутардгийн нэгэн адил заримдаа оюун санааны хөгжилд саад бэрхшээл гарах нь бий. Сахил маань дээсэн дөрөөн дээр дэнжигнэж, итгэл маань тийм ч хүчтэй биш болсон мэт. Оюун санааны уналтанд эсвэл зогсонги байдалд орж, гуниглана. Энэ бол “оюун санааны дадал бясалгалын өвөл” юм. Саад бэрхшээлгүй хөгжиж буй үеэ бид “хавар” эсвэл “зун” гэж нэрлэж болно. Хавар, зун, намар, өвөл хоорондоо ялгаатай шиг бидний оюун санааны дадал бясалгалд ч бас ялгаатай үеүд байдаг. Бид өдөр бүр нэг янзаараа байгаад байж чадахгүй. Тиймээс ч бид алдаа гаргах, больчихмоор санагдах, дурамжхан бясалгах, бясалгалаасаа

уйдах үе гардаг. Сэтгэл санаагаар унаж, чухам яагаад тэгж буйгаа үл ойлгоно. “Оюун санааны дадал бясалгалын өвөл” иймэрхүү шинж тэмдгээр илэрдэг. Ийм үед бид хурдхан тамиржуулах зүйл хэрэглэж, шим тэжээл өгөх хэрэгтэй.

Жишээ нь, чийгтэй хүйтэн өвөл бие суларч, сайнгүй байвал хятадын уламжлалт эмчид үзүүлж, эм тэжээл авч болно. Аль эсвэл илүү шим тэжээлтэй хоол хүнс хэрэглэх буюу өдөрт нэг удаа илүү хооллож, хавар хүртэл хангалттай байхуйц тамир тэнхээ хурааж болно. Хавар бид тэгтлээ их иддэггүй, зун бол бүр ч бага иддэг атлаа өвлийнх шигээ ядарч, санаа сэтгэлээр унахгүй, тааламжтай байдаг.

Оюун санаа саадгүй дэвшиж чадахгүй байгаа үеийг өвлийн улиралтай л зүйрлэмээр.



Гэхдээ хэсэг хугацааны дараа бид үүнийг даваад гарчихдаг. “Оюун санааны бясалгалын өвөл” ирэхээр бид будилж төөрч, бясалгалаа хаяж, эсвэл хуурч мэхлэгдэх нь бий. Бид идэвхгүй сул болж, бясалгалдаа ахихгүй эсвэл дурамжхан хандаж, үгүй бол сэтгэл гонсгор байж, тотгор үүсгэх нөхцөл байдлууд бий болох магадлалтай. Гэвч хэсэг хугацаа өнгөрөхөд бүх зүйл зүгээр болно гэдгийг л санавал зохино. Тухайн үед бид алдаа гаргасан ч, бясалгалдаа унаж, итгэл суларсан ч өөрсдийгөө уучлах хэрэгтэй. Боломжтой бол түргэхэн шиг “нэмэлт тэжээл” хэрэглэхивэл сайн! Жишээ нь, дияанд явдаг ч юм уу, Их Багшид бараалхаж, авшигтнуудтайгаа илүү их уулзаж, нийтийн бясалгалд илүүтэй оролцож, Багшийн номыг ахиухан уншиж, бичлэгийг сонсож болно. Энэ бүгд бидний оюун санааг тэтгэгч “нэмэлт тэжээл” юм шүү дээ. Эдгээрийг хэрэглэсний дараа бид хамаагүй

дээрдэх болно. Тэгээд “хавар” иртэл бясалгасаар байна. Хавар бидний байдал хамаагүй илүү сайжирч, тийм их “нэмэлт тэжээл” ч хэрэггүй болно.³¹

³¹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1989 оны хоёрдугаар сарын 13-наас 18 (Хятад хэлээр)





БЯСАЛГАЛ ХИЙХЭД ХАМГИЙН ТОХИРОМЖТОЙ ЦАГ

Өглөө бясалгавал илүү дээр гэж би боддог юм. Энэ бол хүн унтаж амраад сэтгэл санаа харьцангуй цэлмэг байх тул дотоодын ахуй ойлголт олж, Гэрэл харахад их хялбар байдаг үе. Зохих хэмжээнд унтсан боловч жаахан нойрмогдуу байх үе л бясалгалд хамгийн сайн. Мэдээж энэ үед босоход хамгийн хэцүү, яг л хоол идэж байгаад арай цадаагүй, ахиад жаахан идчихмээр байдаг үе шиг. Бясалгалд хамгийн сайн цаг бол энэ.



Шөнө унтаж амарсны дараа олон олон саад бэрхшээл, үйлийн үрийн тогторууд арилсан байдаг. Өмнөх өдрийн сэтгэгдлүүд, сөрөг нөлөөнүүд цөм угаагдсан байна! Бидний хамаг шалтгаан, хамаг үр дагавар зүүдэнд төлөгдөж дууссан байдаг. Тэгэхээр бид өглөө босохдоо тун шинэ соргог байдаг байх нь. Иймээс ч бясалгалдаа Гэрэл харах, өөрсдийн агуу мөн чанартай холбогдоход маш хялбар байдаг юм.

Зарим хүмүүс шөнийн ажилтай, өдөр унтдаг. Нөхцөл байдлаасаа хамаарч, та нар унтаж сэрэнгүүтээ бясалгах хэрэгтэй. Долоон цагт босч чаддаггүй юм бол, есөн цагт бос, гэхдээ хэсэг зуур заавал бясалгах хэрэгтэй. Эс бөгөөс бидний сэтгэл тогтворгүй, сайныг муу, мууг сайн гэж харна. Мөн бусдын үйлийн үрээр амархан бохирдож, доош татагдана. Дэс маань даруй унана, унадаггүй юм гэхэд дэвшихэд маш бэрх байх болно. Сэргэлэн


цовой байж чадахгүй, хийсэн бүхэнд саад тохиолдоно. Хэн нэгэн хүн биднийг гомдоовол уучилж чадахгүй, мөн юуны ч тухай эмх цэгцтэй сэтгэж чадахгүй байдалд хүрдэг. Иймд бясалгал маш чухал юм.³²

³² Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шиху, Формоса, 1992 оны дөрөвдүгээр сарын 12 (Хятад хэлээр)



Бясалгагч нар гэрээс гарсан, гараагүй ялгаагүй, өдөр бүр, өглөө оройны аль алинд нь заавал бясалгаж байх хэрэгтэй. Тухайн өдрийн таагүй бэлгийг хүлээн авахын тулд өглөөдөө бясалгана. Бид шөнөдөө хамгаалалттай, амгалан тайван байхын тулд болон өдрийн бохир уур амьсгалыг цэвэрлэхийн тулд оройдоо бясалгана.

Өглөө эртнийн бясалгалыг хэрхэн дадуулах вэ

 Өдрийн сэрүүн байх цаг хүрэлцэхгүй үед өдөр тутмын бясалгалынхаа хуваарийг яаж зохицуулах вэ?

Б: Та сэрж чадахгүй байна уу? Би ч бас адилхан. Дулаан хөнжилдөө шигдсэн хэн ч байсан сэрэх дургүй, гэвч бид хичээх хэрэгтэй. Ажилдаа эрт явах ёстой байсансан бол та босох л ёстой болно. Сарын хоёр мянган доллар ч юм уу, тэрүүхний төлөө та нар өглөө бүр таван цагт босдог. Гэтэл Эзэн Бурханы төлөө босдоггүй ээ! Тэгэхээр чинь би яах вэ? Та нар өөрсдөө л юу хамгаас чухал гэдгээ шийддэг. Ердийнхөөсөө жаахан эртхэн босоод, түүнийгээ дадал болгож болно.



Жишээ нь, 3 цагт босоход хэтэрхий эрт байгаа бол битгий бос. Ажилдаа явахаар жирийн үед 5 цагт босдог бол эхний удаад тавд хорин минут дутуу байхад бос, бүр тавд арав дутуу, тавд таван минут дутуу байхад бос л доо. Дараачийн өдөр юм уу, дараа долоо хоногт тавд арван минут дутуу байхад бос. Өөрийгөө үүнд дасгаж, бас сайн шагна. “Өнөөдөр эрт босвол чамд хоёр боов, бас нэг аяга кофе латте илүү өгнө шүү” гэж өөртөө хэл. Сэтгэлд чинь юу л таалагддаг вэ, түүгээр өөрийгөө шагна.

Бид өөрийгөө хайрлах ёстой. Яагаад гэдгийг бодоод үз, бидэнд энэ бие махбод ердөө ганц байх атал заримдаа бид биеэ хэт их ядраадаг. Энэ машинаа л тордох гэж өдөрт бид наймаас арван цаг асар ихээр хөдөлмөрлөнө. Тэгээд хааяа бас гэр бүл: эхнэр, хүүхдүүд, эцэг эх, найз нөхөд, хөршүүд, садан төрлүүд гэх мэт бусад ажил ч гардаг. Энэ махан биеэсээ бид үнэндээ хэтэрхий их юм шаардаж байна.

Өглөө бясалгахаар босч чадахгүй байгаа бол өөрийгөө уучлахаас ч биш яах вэ. Өөртөө хэт хатуурхалгүй, зугуухан сургаж ав. Зурагт үзэхээ багасган, өглөө эрт босохын тулд арай эртхэн унт. Уйдахаараа цаг нөхцөөх гэж хийдэг байсан зүйлдээ хэт ихээр зарцуулдаг байсан тэр цагаа Эзэн Бурханыг таньж мэдэхэд зориул. Энэ бол ердөө зохион байгуулалтын л асуудал.

Би бас хэрэндээ л завгүй. Та нар итгэхгүй байж мэднэ, би энд нэг сайхан хүн сууж байгаа хэдий ч тун завгүй хүн шүү дээ. Надад ч гэсэн өглөө босоход хэцүү үе заримдаа гардаг. Сэрүүлэг тавихаас өөр аргагүй болно. Заримдаа ийм үе байдаг.

Эртний Энэтхэг домогт нэгэн Гэгээнтэн шөнө суугаагаараа хонодог, гэхдээ ямар ч ялгаагүй болохоор хэвтэхийн оронд суугаагаараа унтдаг байсан гэдэг. (Инээлдэв.) Манайхан ч бас адилхан даа. Дияанд ирэхээрээ, давгүй сайхан



сууж харагдана. Гэхдээ янз бүрийн байдалтай сууна. (Багш толгойгоо унжуулан, зүүрмэглэж байгаа хүнийг элэглэв.) Иймд энэ хамаагүй. Чадахаараа хичээ, тэр чинь л чухал. Энэтхэгт над шиг урт үстэй нэг Гэгээнтэн үсээрээ таазнаас өөрийгөө уячихдаг байсан юм даг. Би тоглоогүй байна! Тэгж их хичээсний дүнд тэр Багш болсон. Үсээрээ таазнаас зүүлттэй тэр зүүрмэглэж дохихоороо “Өө, за, ёох ёох” гэнэ. (Инээлдэв.)

Би та нарыг үсээ ургуулаад үүнийг дуурай гэж байгаа юм биш. Гэхдээ өөрийн гэсэн аргаа олоорой. Өглөө эрт босъё гэвэл; жишээ нь би яадаг байсан бэ гэхээр, хажуудаа халуун саванд мөстэй ус хийж тавьчихаад сэрүүлэг дуугармагц гараа сунгаж аваад нүүр лүүгээ цацдаг байв. Ёо! Мөс хувцас хунар, хамаг юм уруу чинь нэвчихээр, орноосоо шалавхан үсэрч босохоос өөр аргагүй.

Та нар тэгэх албагүй; өөрийнхөө аргыг олно биз. Гэхдээ хүн юмыг болгоё л гэвэл болдог. Та нар өөрсдөө бурхад учраас чадна гэдэгтээ итгээрэй. Эзэн Бурханд чадахгүй зүйл гэж байхгүй. Та нарын дотор Эзэн Бурхан оршиж буйг л саначих, өөр хэн ч тэнд байхгүй. Тархи бодлоо бүү сонс, тэр чинь ердөө л компьютер. Бодол маань “Унт унт, унтах биенд чинь сайн” гэдэг. Гэтэл тэр бол Эзэн Бурханы дуу хоолой биш. Эзэн Бурханы дуу хоолой түүний цаад талд байгаа.³³

³³ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Оукланд, Шинэ Зеланд, 2000 оны дөрөвдүгээр сарын 27, (Англи хэлээр)



Өглөө ер нь чимээгүй байдаг. Гурваас зургаан цагийн хооронд ихэнх хүн унтаж л байдаг: замын хөдөлгөөн, шуугиан байхгүй, хүүхдүүд үймүүлж, утас дуугарахгүй. Шөнө унтаж амраад сэтгэл чинь тайван. Бие махбод бүрэн идэвхжиж сэрээгүй байдаг. Ийм үед та илүү сайн сууж, самади буюу Бурханы Оронд илүү хурдан хүрч чадна.

Хоёр цаг хагасыг цаглашгүй урвуулахуй

Та нар өдөр бүр бясалгалдаа зориулж буй хоёр цаг хагас тань удаан хугацааны үр дүн, мянга мянган жилийн үр дүнтэй; учир нь бясалгалаараа та нар мөнх оршихуйд нэвтрэх үед цаг хугацаа зогсчихдог юм. Энэ бол ердөө хоёр цаг хагасхан төдий биш. Харин энэ нь мянга мянган жил, олон галав эриний дайтай хувьсал, хөгжил юм. Бясалгалаар хүн цаг хугацаа, орон зайн өөр бүс үрүү ордог. Өөрсдийгөө шинэчлэх эсвэл мөн чанараараа оршихын төлөө ахин дахин эргэж төрөхгүйн тулд та нар ийнхүү цэнэглэгдэж шинэчлэгдээд буцаж ирдэг. Учир нь бидний эргэж төрөхийн зорилго нь суралцах, өөрийгөө дахин танин мэдэх явдал байдаг юм. Тэгээд л тэр. Энэ төрөлдөө үүнийг хийж чадахгүй бол ирэх төрөлдөө, дараа дараачийн



төрөлдөө хийх хэрэгтэй болно. Иймд одоо бидэнд хоёр цаг хагасын зав байгаа бол бид өдөр бүр бясалгавал зохино. Тэр бол бид аль хэдийн сая сая жилийн бясалгал хийж байна гэсэн үг. Хоёр цаг хагас бясалгах бүртээ та нар дөнгөж хоёр цаг хагас гэх буюу эсвэл хэтэрхий урт хугацаа гэж бүү бодоорой. Минут бүр нь нэг насны амьдралтай тэнцэнэ. Учир нь мөнх оршихуйд хоёр цаг хагас эсвэл нэг минут гэж байдаггүй. Дандаа мөнх л гэж байна. Бид цаг хугацаанд хоригдчихоороо цаг хугацааг мэддэгээс л болж түүнийг тоолдог. Цаг хугацаанаас гараад явчихаар цаг хугацаа гэж байхгүй.

Бясалгалын цаг маш их үнэ цэнэтэй. Энэ бол танд гарах зуун зуун галав эриний хувьсал хөгжлийг яг компьютерийн нягт жижиг хэсэг шиг шахаж багтаасан цаг. Иймхэн жаахан компьютерийн жижиг хэсэгт мянга, бүр заримдаа сая сая нэгж мэдээллийг хадгалж байдаг болохоор хэмжээ гол нь биш. Энэ чинь нөгөө бидний дасч

сурсан цаг хугацаа, тоо ширхэг биш шүү дээ. Бясалгалын үе бол тэс өөр цаг хугацаа, орон зайд харьяалагдана. Иймд энэ цаглашгүй, хязгааргүй орон зайд та нар хэдий чинээ их нэвтэрнэ, өөрт тань төдий чинээ сайн, өөрийгөө улам илүү танин мэдэж, улам илүү эрх чөлөөтэй болно.³⁴

³⁴ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын тав хоногийн дияан бясалгалын үеэр, Ён Донг Төв, Солонгос, 1998 оны тавдугаар сарын 9 (Англи хэлээр)



Хэрэв бид улам илүү их
бясалгавал бидэнд ер нь юу ч
хэрэггүй юм байна гэдгийг эцэстээ
ухаарна. Өдөр бүр гайхамшиг
болж, бид өдрөөс өдөрт улам бүр
аз жаргалтай, улам энэрэнгүй
болсоор байх болно. Эзэн Бурханы
хамгийн сайхан бэлэг энэ л юм.

Маш их бясалгаад ядрахгүй байх арга

Бид маш их бясалгаж, гэхдээ ядрахгүй байхыг хүсвэл яах хэрэгтэй вэ? Үүний нууц бол: бага ярьж, эргэн тойрноо бага анхаарч, бусдын сайн муугийн тухайд бодолгүй хорин дөрвөн цагийн турш Ариун Нэрсээ л уншаад бай. Аялгууны бясалгалын үед нэг л тогтож өгөхгүй бол Ариун Нэрсээ хэсэг зуур уншчихаад Аялгуугаа дахин ажаарай. Биеийн чинь аль нэг хэсэг өвдөх юм уу, хөшсөн мэдрэмж төрвөөс түүнийг үл ойшоо! Самадид орчихоороо бүтэн биеэ оршиж буй эсэхийг ч мэдрэхгүй. Иймд энд тэндээ маажлах хэрэггүй. Аялгуу ажиг ядарвал байрлалаа өөрчилж Гэрэл ажаарай. Хөл чинь тун их талархах болно. Учир нь хөл чинь их өвдөж, толгой чинь өмнөх байрлалаас болж хөшчихсөн байгаа. Энэ үед нь байрлалаа сольж Гэрэл ажвал хамаагүй аятайхан санагдана.



Иймд Гэрэл, Аялгууны бясалгалыг солбиж хийх хэрэгтэй. Тэгвэл эдгээр нь харилцан дэмжилцэж, та нар ядрахгүйгээр илүү удаан бясалгах боломжтой болно.


Манай зарим бясалгагч нар Гэрэл, Аялгуу ээлжлэн ажсаар бүхий л шөнөжин сууж чаддаг. Гэхдээ байнга ингэж, таван минут тутамд байрлалаа бүү солиорой. Тэгвэл ямар ч хэрэггүй. Нэг байрлалдаа удаан байх тусмаа л сайн. Гэрэл ба Аялгууны бясалгал бие биедээ харилцан тусалж байдаг. Заримдаа Гэрэл ажсаар бүр чилж ядарвал байрлалаа өөрчилж Аялгуу ажаарай. Тэгвэл танд хамаагүй сайхан санагдана, учир нь танд тулж найдах юм байна шүү дээ. Бясалгалын энэ нэг нууцыг мэддэггүй хүн олон бий.³⁵

³⁵ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Шиху, Формоса, 1989 оны хоёрдугаар сарын 13-наас 18 (Хятад хэлээр)



Бясалгал гэдэг өөрөө нэгэн төрлийн шагнал юм. Учир нь бясалгах боломж гарахаар бид билиг ухааны төлөө сууя гэж үнэнээсээ хүсдэг. Ахуй ойлголт байсан ч, үгүй ч энэ бол хэдийнээ шагнал мөн билээ.





БЯСАЛГАЖ БАЙХАД СААД ТОТГОР ТОХИОЛДВОЛ

Гэртээ бясалгаж байхад чинь дүрсгүй амьтад та нарт түвэг учруулж эсвэл сэтгэл чинь түгшиж тайван биш байгаагаас сайн бясалгаж чадахгүй байвал үүнийг шийдэх хоёр арга зам бий. Та нар миний залбирлын дуу, хөгжмийн эсвэл ном тайлж буй бичлэгийг цаанаа тавьж болно-гэхдээ суудлынхаа цаана биш-харин намуухан дуугаар өмнөө тавина гэсэн үг. Хэрхэвч битгий ар талдаа тавьж байгаарай, учир нь анхаарал чинь ар тал уруугаа яваад урдаа төвлөрөхөд чинь хэцүү болно. Бүр болдоггүйдээ ч биш, зүгээр л та нарт тустай сайн биш. Дуу



бичлэг, зурагт, хөгжим, тэр ч байтугай, утас, факсын аппаратаа, ер нь сонсогдож болох бүхий л юмаа урдаа тавьж байгаарай. Хэрвээ та албан тасалгаандаа суудаг бол аппарат машиныхаа урдаас нь харж сууснаар яг урд чинь дуугарч, харин анхаарал чинь өөр тийш сарнихгүй. Учир нь анхаарлаа дахин урдаа төвлөрүүлэх нь маш хэцүү байдаг. Мөн та нар утсаар ярих бол утсаа баруун чихээрээ сонсож байгаарай. Үүнийгээ дадал болго, зүүн талаараа битгий сонсож бай. Анхаарлыг чинь зүүн тийш эсвэл хойш нь татаж байгаа бүхэн сайн зүйл биш. Үүнийг санаж яваарай. Ийм нэг зүйл байдаг. Бас нэг юм гэвэл нөхцөл байдал сайжрах хүртэл та Ариун Нэрсээ шаардагдах хугацаанд эсвэл өдөр бүр нэг цаг чангаар уншдаг байж болно.

Урьдчилан сэргийлэх бас нэг арга бий. Хэрвээ та айдсаар дүүрэн, заримдаа дүрсгүй амьтад ойр хавьд чинь эсвэл ард чинь байгаа мэт санагдаж байвал, эсвэл миний шавь болохоос

өмнө танд юм шүглэсэн байсан бол миний зургаар өөрийгөө тойруулан тавьж болно. Та нарт өчнөөн олон зураг байгаа; том байх албагүй жижигхэн зурагнууд байхад л болчино. Ер нь бол зурагны хэмжээ хамаагүй, зурган дээрх хүн нь л чухал. Гиймээс жижигхэн зураг байсан ч хамаагүй өөрийгөө тойруулан тавиарай.

Түвдүүдийн Мандал энэ уламжлалыг хадгалж үлдсэн байдаг. Тэд үргэлж тойрог зурдаг байжээ. Эхэн үедээ Багш нь өөрийн адислаж бэлэг дурсгал болгон өгсөн шашны эд зүйлсээрээ тойруулан суухыг заадаг байсан юм. Тэд Багшийнхаа хайр адислалаар дүүрэн тэдгээр зүйлсээр өөрсдийгөө тойруулан суудаг байж. Хожим нь чамин тансаг болж, цэцэг, хүж, элс, өнгө будаг зэргийг нэмжээ.

Та нар бүрэн хамгаалагдсан, аюулгүй, тайван гэдгээ мэдэрч л байвал өөр бусад ямар ч зүйлийг хийж болно. Зурагнуудыг минь тойруулж



тавиад, цэцэг, хүж, өөр юу ч байдаг юм, лаа ч тавьж болно. Гэхдээ хэтэрхий их утаа битгий гаргаарай, тэгвэл байнга ханиалгах болно шүү. (Инээлдэв.) Хэдийгээр романтик бас оюун санаанд зохицож харагддаг ч хүж болон лааны утаа элдвээр нөлөөлөх нь олонтаа. Тэгээд хоолой өвдөж цээж цэртэнэ. Энэ нь яваандаа илрэх хор нөлөө бөгөөд сайн зүйл биш. Гэхдээ та нар тэвчиж чадвал яах вэ дээ. Та нарт бясалгалаа хийх таатай нөхцөлийг бүрдүүлэх юу ч байсан би хорихгүй. Тэр ч байтугай та нар эрхи эргүүлж, тарни уншсан ч болно. Гэвч ингэвэл та нар нөгөө эрхи тоолох зуршилдаа хүлэгдэн, улмаар эндээ төвлөрөхөө мартана. (Багш билгийн нүдээ зааж байна.) Тэгээд төвлөрлөө буцааж авчрахад хэцүү болдог. Бид өдөр тутмын ертөнцийн амьдралд хэдийнээ хэт их хүлэгдсэн байдаг. Өглөө бид босоод нүүр амаа угааж, оо энгэсгээ тавьж, зангиагаа зүүх хэрэгтэй болдог. Энэ гэхэд л хэдийнээ дэндүү материаллаг ажил. Ажил дээрээ бид ухамсраа мөнгөнд хандуулж, гэртээ харих

гээд явж байхдаа ч хүртэл мөнгийг бодсоор л байдаг. Тэгэхээр бид өдөр бүр хүүхэн, залуу, зангиа, үнэт эдлэл, нүүрний будаг, мөнгөн дээр хэдийнээ бясалгаж байгаа байх нь. Тиймээс бидэнд өөрсдөдөө зориулж бясалгах цаг гарвал бид анхаарлаа дотоод уруугаа л хандуулах хэрэгтэй юм.³⁶

³⁶ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын дөрөв хоногийн диван бясалгалын үеэр, Вашингтон ДС, АНУ, 1997 оны арван хоёрдугаар сарын 26 (Англи хэлээр)



Билиг ухааныхаа төв дээр дотооддоо төвлөрөх

Ямар ч Их Багш эсвэл би туйлширч хэнээрхэн, дарангуйлах гэсэндээ та нарыг ингэж ч болохгүй, тэгж ч болохгүй гэж хориглодог юм биш, тийм биш шүү. Та нар зүгээр л бүх юмыг мартаж, зөвхөн дотооддоо, билиг ухаан дээрээ төвлөрөх хэрэгтэй. Гэхдээ төвлөрч байхдаа чанх урагшаа харах хэрэгтэй гэж ярьж байна, харин билгийн нүдээр бол дотоод уруугаа харна гэсэн үг юм. Тэгээд ч бид ер нь дотроо ч биш, гадна ч биш, хаа ч байхгүй юм шүү дээ. Энэ бол та нарт биечлэн яаж хийхийг тань ойлгуулахын тулд зүгээр л үгээр илэрхийлж буй байдал юм. Түүнээс бус нүдээ аниад чихээ таглахад чинь бусад бүх л зүйл дотоодод чинь байж байна. Ингэмэгц та нар материаллаг ертөнцтэй тийм их холбоотой байхаа болино. Та



Хэрвээ та зуун хувь бүрэн
итгэлтэйгээр оюун санааны
зам мөрийг дагавал
тун удалгүй үр дүнд хүрнэ.
Ийнхүү үр шимийг нь
хүртэхүйд итгэл сүжиг тань
нэмэгдэж цаашид улам илүү
амжилтыг олно.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Бид үтэр түргэн дэвшихийг хүсвэл өөрийгөө
умартан, даруу төлөв байж, бусдын хийх дургүй
хамгийн бохир ажлыг цөмийг нь хийх хэрэгтэй

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



нар дотооддоо зөвхөн өөртэйгээ байж, өөрийн мөн чанараа танин, өөрийгөө оюун санаа, Бурхан, Гэгээнтэн гэдгээ ухаарах болно. Тиймээс тэр бүх эрхи сэлт нь төвлөрөлд илүү саадтай, хор нөлөөтэй зүйлс юм.

Тэдгээрийг хэрэглэх нь муу зүйл биш л дээ. Зураг хөрөг, эрхи, загалмай, Бурханы баримал гээд Бурханлагийг сануулж байдаг бүхнийг ашиглаж болно. Гэхдээ та өөрөө Гэгээнтэн, өөрөө загалмай, өөрөө Эзэн Бурхан учир бясалгаж байх үедээ эдгээр зүйлсийг хойш тавих нь зүйтэй. Сануулах элдэв зүйлс хэрэггүй. Харин Мандала бол зөвхөн хамгаалах зориулалттай, зарим цөөн тооны хүмүүс урьд нь тэдэнд яршиг түвэг удаж байсан дүрсгүй амьтад ой санаанд нь үлдсэнээс болж юм уу эсвэл харанхуйгаас болж айдаг. Тэгээд эрт урьд цагт, тэд айхгүйн тулд лаа асаадаг байсан байна. Иймээс би та нарын заримд гэрлээ асаалттай орхихыг зөвлөдөг, ингэж болно. Гэхдээ бид



цаг үргэлж ингэх ёстой юм уу эсвэл хүн бүхэн хийх ёстой зүйл гэсэн үг биш. Эс бөгөөс нэг нь нөгөөгөөсөө сурчихаад “Лаа асаахаар надад маш таатай байдаг” гэх мэт юм ярина, тэгээд бүгд дуурайна. Ингэсээр энэ нь шууд заншил болж мэднэ. Ийм байж болохгүй.

Та нар билгийн нүдэн дээрээ тосоор эсвэл хуурай иллэг хийж болно. Хэрвээ хэтэрхий хуурай байвал тосолчихоод илэхэд хялбар болно. Мөн над шиг үрчлээ суусан настай хүмүүст тустай байдаг. (Инээлдэв.) Би энэ иллэгийг тийм ч их хийдэггүй л дээ, нүүрээ будахдаа л хийдэг юм. Хэрэв та нарт төвлөрөхөд хүндрэлтэй байдаг бол эрхий хуруу, эсвэл бусад хуруугаараа билгийн нүдний чигт яг энэ хүртэл ил. (Багш хөмсөгнийхөө хооронд, дээхэн талд духныхаа дунд зааж байна.) Эндээ дар, эсвэл зүгээр илж байгаад дараа нь дар.³⁶

³⁶ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын дөрөв хоногийн дияан бясалгалын үеэр, Вашингтон ДС, АНУ, 1997 оны арванхоёрдугаар сарын 26 (Англи хэлээр)



Бид ахин дахин суралцах ёстой. “Өнөөдөр би ахиц гаргасангүй. Тийм ч сайн бясалгасангүй. Маргааш, дараагийн өдөр би илүү их хүч чармайлт гаргая” гэж өөртөө шийдэмгий хэлэн шинээр эхэл. Оюун санаагаа дэвшүүлье гэвэл сэтгэлийн тэнхээгээ илүү сайжруулахын төлөө цаг үргэлж чармайх хэрэгтэй. Тэгж гэмээ нь та Бурханы Оронд илүү хүчирхэг, илүү билгүүн ухаант нэгэн байх болно.



Бясалгах үед чичирхийлэхийг яаж зохицуулах вэ?

А: Гэрэл ажиж байх үедээ би заримдаа энергийн огцом цохилтонд өртөх шиг болдог, энэ нь намайг нэг талаас нөгөө тал уруу элдвээр савчуулах мэт санагддаг. Энэ чухам ямар үзэгдэл вэ?

Б: Энэ зүгээр ээ. Эерэг болон сөрөг энерги хоорондоо тэмцэлдэхийг оролдож байгаа нь тэр. Бид хараахан тогтворжоогүй, мөн 100% цэвэр биш байх үед иймэрхүү зүйл тохиолддог юм. Аяндаа энэ чинь тогтвортой болно. Тэр мэдрэмжийг анхаараад хэрэггүй, зүгээр л орхичих. Ийм л учраас бид сахил болоод өөр бусад аргаар өөрсдийгөө цэвэр байлгах хэрэгтэй, тэгж байж л бид ийм ариун бөгөөд асар хүчтэй энергийг хүлээж авч чадах юм. Хоол унд, хэл яриа, үйлдэл мөн бодлоо цэвэр ариун байлгахыг хичээ. Тэгвэл

энэ байдал чинь аяндаа сайжирч, яваандаа бүр мөсөн алга болно.

Заримдаа хэтэрхий чичирхийлээд байвал, шалан дээр сууж болно. Хэт өндөр юман дээр битгий суу, тэгэхгүй бол уначихна. (Шавь нар инээлдэв.) Би тоглоогүй байна шүү. Эсвэл, модон тавцан болон модон шалан дээр сууж болно. Эдгээр нь энергийн зарим хэсгийг өөртөө шингээж авдаг учраас та тийм их чичрэлтийг мэдрэхгүй. Заримдаа аялгуу ажих үед шатах мэт мэдрэмж төрж, цаашид үүнийг тэсвэрлэж чадахгүй мэт санагдаж мэднэ. Тэгвэл та нар суудлаа өөрчилж болно. Олбог дээр бүү суу. Сэрүүхэн модон шал олж суугаарай. Хөлөө модон тавцан юм уу эсвэл газар тавь. Ингэх нь хэлбэлзлийн хүчтэй нөлөөг сөрж чадахгүй үед тэр хүчийг саармагжуулж өгөх болно. Иймэрхүү тохиолдолд энэ арга хэмжээг авч болно, харин аялгуу ажихаа заавал үргэлжлүүлэн хийгээрэй. Аялгуу бол маш хүчтэй юм шүү.



Заримдаа та нар цэвэр биш байх нь (хүмүүстэй харьцсан тохиолдолд) тэр болгон та нарын үйлийн үр биш байж болно. Тиймээс юм л болвол өөрсдийгөө битгий буруутгаарай. Хааяа бид хүмүүстэй харилцахад тэдний ариун бус байдал мөн үйлийн үр нь бидэнд нөлөөлдөг юм. Эсвэл бид хоол хүнсээ цэвэр цагаан хоол бишийг нь мэдэхгүйгээр идчихдэг тохиолдол бий. Эдгээрийн аль ч тохиолдолд ахиухан бясалга.

Хэрвээ олбогон дээр суухад тухтай биш байвал, дэндүү халуудаж байж магадгүй, ийм үед модон шал эсвэл газар шороон дээр суу, хөлөө өөд нь аваад шал, сүрлэн дэвсгэр дээр суухад ч болно. Энэ нь сэрүүхэн, агаар сайтай байдаг юм. Бидний хэрэглэдэг олбог нь Аялгуу ажихад зориулагдаж хийгдээгүй байдаг. Суудаг байрлалаа эсвэл газраа, олбогоо солиод үз, тэгвэл өөрт чинь арай дээр санагдах болно.³⁷

³⁷ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын дияан бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1995 оны арвдугаар сарын 31, (Англи хэлээр)

Зориг хатуужлаа хүчтэй болгож саад бэрхшээлийг давж гарах нь

А: Хэсэгхэн бясалгасны дараа л надад босч явмаар санагдаад байх юм. Намайг босгох гээд ямар нэг хүч татаж буй нь мэдрэгддэг, үүнээс болоод би бясалгалаа үргэлжлүүлж чаддаггүй.

Б: Ямар хүч вэ? (Шавь нар инээлдэж байна.)
Та нар өөрсдийнхөө залхууг буруутгахгүй атлаа гадны хүчийг буруутгах юм. Буруугаа дандаа л хий үзэгдэл, Маяа эсвэл үнэг, харх, муур луу чихэж байдаг. Асуудал өөрсдөд чинь байгаа эсэх талаар ер боддоггүй. Хэрвээ бид хичээнгүйлэн бясалгах юм бол заавал дотоод ахуй ойлголттой болно. Гэхдээ бидэнд саад болж, уруу татаж байна гэж сөрөг хүчийг буруутгалгүй өөрсдөө үнэхээр хичээнгүй байх ёстой. Үнэндээ өөрсдийн маань сул дорой байдлаас өөр биднийг доош татах хүч гэж байхгүй. Тэр байтугай, Маяа бидэнд яршиг



удах нь хүртэл бид түүнээс айснаас л зөвхөн болсон хэрэг.

“Маяа та нарыг оролдмоор бол эхлээд царай луу чинь хардаг” гэж аулакчууд ярьдаг. Энэ нь өөрийн чинь зоригтой, хүчтэй эсэхийг эхлээд харна гэсэн үг юм. Хэрвээ бид тийм байж чадахгүй бол Маяа бидэнд түвэг тарина. Харин бид Маяагаас илүү хүчтэй харагдаж байвал тэр биднийг оролдож зүрхлэхгүй юм. “Баруун хязгаарт зорчсон тэмдэглэл” (Хятадын сонгодог уран зохиол)-д тамын эзэн, Мичин Хааныг тамдаа авч одохоор хүрч ирээд “Ха, ха би тамын эзэн байна!” гэж омог бардам хэлдэг. Гэвч дараа нь тэрээр ялагдчихаад Мичин Хаанд бөхөлзөн мөргөж “Ээ, эрхэм дээдэс минь, амь хэлтрүүлж хайрла! Амь хэлтрүүлж хайрла!” гэж гуйдаг. (Инээлдэв.) Бид яг л энэ Мичин Хаан шиг байх ёстой. Хэтэрхий сул дорой байваас Маяа биднийг айлгана. Үргэлж л Маяагийн хүчнээс айгаад байвал, түүнийг ирнэ гэж бид бодоод байгаа болохоор тэр ирж л таарна.

Түүнээс биш бусад дээр ирэхгүй зөвхөн өөр дээр чинь л хүрч ирээд байдаг тийм хүч гэж хаана байх вэ?

Иймд саад тотгортой учирвал бүү тоо. Сөрөг энергийг мэдэрсэн ч бясалгалаа үргэлжлүүл. Бясалгаж чадахааргүй бол босоод хэсэг жаахан алхаж байгаад буцаад бясалгахыг оролдох хэрэгтэй. Ариун Нэрсээ уншин, дотоодын Багшдаа залбиран бясалгалаа үргэлжлүүлж байхад биднийг сөрөг хүч чухам яаж чадахыг нь харъя л даа. (Алга ташив.) Бид эерэг бодолтой, өөдрөг үзэлтэй, зоригтой байх ёстой, ингэвэл энэ бүхэн бидний дадал болно, учир нь хамаг зүйл бодлоос үүсдэг. Бидэнд өөртөө итгэх чадвар, зориг дутуу байсан цагт харх гүйсэн ч айж, түүнийгээ ямар нэг аймшигт юм эсвэл Маяагийн хүч ирж байна гэж төсөөлдөг. Гэтэл тэр нь ердөө л нэг харх төдийхөн байх жишээтэй. Иймд юунаас ч айх хэрэггүй.³⁸

³⁸ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Тайнан, Формоса, 1989 оны нэгдүгээр сарын 12, (Хятад хэлээр)



Айдас төрүүлсэн мэдрэмжиндээ битгий авт, учир нь айх тусам айдас хүчтэй болдог. Аливаа юмны талаар бид хэдий чинээ их бодно, тэр зүйл төдий чинээ хүч авч байдаг. Тэгэхээр зөвхөн “хайрын” тухай л бодоцгооё. Цаг үргэлж бид зүгээр л “хайр” болон “хайрын хүчний” тухай бодон, эерэг бодолтой байхад, Их Багшийн хүч аяндаа бүх зүйлийг зохицуулах болно. Аажим аажмаар бид энэ байдалдаа дасч, саад тотгор үгүй болж бүхий л айдас хүйдэс арчигдан арилах болно.

Бодол сэтгэлийг номхотгохуй

■ Би маш их биеэ барьж, тэмцэлдээд л, тэмцэлдээд л, тэмцэлдээд л...

Б: Юутай тэмцэлддэг хэрэг вэ?

А: Бясалгалаа хийх гэж л.

Б: Өө тийм үү. Бясалгалыг битгий ажил болго, энэ бол тайвширч амрах цаг шүү дээ. Тархиндаа юу ч хийх хэрэггүй, зүгээр л тэнд тайвшраад сууж бай гэж хэл. Хэрвээ удаан сууж чадахгүй бол хэвтэж амарч болно. Тааламжтай бясалга.

Өөрийнхөө урд цэцэг тавиад, гоё хувцсаа өмсөөд бясалгаж болно. Хэрвээ сайхан санагдаж байвал бясалгалаа ёслолын ажиллагаа шиг



болго. Зарим хүмүүс хүж асааж, цэцэг тавьдаг нь сэтгэлээ аргалах гэснээс л тэр юм. Бясалгалаа хийхэд чинь таатай л байвал юуг ч хийж болно. Баяс! Эсвэл хэвтэж амар. Тэгэх зуураа харин эндээ (Билгийн нүдэн дээрээ) төвлөрөөрэй.

Юун түрүүнд бясалгалаа таатай болго. Сэтгэлд тань дэндүү хэцүү санагдах ёсгүй, тэгвэл тэр дургүйцнэ. Сэтгэл гэдэг зүйл ажил хийх дургүй. Хэрвээ та бясалгалдаа хэтэрхий чухал хандвал сэтгэл чинь “Надад наад юм чинь таалагдахгүй байна. Би зугаацмаар байна, найз нартайгаа хөгжим сонсож, кофе уумаар байна. Би ингэж суухыг хүсэхгүй” гэж эсэргүүцэх болно.

Тиймээс бясалгалаа зүгээр л таатай сайхан болго. Сайн найз нар, авшигтнуудаа гэртээ урь. Эсвэл тэднийхээ гэрт очиж, эхлээд кофе уун, ярьж хөөрч эсвэл цугтаа ямар нэгэн юм хий. Тэгээд дараа нь цуг сууцгаа, бясалгалаа наадам, зугааныхаа нэг хэсэг болгож хий. Эхэн

үед иймэрхүү байж болно. Сүүлдээ сурч дасаад энэ мэт тоглоомны хэрэггүй болж, хаана ч сууж бясалгахад сайхан санагддаг болно.

Эхлээд сэтгэлээ тайвшруул. Олонхи тохиолдолд бид бүгд Гэгээнтэн болох гэж маш их яарч байдаг, түүнээс л болж бидэнд асуудал бэрхшээлүүд үүсдэг. Бид сүнс болоод сэтгэлээ хооронд нь зохицуулах гэж зүдэртлээ зүтгэнэ. Сүнс бясалгахыг хүсч, сэтгэл зугаацахыг хүсдэг. Тийм учраас бид сайн бясалгасныхаа дараа, өөртөө дуртай хоолоо өгөх мэтээр сэтгэлээ шагнаж болно. Гадуур гар, эсвэл найз охинтойгоо уулз, ер нь бясалгасныхаа дараа ямар нэгэн зугаатай юм хий. Тэгвэл сая тархи чинь “Болж байна. Энэ чинь зүгээр юм байна” гэж ойлгох болно. Сэтгэлээ яг л нохой сургаж байгаа юм шиг сургаж дадуул” (Инээлдэв.) Та нар нохой яаж сургадгийг мэднэ. Нохой хийх ёстой юмаа сайн хийвэл та нар түүнийг шагнадаг. Тэгж байж л тэр нохойг сайжруулна.



Бидний сэтгэл заримдаа их яршигтай!
 Хэрвээ үнэхээр бясалгамаар санагдахгүй байвал
 зүгээр л орхичих. Өөрийгөө битгий их хүчил.
 Зүгээр л өөр юм хий. Ямар нэг дасгал хийж
 эсвэл гүйж болно. Тэгээд ядрахаараа суумаар
 санагдана. Бодол сэтгэл чинь ч саад болохгүй. Ер
 нь ганцаараа байхын бэрхшээл бол: зарим үед
 сэтгэл маань биднийг маш ихээр хуурч мэхэлдэг.
 Ийм үед биднийг зоригжуулж, гараас маань
 хөтөлж явах хэн нэгэн хүнгүй бол бид тийм
 хурдан ахиц гаргаж чадахгүй. Тиймээс бидэнд
 багш, найз нөхөд хамтран бясалгагчид хэрэгтэй
 байдаг юм. Тэдэндээ бэрхшээлээ хэлж болно.
 Заримдаа тэд тусална.

Тийм учир нийтийн бясалгалд аль болох
 байнга оролцохыг хичээ. Хамтран бясалгагч
 нартайгаа асуудал бэрхшээлээ хэлэлцэж болно.
 Хоорондоо найзал, бие биеэ гэртээ урин хамтдаа
 цай, кофе уу. Ингэхдээ хөгжилтэй байцгаа.
 Заримдаа гадуур цуг яв, зугаатай бай. Кино театр

луу явж, хамтдаа ямар нэгэн юм хий, тэгвэл бясалгал чинь нөхөрлөл, зугаацлын нэгэн хэсэг болно. Эхэндээ зарим хүнд энэ бол зайлшгүй хэрэгтэй зүйл. Та нар сэтгэлээ юунд дуртайг олж мэдэх хэрэгтэй. Тэгээд тэр зүйлийг нь бага багаар өгч бай, хэтэрхий хатуурхаж болохгүй.

Зарим хүмүүст бол ингэх шаардлага байхгүй. Өөрсдөө дуртай болохоор тэдний хувьд бясалгал хялбар байдаг. Гэхдээ заримдаа ийм хүмүүс ч ялгаагүй, бясалгалын тодорхой шатанд хүрэхээрээ тэндээ гацчих явдал бий. Гэнэтхэн л цаашид бясалгамааргүй санагдаад явчихна. Энэ тал дээр бүр юуг ч хүсэхээ байчихаад, би Бурхадтай (гэгээрсэн төрөлтнүүдтэй) бишгүй л хамт байлаа гэдэг. Гэхдээ энэ нь түр зуурын байдал. Хожим нь хүмүүстэй нөхөрлөн, оюун санааны амьдралын талаар ном уншин, бичлэг сонсож, бүр гүнзгийрч Бурханы судар шаштир уншдаггүй юм гэхэд ядаж л амьдрал, үхэл, бясалгал мөн Бурханы Орны тухай өөр бусад



хүмүүсийн ойлголт туршлагыг бичсэн орчин үеийн номнуудыг уншвал ямар нэг байдлаар илүү урам орж, тэр хүмүүстэй адилхан ахуй ойлголттой болохыг хүснэ. Тэгээд бид агуу ихээр чармайх болно.

Бид алив зүйлийг хийхдээ өөрсдийнхөө амьдралын хэмнэл болоод хэв маяг, бодол санаа болоод дадал зуршилдаа тохирсон аргыг олох хэрэгтэй. Дадал зуршлыг өөрчлөхөд хэцүү байдаг. Хурдан өөрчлөх боломжгүй бол аажмаар өөрчлөх хэрэгтэй.³⁹

³⁹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайр айлдвар, олон улсын дияан бясалгалын үеэр, Норфолк, Англи, 1999 оны зургадугаар сарын 11, (Англи хэлээр)

Адислал хэдийд ч санаандгүй болно

А: Суугаад бясалгаж нэг л чадахгүй байгаа хүн яавал зохих вэ?

Б: Тэгвэл босоод ойр хавиар хэсэг алхаад, нүүрээ угааж, шүршүүрт ор. Жаахан алхаж байгаад буцаж ирээд дахин оролдоод үз. Битгий бууж өг. Өдөр бүр бясалгана гэдэг чинь заавал өдөр бүр сайн амарч, сайн үр дүнд хүрнэ гэсэн үг биш. Гэсэн хэдий ч та нар өдөр бүр бясалгах хэрэгтэй. Боломж гарах бүрт бясалгах ёстой. Яагаад гэвэл Эзэн Бурханы ивээл адислалд болзоо үгүй. “Маргааш би бууж ирээд амар амгаланг хайрлана, маргааш сайхан ахуй ойлголт өгнө, маргааш чамайг гуравдугаар ертөнц үрүү аваачна” гэж товлохгүй! Тийм байдаггүй юм шүү дээ! Энэ бүхэн хэдийд ч аль ч хоромд ирж



болно, хамгийн санаанд оромгүй цагт ч ирж болно. Тийм учир бясалгахын тулд ямар арга хэрэглэх нь хамаагүй, ердөө л туйлбартай хичээж, дотоодын Бурхандаа залбиран, биднийг залж, дэмжиж, адислахыг Хамгийн Дээд хүчнээс гуй. Бид үр дүн гаргасан ч, гаргаагүй ч өдөр бүр бясалгах хэрэгтэй. Тэгвэл хэзээ ч юм, магадгүй маргааш, магадгүй яг дараачийн мөчид адислал ирж болно. Шантарч л болохгүй. Үүнийг бараагаа зарахын тулд нээлттэй байх дэлгүүртэй зүйрлэж болно. Худалдан авагч хэзээ ороод ирэхийг мэдэх аргагүй. Өдөржин нээлттэй байж хүлээх хэрэгтэй. Худалдан авагч байсан ч байгаагүй ч дэлгүүр өдөржингөө нээлттэй байх болдог. Заримдаа хамгийн сүүлд орж ирсэн худалдан авагч дэлгүүрийг чинь тэр чигт нь эсвэл талыг нь нүүлгээд явчих үе байдаг учраас тэр.⁴⁰

⁴⁰ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Берклийн Их Сургууль, АНУ, 1989 оны аравдугаар сарын 13, (Англи хэлээр)



Хэдийгээр бидний бясалгалын түвшин дээгүүр биш байлаа ч гэмээ наминчлан, чин сэтгэлтэй байж өдөр бүр залбирваас Эзэн Бурханы өршөөл аврал ивээсээр л байх болно.





ИЛҮҮ ХУРДАН ДЭВШИХИЙГ ХҮСЭГЧДЭД

А: Илүү түргэн дэвшихийг хүсч байгаа хүнд бясалгалаа ахиухан хийх тустай байдаг юм бол, яг хэр илүү хийж байж дэвших вэ?

Б: Хэр ахиухан хийж дийлэх, эсвэл хэр ихийг хийхийг хүсэж байгаагаа өөрөө мэдрэх ёстой. Зөвхөн бясалгалд гол нь байгаа юм биш; зүрх сэтгэл, зориг шийдвэрээс хамаарна. “Би үнэхээр зөвхөн үүнийг л хүсч байна” гэж дотроос чинь өгүүлэх чин үнэн сэтгэлтэй байх, дотооддоо хүсэн тэмүүлэх нь бясалгаж буй нэг хэлбэр юм. Зөвхөн суух ч биш л дээ.

А: Би өдөр тутмын амьдралдаа аливаад хэрхэн хандаж үйлдэж байгаа болон сэтгэл санааны хувьд



ямархуу байгаа нь бясалгалд нэмэртэй юу?

Б: Тийм, тийм, тийм: юмыг ямар байр сууринаас харж, яаж өнгөрөөж байгаагаас энэ шалтгаалдаг. Бид энэ талаар эцэс төгсгөлгүй ярьж болох авч, гэхдээ хүн болгон Эзэн Бурханд хүрэх өөрийн гэсэн замтай. Хурдан эсвэл удаан хүрэх нь бидний өөрсдийн л сонголт юм. Та зүрх сэтгэлдээ юу хийхийг тушааж чадахгүй, би ч танд тушааж чадахгүй. Танд хүсэл байвал тэр, байхгүй бол тэр. Нэг л өдөр та энэ дэлхий, энэ худал хуурамч байдал болоод хоосон төөрөгдлөөс залхана. Тэгээд л дотооддоо хандах болно. Хэчнээн ч удаан сууж бясалгасан хамаагүй болно, учир нь та зориг шулуудчихсан байх юм. Та зүрх сэтгэлдээ Эзэн Бурхантай үргэлж хамт байна. Энэ л жинхэнэ бясалгал юм. Ийм байх нь танд маш таатай сайхан санагдана. Тэр үед та үүнийгээ ойлгож, өөртөө үнэн сэтгэл буйг мэднэ. Урьд өмнө нь та үүнд үнэн сэтгэлээсээ хандах гэж маш их чармайж байсан, гэхдээ та ердөө зөвхөн чармайж байсан хэрэг. Үүнд л ялгаа нь байгаа юм!⁴¹

⁴¹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Лондон, Англи, 1998 оны гуравдугаар сарын 10, (Англи хэлээр)

Гашуун бясалгал үйл лайг арилгахгүй

А: Их Багш аа, гашуун бясалгал биднийг Бурханы хутагт хүргэж чадахгүй хэдий ч бидний үйл лайг зайлуулж, зарим үйлийн үрийг маань арилгаж тус нэмэр болох уу?

Б: Үгүй, чадахгүй! Хатуу гашуун бясалгал ямар ч хэрэггүй. Дотоодын Бурханаа тэгж доромжлох хэрэг юу байна? Эзэн Бурхан бидний дотор оршиж байгаа. Түүнийг доромжлох нь, Бурханыг доромжилсон хэрэг. Та Түүнийг гомдоож байна. Бурхан Шагжамуни гашуун бясалгалаар хэсэг бясалгасныхаа дараа болихоос өөр аргагүй болсон шүү дээ. Тэр эцсийн эцэст жинхэнэ зөв аргаар бясалгахын тулд гашуун бясалгалыг хаясан юм. Ингэж байж л тэр гашуун бясалгалаар салгаж чадаагүй үйл лайгаа арилгасан.



Зөв аргаар бясалгаж байхад гашуун чанга дэглэм бага зэрэг барьж байна уу, эсвэл тансаг сайханд санаснаараа умбаж байна уу хамаагүй. Нэгэнт зөв замаар орсон хойно таксигаар явна уу эсвэл Мерседес Бенз, Роллс Ройзоор явна уу ялгаа байхгүйтэй адил. Зөв замаар яваа нь чухал болохоос, ямар хөсгөөр явах чухал биш. Сая би такси бариад л энэ танхимд хүрч ирсэнтэй яг адилхан. Та нар магадгүй, автобус, Роллс Ройзоор ч юм уу, эсвэл өөрсдийн тэргээр ирсэн байх, та нар мөн л энд ирчихсэн байна. Яагаад гэвэл бид бүгд зөв замаар явсан учраас тэр. Гашуун бясалгал сайн уу, муу юу гэдэг бол асуудал биш, хамгийн гол нь зам мөр л зөв байх ёстой. Арьяабалын аргаар бясалга, тэгвэл та чөлөөлөгдөн гэтэлж үйлийн үрийн зовлонг үгүй хийж чадна!⁴²

⁴² Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайр айлдвар, Хонг Конг, 2000 оны талдугаар сарын 2, (Хятад хэлээр)

Үнэн зөв аргаар бясалгахуй

Бидний энэ аргаар бясалгах маш амархан. Нэгэнт л бид зөв замдаа орсон болохоор бид хүссэн хэрээр элбэг дэлбэг хоол ундтай амьдарч болно. Аврал өршөөлдөө багтаахын тулд биднийг үхтлээ өлсөж, зовохыг шаарддаг тийм Бурхан хаа байдаг юм бэ? Тэгвэл ямар ч утгагүй. Бид бясалгахын зэрэгцээ яагаад биедээ арчаатай байж болохгүй гэж? Үүнд ердөө ямар ч учир зүй алга. Жишээ нь, хэрвээ бидний эцэг эх маш баян бөгөөд бидэнд маш их хайртай бол, биднийг сурч мэдлэг эзэмш гэх байх л даа. Тэгээд биднийг өсч томроод тодорхой чадвартай болсон цагт бидэнд өв хөрөнгөө даатган өвлүүлнэ. Цаг нь болоогүй байхад бид эд хөрөнгөө яаж авч явах ухаанаа олохгүй гэж санаа зовсных.



Мэдээж хэрэг бид сурч боловсорно, гэхдээ сурч байх үедээ ч хоолтой ундтай, өмсөж зүүх юмтай байж, цэнгэн наадаж болно. Яагаад? Яагаад гэвэл бидний эцэг эх баян учраас л тэр, ойлгож ядах юмгүй. Үүнтэй адилаар, бид Бурхан чанараа олж авах, Эзэн Бурхантай нэгдмэл болох гэж бясалгаж байна, харин Будда болон Эзэн Бурхан бол хамгийн баян нь шүү дээ. Та нар тарчиг ядуу Будда байхыг харсан уу? (Инээлдэв.) Энэ бол боломжгүй зүйл. Ертөнц бүхлээрээ түүнийх. Тэнгэр Бурханы Орон болоод газар дэлхий түүнийх. Тэгэхээр Тэр яаж ядуу байх юм бэ? Тэр хамгийн дээд эрх мэдэлтэй, хамаг бүхний эзэн нь Тэр. Тэгвэл бид яагаад зориудаар гуйлгачин мэт байх ёстой гэж? Бид түүний баялгийг эзэмшин, Түүний түвшинд хүрч, Түүнтэй нэгдмэл болох гэж бясалгадаг. Гэхдээ бид Түүнтэй нэгдэж, Түүний өв хөрөнгөнд хүрэхээсээ өмнө ядаж л хангалттай ууж идэж, тоглож цэнгэх хэрэгтэй. Яагаад бид зовсон дүр эсгэх ёстой гэж?

Иймд оюунлагийг дадуулахад хамгийн чухал нь зөв үзэл барьж, зөв аргаар бясалгах явдал юм. Ингэж чадвал хамгийн эгэл жирийн байдалд ч хангалуун амьдарч чадна. Буруу үзэл болон буруу бясалгалын арга нь яршиг түвэг л авчирдаг.⁴³

⁴³ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1992 оны долдугаар сарын 5, (Хятад хэлээр)



Гэгээрэлд хүрэх зам мөр

Өөрийгөө золиослох сэтгэл үгүй бол бид өсч дэвшиж чадахгүй. Ийм маягаараа бид хэдэн зуун жил бясалгасан ч үр дүнд хүрэхгүй. Өөрийгөө бусдад биш, зөвхөн өөртөө зориулна гэдэг Бодьсатвагийн (гэгээрсэн төрөлхтний) явдал биш. Тийм түвшинд хүрэхээс хол байна гэдгээ ойлговол зохино. Бид бусдыг бодохгүй байх тоолондоо л сөрөг хүч Маяатай нөхөрлөж буйгаа ухаарах хэрэгтэй. Бурхан (гэгээрсэн төрөлхтөн) ба Маяагийн цорын ганц ялгаа энэ юм. Бусдын тухай бодохдоо өөрийн биеийг огт хайхардаггүй бол Бурхан боллоо гэсэн үг. Зөвхөн хувиа бодож, бусдыг мартвал бид нүгэлтэн болж байгаа юм. Энэ хэмжүүрээр бид өөрсдийгөө үнэлж болно. Аль түвшинд яваагаа эсвэл Бурханы хутгийг олсон эсэхээ надаас асуултгүй!

Намайг Бурхан гэдэгт та нар итгэдэг. Яагаад гэвэл би цаг үргэлж зөвхөн бусдыг бодсоор өөрийн ашиг тус, гарз хохирол, ирээдүй, эрүүл мэнд, тав тух, нэр хүнд болон хэрэгцээг умартаж, эдгээрийн алийг ч ойшоохоо больсон. Амжилт олох олохгүйгээс хамааралгүйгээр би бусдын төлөө амь биеэ золиослоход бэлэн байдаг. Амжилт олох үгүйгээр үүнийг бид хэмжиж болохгүй. Сайн үйл хийх бүрийд амжилт олох албагүй. Тийм биш! Энэ нь үхэж буй амьтдыг авран хамгаална гэсэн бидний тангаргаас, хамаг амьтны төлөө өөрсдийгөө золиослон зориулах чин сэтгэлээс хамаарна.⁴⁴

⁴⁴ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын гурав хоногийн дияан бясалгалын үеэр, Пном Пен, Камбож, 1996 оны гуравдугаар сарын 28 (Хятад хэлээр)



Амь биеэ хайрлахгүй тусыг бүтээх

Иймд, бид амь бие хайрлахгүй бусдад үйлчлэх хэрэгтэй, тэгвэл бүх зүйл аяндаа болно. Ингэж та нарт хэлэхэд хэцүү л дээ, учир нь та нар “Эхлээд Эзэн Бурханы Вант улсыг хайж ол, тэгвэл бүх зүйл өөрт чинь ирэх учиртай” гэдгийг л байнга сонсож байсан. Гэтэл Эзэн Бурханы Вант улс гэдэг маань юу билээ? Эзэн Бурханы Вант улс зөвхөн ганц танд зориулагдсан биш юм. Хэрвээ надад Эзэн Бурханы Вант улс гэж байдаг юм бол бүгд л тэнд багтах учиртай. Тийм биш тохиолдолд би тийшээ явахгүй, бусдыгаа хүлээнэ. Хүн төрөлхтөн тэр аяараа зовж зүдрэн, дөрвөн хөллөн мөлхөж байхад ганцаараа эсвэл цөөхөн хэдэн шавь, та нартай Эзэн Бурханы Вант улсад цэнгэн суух надад юу нь сайхан байх вэ? Тэгж ярих юм бол, Эзэн Бурханы Вант улс гэдэг бол хамаг амьтан бүгд гэгээрсний дараа тогтнодог юм.

Бусдын аз жаргалын төлөө зүтгэх нь амиа хичээж явснаас дээр гэж би боддог. Хэрвээ та нар ийм замаар явах юм бол ямар ч сайхан ахуй ойлголт олсноос илүү сэтгэл хангалуун байх болно. Ийм замаас битгий гажаарай. Гэхдээ та нар давгүй байгаа. Хийж буйгаа хийж л бай. Бусдад үйлчил, тэгвэл ямар ч ахуй ойлголт, ямар ч Гэрэл харж, ямар ч Бурханы дүрийг үзсэнээс илүү сэтгэл хангалуун байх болно. Би үнэнийг хэлж байна. ⁴⁵

⁴⁵ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Техас, АНУ, 1993 оны арваннэгдүгээр сарын 12, (Англи хэлээр)



Амьтны тусыг бүтээх ажил нь мэдээжээр ямар ч ашиг, цалин мөнгө авчрахгүй. Гэхдээ хамаг амьтанд үйлчилж буй маань хүндтэй хэрэг юм. Энэ ажил нь өөрөө хамгийн дээд шан харамж, гавьяа мөн.

Бид хэдий их ажиллана төдий чинээ гэгээрдэг

Бид өөрсдийнхөө төлөө л ажиллаж байдаг юм шүү дээ, учир нь байнга ажиллаж байдаг хүний тархи нь хариу үйлдэл хурдан хийдэг, мөн бэрхшээлтэй асуудлууд тулгарахад тэдгээрийг ямар ч атугай даван туулдаг. Энэ нь бидний дадал болж, асуудал бэрхшээлтэй тулгарсан үедээ түргэн шуурхай ажиллаж, хурдан шийдвэрлэж чаддаг болно. Байнга ажиллаад байдаггүй хүн аливаа зүйлд хариу үйлдэл хийхдээ удаан байдаг. Санаа нь хэчнээн сайхан байлаа ч ажил хийх хар ухаан байдаггүйгээсээ болж тийм хүн юмыг түргэн хийж чаддаггүй. Тэд аливаад хурдан шалмаг хандаж сураагүйгээс юм хийхдээ тийм ч нямбай байж чаддаггүй.



Анзаарга сэрэмжээ сайжруулъя гэвэл бид аль болох байнга хөдөлмөрлөж байх хэрэгтэй. Хүн хэдий чинээ их ажиллана, төдий чинээ туршлагажиж нягт нямбай болдог. Мэдлэг ухаан гэдэг зөвхөн сурснаас ч биш мөн дадлага туршлагаар бий болдог. Ямар ч ажлын хувьд энэ адилхан байдаг. Хүн их ажиллах тусмаа хариу үйлдлийг улам хялбар бөгөөд хурдан хийж, мөн улам илүү чадварлаг болдог. Бид өөрсдийгөө сургах замаар энэ дадлыг хөгжүүлж болно.

Юманд хурдан шалмаг хандаж, бүх төрлийн ажлыг хийх чадвар зөвхөн гэгээрсний дараа л надад бий болсон юм биш. Би хүүхэд байхаасаа л ийм байсан, яагаад гэвэл би ажилд дуртай. Намайг найм билүү есөн настай дунд сургуулийн сурагч байх үед манайх гурав, дөрвөн гэрийн үйлчлэгчтэй байсан. Хэдий тийм байсан ч би өөрөө усаа авч, түлээгээ цуглуулж, хагалдаг байсан. Хааяа би эцэг эхдээ хоол ундыг нь хийж өгч, аавдаа цайг нь чанаж, усанд орох усыг нь халааж өгдөг байлаа. Би хувцасаа өөрөө

угааж индүүдэн, өөрөө өөрийгөө авч явдаг байсан бөгөөд гэрийн үйлчлэгч нараар өөрийгөө халамжлахыг эсэргүүцдэг байв. Бүр бага сургуулийн 2-р ангид байхаасаа эхлэн би өөрөө өөрийгөө авч явж ирсэн юм. Ингэж л би хурдан шалмаг байж сурсан. Би Гэгээнтэн болоод та нарт үүнийг ч хий, түүнийг ч хий гэж хэлж суух гэж Бурханы Орноос бууж ирсэн юм биш. Та нар намайг ямар ч ажил хийж чаддагийг харж байгаа. Би цементийн юм хийсэн ч бай, мужааны ажил ч бай, ямар ч ажлыг би өөрөө мэргэжлийн хүнээс ч илүү хийж чадна.

Ажил бүхэн бидний суралцах, дэвших арга хэрэгсэл юм. Угтаа бол бид ямар ч ажил хийдэггүй. Та нар өөрсдийгөө маш их ажиллаж байна гэж бодох эсвэл гомдоллох хэрэггүй. Ажиллана гэдэг бол ердөө л суралцах арга хэрэгсэл юм. Эзэн Бурхан биднийг боловсруулж, гэгээрүүлэхийн тулд мөн бидэнд авьяас чадвар, зан чанараа хөгжүүлэх, зөв сайхан биеэ авч явах, анзаарга сэрэмжээ хөгжүүлэх боломж олгохын



тулд энэ аргыг хэрэглэдэг. Энэ аргаар дамжуулж бид дандаа шинээр юм сурч байдаг учир ажил бүхэн адилхан.

Хэрэв бид ажилдаа үнэхээр анхааралтай хандвал юу ч хийсэн ямар нэг юм сурч авдаг. Энэ нь үлгэр дуурайлыг даган ажиллах зуураа өөр бусад зүйлийг ойлгож мэддэгтэй адилхан. Тийм ч учраас заримдаа бид ажил хийхээрээ гэнэт олон зүйлийн талаарх үнэнийг ухаардаг. Ажил гэдэг бол өөрсдийгөө дарж зөөлрүүлэхэд болон хувийн зан чанар, тэсвэр хатуужил, авьяас чадвар, гэгээрлийнхээ түвшинг хэмжихэд тус болдог арга юм. Тэгэхээр та нар ажиллахаас айх хэрэггүй. Ажлаас айна гэдэг нь мөн нэгэн төрлийн сэтгэцийн өвчин юм. Бид хэдий чинээ их ажиллана, төдий чинээ их гэгээрнэ.⁴⁶

⁴⁶ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайр айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1992 оны дөрөвдүгээр сарын 25, (Хятад хэлээр)



Аливаа ажлыг гавьяа шагналын төлөө бус харин зөвхөн хайрын үүднээс хийхэд бүх зүйл огт саадгүй бүтдэг. Энэ ажлаас өөрт ч юм уу, өөр хэн нэгэн хүнд ашиг тус гаргах гэж сэтгэл зовних хэрэггүй. Тухайн үед хийх ёстой юмаа л хийдэг. Ийм байвал оюун санааны амьдрал маань өдөр өдрөөр сайжирч буйг бид мэдрэх болно. Бид илүү тэсвэр тэвчээртэй болно, хэр их ажиллаж, хэр их зүйлийг бусдад зориулна, тэр хэмжээгээрээ хурдан дэвшинэ. Бидэнд хэний ч магтаал хэрэггүй. Бид юу хийж байгаагаа өөрсдөө мэднэ.



Өөрийнхөө эзэн байж төгс төгөлдөр болох нь Их Багш байхын гол утга учир мөн

Багш бол төгс төгөлдөр хүн биш. Хэзээ ч тийм байгаагүй, тийм байх ч үгүй. Та нар түүнийг мэдэж авах хэрэгтэй. Гэхдээ Багш гэдэг бол алдаа дутагдлаа засч залруулж чаддаг хүн. Бид тэднээс суралцаж, өдрөөс өдөрт сайжирна гэж өөрсдөдөө амлаж болох юм. Суут хүн байх гэдэг түүнээ хадгалахын тулд тасралтгүй шургуу хөдөлмөрлөхийг хэлдгийн нэгэн адил Их Багш байна гэдэг нь өөрийгөө төгөлдөржүүлэхийг л хэлэхээс биш өөр юуг ч хэлж байгаа юм биш. Харин дашрамд нь Хэн нэгэн хүн Түүнийг шүтэх нь ердөө гэрлэн биед нь татагдсан хэрэг. Чин үнэн сэтгэл нь дотроосоо тэднийг татдаг юм. Тийм болохоор Түүнд ярих шаардлага байхгүй. Тэр байтугай тэдэнд юу ч хэлэлтгүйгээр тэд Түүнд итгэдэг. Багш байна гэдэг ийм байдаг.

Намайг төгс төгөлдөр төрсөн, одоо төгс төгөлдөр байгаа, эсвэл төгс төгөлдөр болно гэж бүү бод. Тийм биш ээ! Би та нартай л адил суралцаж байна. Гэхдээ би өөрийнхөө эзэн болчихсон. Би юу хийхийг бодол сэтгэлээрээ заалгадаггүй, учир нь би сэтгэлээ мэднэ. Би түүнтэй найзалж “Чи түүнийгээ хий, би үүнийгээ хийе, харин бие биедээ саад болохгүй шүү. Хэрвээ чи юмаа сайн хийчихвэл, би чамайг шагнана. Чамайг сайн хооллоно, би тэгдэг л биз дээ?” гэж тохиролцдог. Түүнд “Хүссэн цагт чинь би чамд юу дуртайг чинь өгнө” гэж хэлдэг. Харин нэг онцлог нь, тэр их юм хүсдэггүй, учир нь надаас их юм салгаж чадахгүйгээ мэддэг юм. Тиймээс ч тэгсхийгээд нөгөөхөө мартчихдаг. Сэтгэл унтахыг хүсч байхад ч хүртэл би “Үгүй шүү, босч ажлаа хий” гэж хэлдэг. Тэгэхээр тэр хийхээс өөр аргагүй болдог юм даа. Ингээд арван жилийн дараа гэхэд тэр үүнд маань бүр дасчихаад “Энэ бүсгүйтэй яриад ч хэрэггүй дээ. Дэндүү зөрүүд, юу хүссэнээ л хийчихдэг юм чинь маргаад ч хэрэггүй” гэх болсон.



Багш байна гэдэг бол төгс төгөлдөрт хүрэхийн төлөө, илүү сайн сайхан, эрхэм ариун бие хүн байхын төлөө - (үгүй ээ, бие хүн байхын төлөө биш юм байна, бие хүн гэхээрээ нэр төр, алив бүхнийг хүссээр л байдаг) - улам эрхэм зорилгын төлөө тасралтгүй тэмүүлэхийг хэлдэг юм. Энэ биедээ эрдэгч “би” үзэл - Өөрт нь үгүйг Багш мэднэ. Хийхсэн гэж хүсдэг зүйл нь, юуг бусдад ашиг тустай эрхэм ариун, дээд хүсэл гэж Түүний боддог нь хэрэв сайн зүйл мөн бол - түүнийгээ Тэр заавал хийх гэж оролдоно. Ямар ч үнээр хамаагүй түүнийгээ хийчихээд, тэр тухайд харин ярьдаггүй. Ялгаа нь ердөө л энэ. Эс бөгөөс ялгаа юу байна?

Бид одоо уураг тархиндаа мэс засал хийлгэлээ гэхэд хэнийх нь ч тархи нэгнийхээсээ тэгтлээ илүү байж чадахгүй. Магадгүй миний оюуны чадавхи арай илүү, эсвэл таных илүү байж болно, гэхдээ энэ нь бид хоорондоо их ялгаатай гэсэн үг биш. Бидний тархи яг адилхан. Сэтгэлийн тэнхээ маань ч адилхан, та нар түүнийгээ

хөгжүүлж байна уу, үгүй юу гэдэгт л ялгаа байгаа юм. Энэ бол таны чөлөөт сонголт.

Бидний дийлэнх олонхи нь чөлөөт сонголтоо тэнэг буруугаар ашиглаж, өндөр дээд ухамсарт хүрэх хөгжил дэвшлээ сааруулж байдаг. Яагаад илүү өндөр өөд тэмүүлэн тэмцэх ёстой юм бэ гэж надаас бүү асуу. Ямар нэгэн юм болохыг хүлээгээд хэвтэж байдаг “бордмол гахай” адил цаг үргэлж залхуу, удаан, мунхаг, хойрго нэгэн байснаас эрхэм ариун, билгүүн ухаант нэгэн байх нь илүү сайхан шүү дээ.

Намайг шүтэж бишрэхийн оронд ердөө л үлгэр дуурайлыг минь дагасан нь дээр. Зүтгэл чармайлтаас минь гарсан үр дүнг л шүтэж биширч, дагаж хий. Намайг дуурай, тэгвэл нүд ирмэхийн зуур Багш болно.⁴⁷

⁴⁷ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Лос Анжелес, КА., АНУ, 1996 оны гуравдугаар сарын 13, (Ангил хэлээр)



Сэтгэлээ дадуулж, өөртөө итгэж сур

Бид аз жаргалтай байх ёстой, тэгээд өөртөө итгэлтэй, эерэг өөдрөг байх хэрэгтэй. Өөрсдийгөө доогуур дэстэй байна гэж бодох бүрийдээ тэр бодлоо таягдан зайлуул. Сэтгэл санаа хямарсан эсвэл сул дорой болсон мэт санагдах болгонд тэр бодлоо гаргаж хая! Ингэх нь хэцүү л дээ, гэхдээ ингэж байж л та нар гуниг гутралаасаа сална. Тэгснээр та нар дэвшиж чаддаг юм. Та нар Тавдугаар дэсэд хүрнэ гэж хүсч байгаа хэрнээ өөрсдийгөө доогуур дэстэй, үйлийн үрэндээ дарагдсан гэх зэрэг сөрөг бодол тээж байж таарахгүй. Та нарыг ийм байхад би яаж тус болох юм бэ? Аль дэсэд очихыг хүсч буйгаа та л шийднэ, би шийдэхгүй, та нар л өөрсдийгөө адисладаг.

Би “За, та тавдугаар дэсэд хүр, би адислая” гэж хэллээ гэж бодъё л доо. Гэвч та нар сэтгэлдээ сөрөг зүйл бодож, санаагаар уначихсан, гутрангуй үзэлд автсан хэвээрээ байвал нэмэргүй. Та нар сэтгэлээ сургах ёстой. Сэтгэлдээ өөрсдийгөө эзэн чинь байна гэж хэл. Юу бодохыг нь, юу хийхийг нь, юу мэдрэхийг нь, ямар дэсэд харьяалагдах ёстойг нь ч хэл. Үүнийг хийж чадвал та нар өөрсдийнхөө эзэн, Багш болжээ гэж ойлго. Өөртөө итгүүлэхэд л хэцүү байгаа болохоос биш та нар хэдийнээ багш юм шүү дээ. Өөртэйгөө ажиллацгаа. ²⁸

²⁸ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын гурав хоногийн дияан бясалгалын үеэр, Лос Анжелес, АНУ, 1998 оны арванхоёрдугаар сарын 16-наас 18 (Англи хэлээр)



Хэлбэлзлийн хурдтай болох

Хэлбэлзэл нь маш доогуур бөгөөд асар удаан, тэгээд удаан сэтгэж, удаан ажиллаж, удаан ярьдаг хүн юу хийж чадах юм бэ? Ямар ажил хийж дийлэх юм? Чухам яаж амьтан хүнд туслах юм? Түвшин ийм доогуур, хэлбэлзэл нь ч ийм доогуур байж байдаг. Хэлбэлзэл доогуур байх тусам, хөгжлийн түвшин доогуур байдаг юм. Жишээ нь, чулуу маш хатуу учраас хөдөлж чадахгүй. Мод жаахан л хөдөлж чадна, гэхдээ заавал гадны нөлөө тусламжтайгаар. Дараагийн түвшинд өөрсдөө хөдөлж чадахуйц хорхой шавьж, загас жараахай болон бусад төрлийн амьтад болох боловч, тэд бас л удаан сэтгэдэг. Гэвч бид хүн учраас, илүү хурдан байх хэрэгтэй. Бид өндөр давтамжтай, хурдан хэлбэлзэлтэй байх ёстой. Эс бөгөөс бид гүйцэж түрүүлэн, урагшилж, өсч, хөгжиж, сайжран,



дэвшиж чадахгүй. Бид амьтан, мод, чулуу, хорхой шавьж байсан шигээ үргэлж тийм болхи удаан байгаад байж болохгүй. Одоо бол бид өөр. Тэр хуучин хэлбэлзэлдээ хоргодоод байж болохгүй. Түргэн хөдөлж сэтгэх хэрэгтэй.



Бид урьд төрөлдөө мод чулуу, хорхой шавьж байсан гээд, үргэлж тэндээ л, тэр түвшиндээ л гацах ёстой гэсэн үг биш. Өөрсдийгөө өөр түвшинд байгаа гэдгээ одоо ойлговол зохино. Бид хурдан хөдөлж, дэвших хэрэгтэй. Хурдан сэтгэн бодох, аливаа зүйлийг хурдан хийх энэ боломжийг ашиглах хэрэгтэй, энерги чинь хурдан эргэлдэх хэрэгтэй байна. Тэгвэл бид Бурхан болоод Эзэн Бурханы хэлбэлзэлтэй тэнцэхүйц болтлоо улам улам хурдалж чадаад, тэдэнтэй нэгдмэл болж, тэдний адил оюунлаг болох боломжтой. Тэгж бид өөрсдөө Бурхан болох юм.

Та нар хоцрогдчихоод, өөрсдийгөө өмөөрч шалтаг тоочин, Багш биднийг шахлаа гэж буруутгаж болохгүй. Би та нарыг шахах хэрэгтэй. Тэгэхгүй бол та нар үүрд тэндээ үлдэх болно. Би та нарыг амь оруулж, шаламгай ажиллаж, түргэн сэтгэж, хурдан ярьдаг болгох хэрэгтэй байна. Та нар хэлбэлзлээ бүр хавьгүй илүү хурдтай

түвшинд хүртэл дээшлүүлж, улам хурдан, бүр хурднаас хурдан байх ёстой. Оюунлаг хүмүүс маш хурдан хариу үйлдэл хийдэг. Хурдан сэтгэдэг. Бурхад болоод Гэгээнтнүүдийн хэлбэлзэл маш хурдан учир тэд асар түргэн ажилладаг. Тэдний хэлбэлзэл тийм хурдан учраас нэгэн зэрэг зуун мянган ажлыг ч хийж чадна. Тэд огт ажиллахгүй байгаа мэт харагдталаа тийм хурдан байдаг. Гэтэл тэд цаг үргэлж, 24 цагийн турш ажиллаж, бүхий л төрлийн ажлыг нэгэн зэрэг хийж байдаг. Тэд маш хурдан хөдөлдөг учраас хөдлөхгүй л байгаа мэт харагддаг. Тийм учир “үйлдэвч эс үйлдэх” гэж ярьдаг юм.⁴⁸

⁴⁸ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Коста Рика, 1991 оны хоёрдугаар сарын 2, (Англи хэлээр)



Олны тусыг бүтээх нь үйлийн үрийг арилгах хамгийн хурдан арга зам мөн

Б и Төв дээр байхаараа юм маш өөр байгааг мэдэрдэг юм. Тийм учраас би та нарт энэ маягийн үйлчилгээний ажил хийхэд үйлийн үр маш түргэн арилдаг гэж хэлсэн. Жишээлбэл, та нар ямарваа төлбөрийг нэг нэг доллараар нь цувуулж хийвэл маш их цаг авна. Харин нэг мөсөн бөөнөөр нь төлбөл дорхноо л барагдана. Тэгэхээр иймэрхүү ажил хийнэ гэдэг чинь өрөө бүгдийг нь нэг дор төлж байна гэсэн үг, учир нь олон хүн үр шимийг нь хүртэх тул өр барагдана.

Хэрэв бид зөвхөн ганц хүний төлөө, эсвэл мөнгө төгрөг, ашиг хонжоо хайж зөвхөн өөрийн амь амьдралаа л бодож ганцхан ажил олгогчийн төлөө ажиллах юм бол, мэдээж, ашиг тус нь тэр



хэмжээнд л байх болно. Гэтэл дээрх маягийн ажлыг өөрсдөдөө ашиг олох гэж биш, хөрөнгө мөнгөний ч төлөө биш, харин олон олон хүний эрх ашгийн төлөө хийвэл энэ ажил нь илүү өргөн хүрээтэй болох юм. Буян хариулал нь асар илүү байх учир бидний үйлийн үр ч үтэр түргэн ариусгагдана. Бид энэ дэлхийд маш их өртэй



байдаг, тэр хэмжээгээрээ ч бас одоо эргүүлэн төлж байдаг. Дээрх замаар л өрөө хурдан төлж чадна. Өөрөөр яаж төлж барах вэ?

Бид асар олон хүнд, бүх хүн төрөлхтөнд маш их зүйлийн өртэй. Хэрвээ бид өрөө бүхий л хүн төрөлхтөнд буцааж төлөхгүй, харин хоёр, гуравхан хүнд л төлөх юм бол, өчнөөн эрин галавын хугацаа шаардагдана! Бид энэ гариг дээр амьдарч байгаа л болохоор бүхий л дэлхийд өртэй. Заримд нь зүлэгний өртэй, заримд нь замын өртэй, заримд нь хувцас, заримд нь будаа тарианы өртэй. Бүх дэлхийд өрөө төлсөн цагт л бид ариусч чадна. Бид асар олон хүнд өртэй, тиймээс ч асар олон хүнд түүнийгээ буцаан төлөх хэрэгтэй болдог. Төвийг маш олон хүн ашиглах учир иймэрхүү ажлыг хийснээрээ нэгэн зэрэг олон хүнд өрөө буцаан төлөх боломж гаргадаг. Өрөө бүхлээр нь төлөх арга зам энэ. Иймээс л бидний үйлийн үр хурдан арилдаг юм.

Энэ дэлхийд төрснөөрөө бид олон хүнд өртэй, будааны ч өр, хувцасны ч өр, өөр бас ... Хүн болгон бидний ивээн тэтгэгч, тиймээс заримд нь бид шууд холбоогоор төлдөг, жишээ нь эцэг, эх, үр хүүхэд, багш нартаа. Бид тэдэнд мөнгө өгдөг, хайраа өгдөг, ийм маягаар заримд нь бид өрөө төлж чаддаг. Харин дэндүү хол хүмүүст татвараар дамжуулж ч юм уу, эсвэл ямар нэг өөр замаар тус хүргэж, цаашлаад бусад хэлбэрээр өрөө төлдөг. Гэхдээ бид өөр улс орон уруу төлөх боломжгүй. Хэрвээ өөрийн улс дотор бол татвар төлж, яаж ийгээд өгөө аваа тэнцэх байх. Харин бусад улс орноор орж ирсэн эмчилгээний багаж хэрэгсэл, химийн нээлт болон импорт, экспортын тэр бүх зүйлүүдийн төлөө бүгдэд нь яаж талархаж, бүгдэд нь шууд болон шууд бусаар өрөө яаж төлөх билээ?



Бид одоо Коста Рикад төвтэй боллоо. Та нар ирж бие засах газар барьж, муу усны нүх ухаж, мод тарьж, бясалгалын төв барив. Мөн зүлэг засч, зам тавьж, хүмүүс тухлах талбай байгууллаа. Тэгээд олон орны хүмүүс хүрэлцэн ирээд, энэ бүгдийг таашаан хэрэглэж байна. Тэгэхээр та нар нэг мөр бүх өрөө төлж байгаа нь энэ юм.⁴⁹

⁴⁹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Коста Рика, 1991 оны хоёрдугаар сарын 2, (Англи хэлээр)



Бид олон түмэнд үйлчилж
байхад Эзэн Бурхан бидэнд бас
үйлчилж байдаг.
Орчлон ертөнц ийм хууль дээр
оршин тогтнодог юм.



Бид ямар нэг зүйлийг хүсч шаардсанаар, зүрх сэтгэл аль нэгэн газарт хорогдсоор байх юм бол Чөтгөрийн Эзэнд ашиглагдах болно. Бид ямар ч айдас, хүсэл шунал үгүй болж, байгаадаа сэтгэл хангалуун бүр юу ч үгүй байсан ч хамаагүй байвал ямар ч урхи занга үгүй болно. Мөн бид ямар ч гамшиг, самуунаас айхаа болино.

Өөрийгөө золиослох, үнэн хайрын тод жишээ бай

Амьд мэнд л байгаа цагт бид хамаг амьдралаа сайн сайхан үйлс, хүн төрөлхтөн хийгээд бүх дэлхий, бүхий л орчлон ертөнцийн хөгжил дэвшилд зориулах учиртай. Бидний зорилго асар том, бүр амьдралаас ч агуу байх ёстой. Энэхүү зорилгоосоо өөр алдах юм юу ч байхааргүй, тийм л эрхэм ариун байх ёстой. Ийм зорилго хүсэлтэй хүмүүсийн хувьд ямар ч бэрхшээл жижгэрч, амин хувийн ая тухын асуудал утгагүй зүйл болон хувирдаг. Бид мөрөөдөл ярьж, хийсвэр зорилго үүсгэж байгаа биш, нэг л өдөр энэ биеллээ олно гэж надад санагдаж байна. Үүний үндэс хэдийнээ тавигдчихсан байгаа байх, харин одоо тал бүр лүү мөчирлөн салаалж, гөлөглөн, дахин цэцэглэж шинэ шинэ мөчрүүд бий болох хэрэгтэй байна. Тэгээд асар хурдан, улам агуу болон өсч томорч, бүхий л дэлхийг хайр, халамж, хариу үл нэхэх тусламжийн



сэтгэлээр өлгийдөх ёстой.

Энэ дэлхий дээр солих хэдэн хувцас, биеэ тэжээхэд хүрэлцэхүйц хүнснээс өөр юу шаардлагатай юм бэ? Бид юунд энэ дэлхийн эд хөрөнгө, байр суурь, эрх мэдэл, нэр төрд шунаж, шаналж байх ёстой вэ? Өдөрт хоёр, гурваас илүү олон удаа хоол идэж бид чадахгүй, дулаан байхын тулд хэдхэн хувцас байвал болчихно, энэ биеийнхээ хэрэгцээг ийм багахан гэдгийг мэдчихвэл бидэнд санаа зовж айх юм алга шүү дээ.

Энэ бие махбодоо орших болсон ч зүгээр. Бидэнд хэрэгтэй бол дахиад нэгийг өгчихнө. Хэрэггүй бол тэр л биз. Эргэж төрөхгүй байсан ч асуудалгүй. Харин энэ дэлхий дээр байгаа цагтаа бид амьдралаа утга учиртай болгох ёстой. Эс бөгөөс өөр юуны төлөө бид амьдарч байгаа гэж? Эрт орой хэзээ нэгэн цагт үхэх маань гарцаагүй. Тэгээд өнгөрүүлсэн амьдралаа нөгөө ертөнцөөс эргэн харахад, хэдэн арван жилийн үйл хэрэг, үг хэл, үзэл бодол маань ямар ч утга учир, ялгуун бахдам

зүйлгүй байсан бол дарамттай санагддаг. Ингээд л хүмүүс энэ дэлхийд эргэж ирэхээс өөр аргагүй болдог юм.

Бидний өөрсдийн хүн чанар, ухамсраас өөр бидэнд шүүлт тулгаад сууж байх хэн ч байхгүй. Хаашаа ч зугтаж болдоггүй ганц юм чинь л тэр. Эзэн Бурхан биднийг өршөөчихөж болно, хамаг дэлхий явдал хэргийг чинь мэдэхгүй байж болно, харин бид өөрсдөө мэдэж байдаг. Хуурч, худлаа хэлж, зугтаж чадахгүй цорын ганц хүн бол бид өөрсдөө юм. Тэгэхээр бид юу ч хийсэн бай, өөрсдөдөө ашиг тустай зүйл л хийх хэрэгтэй. Бусдын тусыг бүтээснээр бид өөрсдөдөө тус болж байдаг. Бид өөрсдийнхөө нүдээр юу хийж байгаагаа, хийсэн болгоны маань ашиг тус хүмүүст хэрхэн хүрч байгааг, бидний гаргаж буй хүчин чармайлтаар дэлхий хэрхэн хөгжин дэвшиж байгааг тодорхой харж болно. Үүнийг бид илтэд мэднэ. Бидний зорилго эрхэм, дээд бөгөөд агуу хүчирхэг байх учиртай. Эс бөгөөс зөвхөн идэж ууж, ажил хийж, үр удмаа өсгөхөөс өөр юмгүй, ямар ч эрхэм




сайхан үзэл санаагүй, өндөр дээд учир зорилгогүй, амьтан мэт амьдрахын хэрэг юу байна? Яагаад бид агуу сүр хүчтэй, ариун дээд оюун санаатай хэрнээ ийм дорд, эгэл жирийн хүн байх ёстой гэж?

Манай дэлхийд заларч билиг оюун, мөнхийн адислалаа хайрласан олон Багшаас бид асар их ариун ном сургаалыг уламжлан авсан билээ.

Юу хийснээ харж, мэдэрч, ойлгосноор өөрийн ухамсарт тусалж, мөн бусад үй олон хүнд тусыг бүтээгч уужуу, агуу их сүнс байхын оронд яагаад бид ердөө жирийн нэгэн, амьтай төрөлтөн төдий байх ёстой гэж. Бид энэ агаараар амьсгалж л байсан цагт бусдын тусыг бүтээх бүх арга замуудыг сурч байгаа. Энэ бол бидний өөрсдөдөө тус болох арга зам юм. Энэ бол сүнсээ ариусган дэвшүүлж, өсч хөгжиж Гэгээнтэн болох зам юм.⁵⁰

⁵⁰ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Шихү, Формоса, 1992 оны дөрөвдүгээр сарын 10, (Англи хэлээр)



**ЯАГААД БИД НИЙТИЙН БЯСАЛГАЛААС
ЕР БУСЫН ИХ АШИГ ТУСЫГ ХҮРТДЭГ
ВЭ?**

Хэр олон хүн байгаагаас шалтгаалан, нийтийн бясалгалаар хураах буян нь гэртээ ганцаараа хэдэн өдөр, сараар, бүр жилээр сууснаас ч хавьгүй олон дахин илүү байдаг. Тиймээс, хэдий чинээ олон бясалгагч, хэдий хэр удаан нийтээрээ бясалгана, бидний оюун санаанд төдий чинээ их өөрчлөлт гардаг. Олон хүнийг би зөвхөн гаднаас нь хараад нийтийн бясалгалд явдаг эсэхийг нь хэлж чадна. Авшигтнууд ч бас мэддэг. Тэд илт өөр байдаг. Нийтийн бясалгалд байнга оролцдог бясалгагч



хэрэв хэсэг хугацаанд орохгүй байгаад, дараа нь дахин орвол нэг л өөр, тийм ч цэвэр биш байгаагаа мэдэх болно. Нийтийн бясалгалд олноороо оролцох тусам бид улс орондоо илүү их адислалыг буулгаж чаддаг. “Бид ердөө хэдүүлхнээ бясалгахад яаж манай улс үндэстэн тэр аяараа адислагдаж чадах юм бэ?” гэж гайхах хэрэггүй. Энэ үнэн шүү. Нэг айлд хэдэн хүн хамт амьдардаг байлаа гэхэд, тэдний ганц нь л баян байхад хангалттай, бусдадаа тус нэмэр болж байдаг. Яг л үүнтэй адил юм. Тэрээр байрныхаа дусаалга гоожих бүх хэсгийг засч гэр бүлийнхэндээ бүгдэд нь тус болно. Тэр байшинд арав хорин хүн амьдардаг байсан ч асуудал байхгүй. Түүнд өөрт нь ч тустай, мөн хамт амьдран суугаа хэн бүхний сэтгэл амар. Нэг гэр бүлийн хувьд ийм байдаг. Үүнтэй адилаар, зөвхөн бид хэдий оюун санааны бясалгалын ач тусыг бусад хүмүүс ч хүртэх нь гарцаагүй ээ.

Замын хажуугийн ганц гэрэл гэхэд л ямар байдаг билээ! Маш олон хүнд, хажуугаар нь өнгөрч буй мянга мянган хүнд ашиг тустай. Чийдэнд бол алдах юм байхгүй, харин ч олон хүн хэрэглэх тусам улам хэрэгтэй байдаг. Үүний нэгэн адил манай дэлхийн хүмүүсийн олонхи нь оюун санааны бясалгал үйлддэггүй байж болох ч бид бясалгаж байвал болчихно. Түүнээс биш ганц ч хүн бясалгадаггүй байсан бол улам л дор байх байсан. Яг л тосгон тэр аяараа гэрэлгүй байвал түнэр харанхуй бүрхэхтэй адил. Ганц хоёр гэрэл байвал, огт гэрэлгүйгээс л дээр! Хэдийгээр төв зам харанхуй байсан ч хэдэн гэрэл байхад л бид замаа харж чадна. Тиймээс бясалгалаа хичээнгүйлэн хийцгээж өөрсдөдөө болон хүн бүрт ач тустай бай. Та нарыг ийм л байвал би баярладаг.⁵¹

⁵¹ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Япон, 1992 оны гуравдугаар сарын 12, (Хятад хэлээр)



Нийтийн бясалгалын үед асар их адис хүч буудаг. Бидний оюун санааны дэс хэдийгээр асар доогуур байлаа ч нийтийн бясалгалд хэсэг хугацаанд оролцсоны дараа хавьгүй их өсч дэвшинэ. Нөгөөтэйгүүр, бидний дэс өндөр байлаа ч, нийтийн бясалгалд явахгүй бол маш ихээр доошлох болно. Учир нь бид энэ дэлхийд бусдаас хамаарч, бусадтай холбоотой байдаг, хэн ч ганцаараа амжилтанд хүрдэггүй. Оюун санааны бясалгалын хувьд ч энэ бас адилхан. Ганцаараа бясалгаад оюун санааны хөгжилдөө амжилт олно гэж бодох нь буруу. Ийм бодол нь бидний мунхаг байдал, доогуур дэсийг илтгэж байгаа юм.

Хэрхэн илүү сайн төвлөрч бясалгах вэ?

Багш аа, би бясалгахдаа сэтгэлээ төвлөрүүлж чадахгүй юм. Сэтгэл санаа хаа сайгүй хэсэн тэнүүчилж, есөн жорын сэдвээр юм ярих юм. Яаж би илүү сайн төвлөрч, бясалгах вэ?

Б: Энэ авшигтан уу? (Хөтлөгч: Та авшигтай юу) Учир нь би өөрөөр хариулна. Үүнийг хэн асуусан бэ? (Хэн нэгэн нь “авшигтай” гэж хариулав). Ийм л байдаг учраас бид нийтийн бясалгалд явах хэрэгтэй байдаг юм. Яагаад гэвэл төвлөрсөн хүч бидэнд тусалдаг бөгөөд хүн бүхэнд төвлөрөх хугацаа шаардагддаг. Зарим хүмүүс шууд тэр дороо төвлөрдөг бол, зарим хүмүүс хугацаа авдаг. Энэ тухайд би түрүүн дурдсан. Өөрийгөө бас уучлах хэрэгтэй. Энэ дэлхийн нөхцөл байдал нь нам тайван бясалгаж, амар амгалан бодол агуулахад тохиромжгүй байдаг, гэхдээ дахин дахин оролдох хэрэгтэй. Харин энэ дэлхийн нэг давуу тал нь



оюун санааг дадуулахад маш хүнд газар учраас Эзэн Бурханы адис бидэнд хэд дахин хүчтэй буудаг явдал юм. Тэгэхээр бид урагш ганц л алхам хийхэд Багшийн хүч бидэнд туслах гэж зуун алхам хийнэ.

Диваажинд байж бясалгавал үр дүн тийм ч их биш. Тиймээс диваажинд бясалгахад маш их хугацаа авдаг юм. Жишээ нь, бид энд нэг өдөр бясалгах нь диваажинд зуун өдөр бясалгасантай тэнцэнэ. Тийм учир, сахиулсан тэнгэрүүд, диваажингийн төрөлтнүүд хурдан дэвшихийн тулд хүний биенд төрөх дуртай байдаг юм. Учир нь энд үйлийн үр, элдэв нөхцөл байдал, гай гамшиг, дайн дажин, зовлон жаргал холилдсон саад бэрхшээл байдаг. Энэ нь бидэнд болон дэлхий ертөнцөд ач тустай, хүчтэй арга хэрэгсэл юм.

Бид энд бясалгаж байхдаа бусад амьтдад тус болох боломж байдаг бөгөөд ингэснээрээ бас илүү буян хураадаг. Жишээ нь, хэрвээ та гэртээ ганцаараа бясалгавал ганц хүний л буян хураана. Харин өөрийн хүчин чармайлт буюу ярих үр

чадвараа уриалж, эсвэл байраар хангаж, зуун хүнийг бясалгуулбал өөрийнхөө буян дээр зуун хүний буяныг нэмж хураана. Тэгэхээр зуу дахин илүү хурдан дээшилж байна гэсэн үг. Миний юу хэлж байгааг ойлгож байна уу? Мөн авшиг авахуулахаар зуун хүнийг ирүүлбэл тэр буян нь та нарт ч бас ирнэ. Яагаад гэвэл эцсийн дүндээ бид бүгдээрээ нэгэн цогц юм, иймд бид хэчнээн олон хүнтэй хэдий чинээ их холбогдоно тэр хэмжээгээрээ тэлж, буян маань ч асар их арвиждаг. Тооны хэлээр ярихад ийм байна.

Тэгэхээр энд байх нь диваажинд байхаас илүү дээр. Диваажинд бүгдээрээ л сайхан амьдардаг учир тайвширчихдаг. Тэндхийн төрөлтнүүдийг бясалгал төвлөрөлд хандуулах сэдэл шалтгаан байхгүй. Тиймээс ч би та нарт, гүн гутрал зовлонд унахаараа хүн илүү сайн залбирдаг, заримдаа бүр илүү сайн бясалгадаг гэж хэлдэг. Тийм үедээ та нар Их Багшийгаа илүүтэй санан дурсаж “Ээ, Багш минь, гуйя, гуйя, гуйя,” гэгцгээдэг. (Шавь нар инээлдэв.) Тэгээд тэр өдрөө та нар илүү сайн ахуй




ойлголт, илүү тод Гэрэл үзэж, илүү хүчтэй Аялгуу сонсох буюу сэтгэл санаа чинь өөдрөг болж, Эзэн Бурхантай ойр буйгаа мэдэрдэг. Тэгэхээр хэдийгээр хэцүү хэдий ч энэ дэлхий дээр байхдаа бясалгасан нь хавьгүй дээр юм.

Манай олон авшигтнууд маш их хичээнгүйлэн бясалгадагт би баярладаг. Зарим нэг нь төв дээр зүгээр хүн харах гэж ирдэг. Гэхдээ хэсэгхэн байж байгаад... тийм ч удаан сэлгүүцэж амжаагүй байж байтал нь бүгдээрээ нүдээ аниад суучихдаг. Тэгэхээр хэсэг хугацааны дараа тэд ичсэндээ бас нүдээ анихаас өөр аргагүй болдог юм. Тэгээд тэд гадагшаа хөөрхөн охид харахын оронд дотооддоо ямар нэгэн зүйлийг хардаг. Иймд хүмүүс цуглан нэгэн ижил зүйлийг хийж, хамтдаа төвлөрөн, нэгэн үзүүрт сэтгэлээр Эзэн Бурханыг дурсах сүм буюу бясалгалын төвтэй байх нь асар их давуу талтай, үүний ач тус маш их. Гэхдээ яарах юу байх вэ. Та нар ийш тийшээ харж л бай, залхахаараа харин нүдээ аниад бусад хүмүүстэй хамт бясалгаж болно. За?

Сэтгэлээ хянах хэзээ ямагт хэцүү байдаг. Тийм учир бид өдөр бүр бясалгаж байх хэрэгтэй. Тиймгүйсэн бол бид та нарт “Авшиг л авчих, тэгмэгц л чи Будда болчихно” гэж хэлэх байсан. Өөр хийх юмгүй байхсан биш үү? Гэтэл бидний дадал зуршил нэн эртнийх, хэдэн мянган жил, магадгүй бүр түүнээс ч илүү хугацааны туршид бидэнтэй хамт байсан. Тэгэхээр ганц энэ төрөлдөө бүгдийг нь арилгана гэдэг нүсэр их ажил, гэхдээ ингэсний хэрэг заавал гарна. Эсвэл та нар эндээ үлдээд энэ бүгдтэйгээ дахиад мянган жил зууралдмаар байгаа юм уу? Тэгвэл ч зугаатай юм болно шүү! Тийм учраас л би та нарыг ахиухан бясалгах хэрэгтэй гэж хэлж байгаа юм. Хоёр цаг хагас эсвэл гурван цаг. Эхний хорин минутанд бол та нар зүгээр л төвлөрөх гэж хичээж зүтгэж байдаг, харин хорин минутын дараагаас та нар төвхнөж эхэлдэг. Гучин минут болоход та нар бясалгалдаа таашаал амсаж эхлээд, дөчин минут болоход тасарна. (Шавь нар инээлдэв.)⁵²

⁵² Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Фремонг Хинди Сүм, КА., АНУ, 1993 оны арваннэгдүгээр сарын 25 (Англи хэлээр)





ХИЧЭЭХ ХЭРЭГГҮЙ ГЭДГИЙГ ОЙЛГОХ ХҮРТЛЭЭ БИД ХИЧЭЭНЭ

А: Бүх зүйл хэдийнээ зурагдчихсан байдаг гэж таны хэлснээс үүдээд миний толгойд нэг асуулт орж ирлээ. Хэрвээ бүх зүйл ийнхүү төлөвлөгдчихсөн байдаг бөгөөд бидний хүчин чармайлт ямар ч утга учиргүй юм бол гэтэлж гэгээрэх гэж чармайхын хэрэг бидэнд байна уу?

Б: Чармайх шаардлага байхгүй юм байна гэдгийг ойлгох хүртлээ та нар чармайх хэрэгтэй.

А: Цөхрөөд болих хүртлээ чармайх хэрэгтэй гэсэн үг үү?



Б: Үгүй ээ, бүх л хүчин чармайлт чинь ямар ч хэрэггүй гэдгийг бүрэн дүүрэн ойлгох хүртлээ зүтгэх хэрэгтэй. Ямар ч чармайлт гаргах хэрэггүй болох хожмын тэр үеийг хүртэл чармайлх хэрэгтэй. Одоо бол би та нарт юу ч гэж хэлсэн байсан та нар хичээсээр л байх болно. Тийм ч учраас би та нарт яаж хичээхийг чинь хэлж өгдөг. Би та нарыг “Хичээгээд бай, сайн хичээ, ‘Яагаад би чармайлх ёстой юм бэ? Би хэдийнээ энд байна шүү дээ, би хэдийнээ ирчихсэн юм байна’ гэж ухаарах хүртлээ чармайн оролд” гэж хэлдэг.

Би та нарт одоо хэлбэл та нар ойлгохгүй. Тэгэхээр та нар хичээх хэрэггүй юм байна гэдгээ ойлгохын тулд хичээх хэрэгтэй юм. Яагаад гэвэл, хэрэв би та нарт одоо “Битгий хичээ” гэвэл та нар больж чадах уу? Та нар зүгээр тайвширч, хамгаа даатган хаяж чадах уу?

■ Би нэг хэсэг тэгж үзсэн л дээ. Тэгтэл нэг л хаягдаж хоцрогдоод байгаа мэт санагдсан тул,

дахин хичээж эхэлсэн.

Б: Тийм, үүнийг чинь л хэлээд байгаа юм. Та тэгэхээр болоогүй л байна. Иймд та илүү их чармайлт гаргахыг хичээ, тэгээд нэг л өдөр чармайхаа болино. Энэ гол зорилго юм. Учир нь одоо бид хичээхгүй бол амгалан тайван байж чадахгүй. Харин та чармайлтаа зогсоосон ч сэтгэл амгалан байж чадаж байвал, энэ чинь болж байна гэсэн үг. Одоохондоо та нар хичээхгүй юм бол хэцүүдэх болно.

А: Бүрэн ойлгож ухаарахгүйгээр хүчин чармайлтаа зогсоовол мөн л үр дүнгүй гэсэн үг үү? Та тэгж хэлээд байна уу?

Б: Тийм, үр нөлөөгүй.

А: Тэгэхээр үүнийг ойлгох түвшинд л жинхэнээсээ хүрэх хэрэгтэй байх нь ээ?



Б: Тийм. Тархины түвшинд ойлгох биш, харин жинхэнээсээ амгалан, жинхэнээсээ гэтэлсэн гэдгээ онох. Учир нь одоо оюун ухаанаараа та миний юу ярьж байгааг ойлгож байгаа, гэхдээ онож мэднэ гэдэг бол өөр хэрэг.⁵³

⁵³ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, олон улсын долоо хоногийн дияан бясалгалын үеэр, Сангимен, Пингун, Формоса, 1992 оны арванхоёрдугаар сарын 22, (Англи хэлээр)

Эзэн Бурханы нигүүлсэл бялхсан

ЭЗЭН БУРХАН

А: Хайрт багш минь, бид бүгдээрээ гэртээ буцан харьж, дэлхий ертөнцийн ажил, асуудалтай зууралдахаа болих өдөр ирнэ гэж Та боддог уу?

Б: Өө, бид гэртээ гарцаагүй харих болно.

■ Бид бүгдээрээ юу?

Б: Бид бүгдээрээ харина. Хэн ч хоцорч үлдэхгүй. Та дахин төрөл авч тодрохгүй (Багш болон бүх шавь нар инээлдэв.) Сайхан хүүхэн ардаа үлдээчихээд ч юм уу, буцаж ирэх гэж жигтэйхэн их хүсээд байдаггүй л юм бол тэр шүү дээ. Яагаад гэвэл дэлхийн хувьд энэ их цөвүүн муу цаг бөгөөд Их Багшийн хүч биднийг хангалттай зовсон гэж үзэж байгаа юм. Тиймээс,



хэрвээ бид жаахан чин сэтгэлээр өчүүхэн л чармайлт гаргах юм бол Их Багш биднийг авралдаа багтааж, бусад юмыг тооцохгүй. Учир нь (Багш санаа алдаж байна) үнэнийг хэлэхэд, та нар энэ дэлхий дээр бясалгаж чадахгүй. Та нар үнэхээр чадахгүй. Бид бясалгахын төлөө юу л хийх боломжтой байна, эсвэл бясалгалаас ямар л үр дүн гарна, бүгд л үнэндээ, миний энэ бие хүний ч биш, харин Их Багшийн хүчний аврал юм. Ямар ч гэсэн Иймд Их Багш биднийг унтаж байхад илүү аюулгүй сайхан янз бүрийн түвшин үрүү аваачдаг. Өдрийн цагаар бид дэндүү завгүй. Бодол сэтгэл маань оюун санааны агуу их хүчний эсрэг ажиллаж байдаг учир энэ үед л амжиж дэвших хэрэгтэй. Хэрвээ та нар сахилаа сахиж, бясалгаж, нийтийн бясалгалдаа явж байвал, өөрсдийгөө санаанд багтамгүйгээр хурдан дэвшихийг харна. Тэгээд өөрийгөө эргээд бодоход, огт өөр хэн нэгэн хүнийг харж байгаа мэт санагдана. Нээрэн шүү! Үүний мэдэх хүмүүс та нарт хэлнэ. Би та

нарт үүнийг номоос мэдчихээд хэлж байгаа юм биш, харин өөрийн туршлага болон номын ах эгч нарын чинь амьдралын тод жишээнээс хараад хэлж байгаа юм. Гэр бүлийнхээ гишүүд болох хамтран бясалгагчдаа долоо хоногтоо нэг харна гэдэг чинь сайхан биш үү? Ингэх нь сайн шүү. Олон хүн ингэж чадахгүй хэдий ч, уг нь ингэх нь тэдэнд тустай. Хэрвээ та нар нийтийн бясалгалдаа явж чадахгүй бол, эсвэл ямар нэгэн шалтгаанаар явахыг хүсэхгүй байвал, гэртээ заавал бясалгаарай. “Албатай” юм гэж байдаггүй, зүгээр л өөрсдийн чинь тусын тулд юм. Миний хэлсэн бүхэн зөвхөн та нарт л хэрэгтэй. Хориотой зүйл гэж байхгүй! Дагаж мөрдвөл өөрт чинь л сайн. Харин дагахгүй бол та нарт зарим нэг саад бэрхшээл тохиолдоно, тэр цагт та нар яагаад гэдгийг нь ойлгох болно.⁵⁴

⁵⁴ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Хавай, АНУ, 1994 оны есдүгээр сарын 4, (Англи хэлээр)



Бясалгах боломжийг нандигна

А: Таны лекцийн эмхтгэлүүдийн нэгэнд Та Кабирын “Далай их хайр” гэдэг шүлгийг дурдсан байдаг, тийм ээ?

Б: Би Кабирын шүлэгнүүдийн тухай олон удаа ярьсан. “Далай их хайр”-ын тухай юу гэж?

А: Энэ бол Сат Пуруш гэж дууддаг Оройн дээд Эзэн Бурханы тухай юм. Тэрээр эрин үе (Юга) болгонд өөр өөр дүрээр бууж ирдэг Тэгээд Кали Югагийн эринд Сат Пуруш олон олон сүнсийг гэрт нь буцааж хариулахаар Калтай (Гурван ертөнцийн эзэн) хэлэлцээр хийсэн байдаг.

Б: Тийм, энэ цаг Кали Юга, Харанхуй эрин. Ийм үед агуу хүчтэй нэгэн бууж ирэн

бүгдийг дээш нь татах хэрэгтэй байгаа юм. Том машинтай! Хүчтэй! (Багш инээж байна.)

А: Тийм учир олон сүнс ийм хялбархан чөлөөлөгдөж байгаа хэрэг үү?

Б: Тийм, яг зөв. Та үүнийг мэддэг юм байна. Мэдээж, тийм. Энэ бол мөчлөгийн сүүлчийн эрин. Тэгэхээр ард хоцорсон хүмүүс бушуулаарай! Бурхан бүгдийг нь дээш нь татаж байна. Тиймээс ч маш их нигүүлсэнгүй байна. Гэхдээ энэ маш их хүч шаарддаг. Яг л далайн догшин салхи асар их ус авчирдагтай адил. Далайн догшин салхи л асар их усыг эх газар дээр авчрахаас биш ердийн бороо бол чадахгүй.

Энэ цаг үед хүн бүрт хүрэлцэхүйц их зай, их өршөөл аврал байгаа учраас “бөөндөж” байгаа гэсэн үг. Ямар ч асуудал байхгүй. Та нар азтай байна шүү. (Бүгд алга ташиж байна.) Эзэн Бурхан бол агуу нигүүлсэнгүй, гэхдээ Тэрбээр



хэзээ ч одоогийнх шигээ ийм их авралыг үзүүлж байгаагүй. Эрт дээр үед сайндаа л хэдхэн хүн, магадгүй мянгаад хүн гэтэлсэн байх. Тухайн үед яагаад ч ийм олон хүн гэтлэх аргагүй байсан бөгөөд нэгэн доор юуг ч үл харгалзан ийм олноороо цугларах боломжгүй байсан. Та нар мөн ч их азтай улс шүү.

Эрт дээр үеэс хүмүүс хамтдаа бясалгахыг хүсвэл, хаа сайгүй зугтан нуугдаж, нууц үг, дохио зангаа ашиглаж, чагж зэрэг нууц гар дохио, эсвэл та нарын хэрэглэдэг мэндчилгээг ашигладаг байсан. Тэр байтугай үүнийг хар, (Багш дохио зангаа хийж байна) билгийн нүдээ санаад, Ариун Нэрсээ уншаад, Гуань Инийг хийгээрэй, тэгвэл бид хамт байна. Энэ бол Христын шашинтнуудын номын ахан дүүсээ танихын тулд хэрэглэдэг байсан нууц дохио юм. Яагаад гэвэл тэр үед Есүс нуугдах шаардлагатай байсан. Шавь нар нь ч мөн адил бүгд нуугдмал байж. Тэд “Би түүний хэн болохыг мэдэхгүй” гэж

хэлээд олны өмнө Багшийгаа ч хүлээн зөвшөөрч зүрхэлдэггүй байсан. Тэр ч байтугай хамгийн тэргүүн шавь болох Питер ч хүртэл Түүнийг мэдэхээ гурвантаа үгүйсгэсэн. Тийм агуу хүн Есүс ч, Түүнд өөрийгөө бүрэн зориулсан шавь Питер ч хүртэл ам нээж чадахааргүй, сөрөг хүч тэгж дарангуйлж байсан юм. Тэр үед хавчилт шахалт маш их байлаа. Харин орчин цагийн бид тун азтай хүмүүс юм.⁵⁵

⁵⁵ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Флорида дахь Төв, АНУ, 2001 оны зургадугаар сарын 9, (Англи хэлээр)




Бид бол хамгийн азтай бясаллагчид

А: Би танаас нэг зүйл асуух гэсэн юм. Үхсэнийхээ дараа энд буцаж ирэхгүйн тулд оюун санааны хувьд бид энэ насандаа хэр өндөр түвшинд хүрэх ёстой вэ?

Б: Чадлаараа дээш зүтгэ. Эс бөгөөс Багш өөрийг тань өөд нь түлхэх болно. Багш өөрийг тань аль хүрэх түвшинд тань хүргэж дэмжих бөгөөд дээшээ нь үргэлжлүүлэн замчилсаар байх болно. Түүнээс биш уг нь та нар гурван ертөнцийг давж өнгөрөх ёстой байдаг. Өөр аль нэг Багштай байсан бол та нар эргэж ирэхгүйн тулд Гуравдугаар Ертөнцийг давах ёстой байсан. Харин энэхүү Цаглашгүй Дээд номын цогцоор та нар асуудалгүй давж чадна.

Яагаад гэвэл өндөр түвшинд хүрч чадаагүй нь заавал ч та нарын буруу биш байдаг юм. Жишээлэхэд, өнөөдөр авшиг аваад маргааш нь үхлээ гэж бодъё. Тэгэхээр та энэ бие махбодоо орхихынхоо өмнө, эсвэл Багш тань биеэ орхихоос өмнө та хаана байсан тэр түвшнээс эхлэн таныг дээш авч явах нь Багшийн үүрэг юм.

 Яагаад энэ зуун маань мянган жилийн өмнөхтэй адилгүй ийм онцгой байгаа юм бэ?

Б: Учир нь Бурханы Орон үе үе “хямдралтай бөөний худалдаа” зарладаг юм. (Багш болон бүх шавь нар инээлдэв.) Яг л гараашиндаа юмаа хямдруулж зардаг шиг. Бүх бараа нэг доллар. Гэхдээ энэ нь ямар Багш бууж ирснээс шалтгаална. Та нар харж байгаа, бид бүгдээрээ л Багш. Гэхдээ зарим багш өөрийгөө дөнгөж санаад, өөрөөр хэлбэл энэ төрөлдөө л анх гэгээрдэг. Зарим Багш бол үргэлж л гэгээнтэн байсан. Зарим Багш хэзээ ч Бурханы Орныг



орхилгүй байж байгаад дөнгөж энэ төрөлдөө бууж ирдэг. Харин зарим нэг нь байнга ирээд л яваад л. Ингэсээр байгаад энэ дэлхийн олон төрөлтнүүдтэй барилдлагатай болсон байдаг. Тэгээд Тэрээр дахин бууж ирэхдээ бүх хуучин найзуудаа “Та нар юу ч хүссэн хамаагүй, болгооно. Бид бие биенээ таньдаг байсан юм чинь.” (Шавь нар алга ташив.) Магадгүй бид хуучин найзууд байсан байх.

Дөнгөж шинээр бууж ирсэн Багшид тийм ч олон төрөлтнүүдтэй барилдлага байдаггүй. Тиймээс эхлээд хэдэн шавьтай болж байгаад, дараа дараагийн амьдралдаа үргэлжлүүлэн номоо айлддаг. Хэрвээ тухайн Багш өөрийнхөө Бурхан гэдгийг дөнгөж энэ төрөлдөө санасан бол мэдээж илүү туршлага хуримтлуулах ёстой. Их Багш юм мэдэхгүйдээ биш, зүгээр л юу ч хийсэн адилхан дадлагажих хэрэгтэй байдаг. Хүмүүний сэтгэлтэй хэрхэн ажиллах, энэ ертөнцийн хүнд сурталтай

хэрхэн учраа ололцох, элдэв хавчилт дарамтаас өөрийгөө хэрхэн хамгаалж, элдэв түвэгт орооцолдуулахгүй байж, бусдад чимээгүйхэн туслахын тулд биеэ яаж авч явах тал дээр туршлагажна.

Гэтэл шинэхэн Багш үүнийг мэддэггүй. Шинэхэн Багш өнгө цацруулж, бишгүүр хангинуулж, хэнгэрэг дэлдэн гарч ирснээ, магадгүй гурван жил хагас, эсвэл хоёр жил хагас, эсвэл бүр гурван сар хагасханы дараа сураг нь тасарч мэднэ. Оюун санааны хүч цөм адил, орчлонгоос ирдэг. Харин шавь нарыг хэрхэн залж удирдах болон дэлхий ертөнцийн улс төртэй учраа олох нь тархины түвшний ажил тул үүнд суралцах ёстой байдаг. Эдгээр нь юмыг хийх ур, чадварын хэрэг бөгөөд гэгээрэл болоод сүнстэй ямар ч хамаагүй. Гэхдээ, мэдээж хамаарал бий л дээ, жишээ нь хэдий их гэгээрсэн байна, юмыг төдий чинээ хурдан сурч чаддаг. Харин тухайн



Гэгээнтэн олон төрөл дамжсан туршлагатай бол энэ төрөлдөө тэгж их юм суралцах шаардлага байхгүй.

Учир нь хүн ганцхан төрөлдөө яаж тийм их зүйл сурч чадах вэ? Гэгээрсэн байсан ч гэсэн авто механик, онгоц ба усан завь жолоодох, нягтлан бодох, компьютерын программ хангамж, техник хангамж гээд тэр бүхнийг сурч барахгүй шүү дээ. Эдгээрийг сурч болох хэдий ч, амьдрал дэндүү богинодно. Эдгээр зүйлс бол сүнстэй хамаагүй, харин оюун ухаан, уураг тархи болон гар, биеэрээ хийж сурч байж эзэмших ур чадвар юм. Тэгэхээр Багш гэдэг “яаж Багш болох” биш, харин Багш “яаж” байдгийг хэдийнээ мэддэг байвал, өөрөөр хэлбэл, олон зүйлтэй тулж, олон зүйлсийг хийж чаддаг бол ийм Их Багш юмыг амархан бөгөөд хурдан хийнэ. Ийм байвал арай хялбар байдаг юм. Дэлхий дээр юмыг яаж хийдгийг мэднэ гэсэн үг юм.

Номлол адилхан, арга адилхан, хүч чадал адилхан, Үнэн ёс ч адилхан. Харин олон нийттэй харилцаж, шавь нартаа хамгийн шилдэг, хурдан дэвших аргыг заах чадвартай чадваргүй Багш гэж байдаг. Багш адилхан аргыг нэг хэсэг хүмүүст зааж өгч болно. Мөн хоёр өөр Багш нэг адил аргыг хоёр өөр шавьд зааж өгч болно. Гэтэл нэг Багшийн шавь нөгөө Багшийн сурсан шавиас арай өөрөөр, илүү хурдан дэвшиж болно. Ийм байдаг. Мөн сургаал номлолоо шавийн сэтгэлд хэрхэн суулгаснаас шалтгаална. Учир нь хэрвээ бодол сэтгэл чинь ойлгож, хүлээж авахгүй бол та нар хурдан дэвшиж чадахгүй гэсэн үг. Та нарт ийм сайхан санагдахгүй байх байсан. Мөн ийм их үнэмшил төрж, ийм их итгэлтэй байж чадахгүй байхсан. (Шавь нар алга ташив.)⁵⁵

⁵⁵ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, нийтийн бясалгалын үеэр, Флорида дахь Төв, АНУ, 2001 оны зургадугаар сарын 9, (Англи хэлээр)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Их Багш Чин Хайн лекцийн эхүүдтэй танилцаж
Түүний адис хүчийг бүр илүүтэй хүртээрэй

- 1 1991 оны 4-р сарын 9, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.90, "Анхаарлын төвд" (Хятад хэлээр)
- 2 1989 оны 2-р сарын 13-18, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.133, "Багшийн айлдвар"/ MP3-CR01 (Хятад хэлээр)
- 3 2002 оны 12-р сарын 28, Флорида, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.146, "Багшийн айлдвар" (Англи хэлээр)
- 4 1990 оны 9-р сарын 28-аас 10-р сарын 3, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.146 "Билиг ухааны эрдэнэс"/ MP3-CR09 (Хятад хэлээр)
- 5 1992 оны 10-р сарын 10, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.140 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.278 "Шургийн онол" (Хятад хэлээр)
- 6 1993 оны 4-р сарын 7, Сиатл, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.43 "Сонгогдмол асуулт хариулт"/ Видео хуурцаг No.348 "Их Багшийн хүчээр гэгээрдэг" (Англи хэлээр)
- 7 1986 оны 12-р сарын 17, Тайпэй, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.52 "Багшийн айлдвар" (Хятад хэлээр)

- 8 1996 оны 2-р сарын 20, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.71 "Багшийн ярьсан түүх"/ Видео хуурцаг No.528 "Бид хэдий чинээ Бурханд чин сэтгэлтэй байна, төдий чинээ шунал хүсэл багатай байна" (Англи хэлээр)
- 9 1991 оны 6-р сарын 2, Коста Рика, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.25 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.175 "Будда, Есүс Христ болон жинхэнэ гэгээрсэн Их Багш нарын үнэн түүхээс" (Англи хэлээр)
- 10 1989 оны 8-р сарын 13, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.95 "Билиг ухааны эрдэнэс" (Хятад хэлээр)
- 11 1990 оны 10-р сарын 10, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.33 "Анхаарлын төвд" (Ау Лак хэлээр)
- 12 1988 оны 10-р сарын 29, Шихү, Формоса, Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр, 5-р боть "Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд" (Хятад хувилбар)
- 13 1994 оны 9-р сарын 6, Хавай, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.43 "Та мэдэхгүй байж магад"/ DVD No.444 "Өөртөө найд" (Англи хэлээр)
- 14 1988 оны 12-р сарын 1, Пинтун, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.45 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.21 "Беннадитын түүх" (Хятад хэлээр)
- 15 1988 оны 8-р сарын 12-18, Илан, Формоса, Төгс Гэгээрсэн Их

- Багш Чин Хайн сэтгүүлээс No.130 "Багшийн айлдвар"/ MP3-CR02 (Хятад хэлээр)
- 16 1990 оны 10-р сарын 19, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.131 "Багшийн ярьсан түүх" (Хятад хэлээр)
- 17 1989 оны 7-р сарын 29-өөс 8-р сарын 6, Шихү, Формоса, MP3-CR06 / Видео хуурцаг No.91 "Шихү дэх зуны долоон өдрийн дияан бясалгал (4)" (Хятад хэлээр)
- 18 1996 оны 5-р сарын 14, Пном Пен, Камбож, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.63 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No. 547 "Махан хүнсний хор нөлөө" (Англи хэлээр)
- 19 1992 оны 12-р сарын 24, Сантимен, Пинтун, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.27 "Анхаарлын төвд"/ Видео хуурцаг No. 295 "Сэтгэлээ аргал" (Англи хэлээр)
- 20 1991 оны 5-р сарын 5-12, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.131 "Мэдээлэл"/ MP3-CR10 / Видео хуурцаг No.165 "Шихү дэх зуны долоон өдрийн дияан бясалгал (3)" (Хятад хэлээр)
- 21 1989 оны 7-р сарын 29-с 8-р сарын 6, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.61 "Багшийн айлдвар"/ MP3-CR06 / Видео хуурцаг No.92 "Шихү дэх зуны долоон өдрийн дияан бясалгал (5)" (Хятад хэлээр)
- 22 1989 оны 4-р сарын 29, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.143 "Багшийн айлдвар" (Хятад хэлээр)

- 23 1994 оны 9-р сарын 14, Банког, Тайланд, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.154 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.446 "Буруу үзэл хүн төрөлхтнийг гамшигт хөтлөх аюултай" (Англи хэлээр)
- 24 1986 оны 8-р сарын 22, Шинтен, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.88 "Багшийн айлдвар" (Хятад хэлээр)
- 25 1989 оны 5-р сарын 21, Тайнан, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.92 "Оюун санааны мэдээллийн булан" (Хятад хэлээр)
- 26 1997 оны 7-р сарын 5, Лос Анжелес, КА., АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.84 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.587 "Гадаад орчны бохир муугаас өөрийгөө цэвэрлэх арга" (Англи хэлээр)
- 27 1997 оны 7-р сарын 6, Лос Анжелес, КА., АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.85 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.587 "Гадаад орчны бохир муугаас өөрийгөө цэвэрлэх арга" (Англи хэлээр)
- 28 1998 оны 12-р сарын 16-18, Лос Анжелес, КА., АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.132 "Сонгомол асуулт хариулт"/ Видео хуурцаг No.639b "Сүнс болгон өөрийн гэсэн зам мөртэй" (Англи хэлээр)
- 29 1995 оны 1-р сарын 10, Сингапур, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.45 "Багшийн айлдвар"/ DVD No.467 "Ертөнцийн зовлон мунхагас үүдэлтэй" (Англи хэлээр)

- 30 1987 оны 9-р сарын 6, Шинтен, Формоса, Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр, 4-р боть "Уламбанагийн уг гарал" (Хятад хувилбар)
- 31 1989 оны 2-р сарын 13-18, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.141 "Багшийн айлдвар"/ MP3-CR04 (Хятад хэлээр)
- 32 1992 оны 4-р сарын 12, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.63 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.241 "Орчлонтой холбогдох хамгийн дээд хүч: Ижил арга боловч Багшийн хүч өөр" (Хятад хэлээр)
- 33 2000 оны 4-р сарын 27, Оүкланд, Шинэ Зеланд, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.139 "Сонгомол асуулт хариулт"/ Видео хуурцаг No.686 "Сүнснүүд эргэн уулзахуй " (Англи хэлээр)
- 34 1998 оны 5-р сарын 9, Ён Донг Төв, Солонгос, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.93 "Багшийн айлдвар"/ DVD No. 620 "Жинхэнэ Багшийн хүч" (Англи хэлээр)
- 35 1989 оны 2-р сарын 13-18, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.131 "Ашигтай зөвлөгөө"/ MP3-CR04 (Хятад хэлээр)
- 36 1997 оны 12-р сарын 26, Вашингтон ДС, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.101 "Багшийн айлдвар"/ DVD No. 608 "Оюун санааг дэвшүүлэх арга замууд" (Англи хэлээр)

- 37 1995 оны 10-р сарын 31, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.66 "Сонгомол асуулт хариулт"/ Видео хуурцаг No.508 "Хятадын агуу их оточ нар" (Англи хэлээр)
- 38 1989 оны 1-р сарын 12, Тайнан, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.97 "Оюун санааны мэдээллийн булан" (Хятад хэлээр)
- 39 1999 оны 6-р сарын 11, Норфолк, Англи, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.122 "Оюун санааны мэдээллийн булан"/ Видео хуурцаг No. 649b "Европт Хайрыг авчирлаа" (Англи хэлээр)
- 40 1989 оны 10-р сарын 13, Берклэйн Их Сургууль, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.56 "Сонгомол асуулт хариулт"/ Видео хуурцаг No.101 "Эзэн Бурхан биетэй юу биегүй юу" (Англи хэлээр)
- 41 1998 оны 3-р сарын 10, Лондон, Англи, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.122 "Оюун санааны мэдээллийн булан"/ Видео хуурцаг No.631 "Эзэн Бурханы бүтээлийн зорилго" (Англи хэлээр)
- 42 2000 оны 5-р сарын 2, Хонг Конг, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.154 "Сонгомол асуулт хариулт"/ Видео хуурцаг No.690 "Мөн чанараа таних нь жинхэнэ аз жаргал мөн" (Хятад хэлээр)
- 43 1992 оны 7-р сарын 5, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.22 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.265 "Агуу Гэрэлт Эзэн Хаан; нүд, чих, хамар,

хэлгүй хүний үлгэр" (Хятад хэлээр)

44 1996 оны 3-р сарын 28, Пном Пен, Камбож, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.64 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.541 "Эхийн сэтгэл мэт Их Багшийн хайр " (Хятад хэлээр)

45 1993 оны 11-р сарын 12, Техас, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.74 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.392 "Багш гэдэг өөрийгөө огоорч бусдыг хайрлахыг хэлнэ" (Англи хэлээр)

46 1992 оны 4-р сарын 25, Шиху, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.132 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.243 "Дотоод хүч чадлаа нээхийн тулд оюуны хүчийг ашиглах нь; нас барж буй төрөл төрөгсдөө хэрхэн Бурханы Оронд хүргэж туслах вэ" (Хятад хэлээр)

47 1996 оны 3-р сарын 13, Лос Анжелес, СА., АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.155 "Багшийн айлдвар"/Видео хуурцаг No.536 "Төөрөгдлийн мананг зөвхөн билиг ухаан арилгаж чадна" (Англи хэлээр)

48 1991 оны 2-р сарын 2, Коста Рика, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.93 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.149 "Олны тусыг бүтээх нь үйлийн үрийг арилгах хамгийн хурдан арга мөн; сэтгэлийн хүлээсгүй бол чөлөөлөгдөнө" (Англи хэлээр)

49 1991 оны 2-р сарын 2, Коста Рика, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.95 "Анхаарлын төвд"/ Видео хуурцаг

- No.149”Олны тусыг бүтээх нь үйлийн үрийг арилгах хамгийн хурдан арга мөн; сэтгэлийн хүлээсгүй бол чөлөөлөгдөнө” (Англи хэлээр)
- 50 1992 оны 4-р сарын 10, Шихү, Формоса, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.21 "Багшийн айлдвар"/ DVD No.240 "Дэлхий ертөнцийг шинэ эрин үед хөтлөхүй" (Англи хэлээр)
- 51 1992 оны 3-р сарын 12, Япон, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.40 "Оюун санааны мэдээллийн булан"/ Видео хуурцаг No. 228 "Японы ирээдүй" (Хятад хэлээр)
- 52 1993 оны 11-р сарын 25, Фремонтын Хинду сүм, СА., АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.34 "Багшийн айлдвар"/ Видео хуурцаг No.396 "Өөрийгөө уучил" (Англи хэлээр)
- 53 1992 оны 12-р сарын 22, Сантимен, Пингун, Формоса, No.292-р видео хуурцагас "Их Багш чамтай хамт байсаар ирсэн" (Англи хэлээр)
- 54 1994 оны 9-р сарын 4, Хавай, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.50 "Сонгомол асуулт хариулт"/ Видео хуурцаг No.443 "Багшдаа барих шилдэг бэлэг бол таны аз жаргал" (Англи хэлээр)
- 55 2001 оны 6-р сарын 9, Флорида дахь Төв, АНУ, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгүүлээс No.140 "Сонгомол асуулт хариулт"/ DVD No. 719 "Муу зуршлаа дийлэх нь" (Англи хэлээр)

Хэвлэл

Агшин зуур билиг нээгдэх түлхүүр

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекцийн эмхтгэл. Ау Лак (1-15), Хятад (1-10), Англи(1-5), Франц(1-2) Финлянд (1), Герман (1-2), Унгар (1), Индонез (1-5), Япон (1-4), Солонгос (1-11), Монгол (1, 6), Португал (1-2), Польш (1-2), Испани (1-3), Швед (1), Тай (1-6), Төвд (1).

Агшин зуур билиг нээгдэх түлхүүр - Асуулт ба хариулт

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн асуулт хариултын эмхтгэл. Ау Лак (1-4), Хятад (1-3), Англи (1-2), Солонгос (1-4), Индонез (1-3), Болгар, Чех, Франц Унгар, Япон, Польш, Португал, Орос хэл дээр.

7 хоногийн дияан бясалгал 1992 он / Тусгай хэвлэл

Ау Лак, Англи

1993 оны Дэлхий даяар ном тайлах аялал / Тусгай хэвлэл

Хятад, Англи (1-6)

Багш шавийн хоорондын захиа

Ау Лак (1-2), Хятад (1-3), Англи (1), Испани (1)

Их Багшийн ярьсан үлгэрүүд

Англи, Хятад, Испани, Ау Лак, Солонгос, Япон, Тай

Бурхан ба хүн төрөлхтний тухайд - Библийн үлгэрүүдийг ухаарахуй

Багшийн газар бүрт ном тайлахдаа айлдсан Библийн 13 үлгэрийн цоморлиг. Хятад, Ау Лак, Англи хэлээр.

Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд

Ау Лак, Хятад (1-2)

Бурхан бүхнийг зохицуулдаг - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ярьсан үлгэрийн, зурагтай ном

Япон, Франц, Ау Лак, Хятад, Англи, Солонгос хэл дээр.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрүүлэгч хошин наргианаас – Та толгойныхоо гэрлэн бүрхүүлд хавчигдчихаж!

Хятад болон Англи хэвлэл. (Ном + CD)

Бурхантай шууд холбогдох нь энх амгаланг тогтоох арга зам мөн

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1999 онд Европоор аялан тавьсан лекцийн түүвэр. Англи, Хятад, Ау Лак хэлээр.

Өнгөлөг сайхан амьдарцгаая

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном сургаалын эмхтгэл. Англи, Хятад, Ау Лак хэлээр.

Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд
Англи, Хятад, Ау Лак, Монгол хэл дээр.

Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ

Багшийн оюун санааны сургаал номлол болон ишлэлийн эмхтгэл.

Араб, Ау Лак, Хятад, Румынь, Англи, Индонез, Солонгос, Испани, Польш, Унгар, Итали, Болгар, Грек, Чех, Франц, Герман, Турк, Орос, Монгол хэлээр.

Алтан эринд амьдрахуй, цуврал

Эрүүл мэндийн биелэл - Амьдралын зөв жам ёсондоо эргэн орохуй.

Багшийн тавьсан лекцийн ишлэлийн эмхтгэл.

Онч мэргэн үгс (1)

Багшийн мөнхийн билиг ухааны эрдэнийн шигтгээ.
Англи/Хятад, Испани/Португал, Франц/Герман хоёр
хэлээр, мөн Англи/Солонгос хэл дээр.

Онч мэргэн үгс (2)

Багшийн мөнхийн билиг ухааны эрдэнийн шигтгээ.
Англи, Хятад хэл дээр.

Тэнгэрлэг зоог (1) - Олон улсын цагаан хоолны соёл.

Дэлхийн өнцөг булан бүрийн номын ах эгч нарын санал
болгож буй амттай хоолны жор.
Англи/Хятад, Ау Лак, Япон хэл дээр.

Тэнгэрлэг зоог (2) - Гэртээ хийх амттанууд

Англи, Хятад хэлний нэгтгэсэн эмхтгэл.

Дуу хөгжмөөр энх тайван эв нэгдэлд хүрэхүй

Англи/Хятад/Ау Лак хэл дээр нэгтгэсэн эмхтгэл.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлиг

Англи/Хятад/Ау Лак хэл дээрх нэгтгэсэн эмхтгэл.

S.M.Тэнгэрийн хувцас

Англи/Хятад хэл дээрх нэгтгэсэн эмхтгэл.

Ноход миний амьдралд (1.2)

500 хуудас бүхий хоёр боть энэхүү ном нь Багш ба Түүний хайрт амьтдын бодит амьдралын тухай юм. Хятад, Англи, Япон, Солонгос, Ау Лак, Герман, Спани, Польш хэл дээр.

Шувууд миний амьдралд

Энэхүү гайхалтай гоёмсог зурагтай номонд Багш амьтдын нууцлагдмал дотоод ертөнцийг бидэнд нээн харуулжээ. Араб, Хятад, Англи, Франц, Солонгос, Ау Лак, Герман, Индонез, Орос, Монгол хэл дээр.

Эрхэм ариун амьтад

Их Багш Өөрөө бичиж мөн гэрэл зургийг нь авсан энэхүү ном нь сэтгэл уярам яруу найраг, гайхам сонин зургуудаар дүүрэн.

Өдрийн тэмдэглэл хэлбэрээр бичигдсэн энэ өгүүллэгт Багш нуурын эрэгт амьдарч байхдаа үзэж судалсан зүйлстээ тулгуурлан, бидний анд нөхөд болох тэдгээр амьтдын төрөлхийн эрхэм ариун чанарыг бидэнд нээн үзүүлдэг. Урьд өмнө огт үзэж сонсоогүй гайхам ертөнцтэй энэ ном таныг танилцуулах болно.

Хятад, Англи, Франц, Солонгос, Ау Лак, Герман,
Монгол хэл дээр.

Тэнгэрлэг урлаг

Тэнгэрлэг урлаг хэмээх энэ ном нь Үнэн Ёс, буян мөр, Бурханы Орны үзэсгэлэнт сайхныг оюун санааны өнцгөөс харж бүтээсэн урлагийн бүтээлүүдийг тайлбарласан онцгой бүтээл юм. Уншигчид Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн уран бүтээлийн эрх чөлөөт ертөнцөд зочлохдоо найрагчийн гүн гүнзгий сэтгэл хөдлөл, зураачийн нарийн мэдрэхүй, загвар зохион бүтээгчийн өвөрмөц санаа, хөгжимчний уяхан сэтгэл тэр бүхнийг асар хүчтэйгээр мэдрэх болно. Хамгийн гол нь уншигчид оюун санааны агуу Их Багшийн билгүүн ухаан, энэрэл нигүүлсэлд адислагдах их завшаан олно.

Хятад, Англи хэл дээр.

Амьдрал болоод ухамсрын тухай бодрол
Др.Жанезын бичсэн ном. Хятад хэл дээр

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
шүлгийн түүвэр**

Чимээгүй нулимс

Англи/Хятад/Ау Лак (нэгтгэсэн эмхтгэл); Англи/
Франц/Герман (нэгтгэсэн эмхтгэл); Испани, Португал,
Филиппин, Солонгос хэл дээр.

Вуузуу шүлгүүд

Ау Лак, Хятад, Англи хэл дээр.

Эрвээхэйн мөрөөдөл

Ау Лак, Хятад, Англи хэл дээр.

Хайрга ба алт

Ау Лак, Хятад, Англи хэл дээр.

Эрин зууны хайр: Хятад, Англи, Франц,
Солонгос, Ау Лак, Герман, Спани, Монгол хэл дээр.

Мартагдсан дурсамж

Ау Лак, Хятад, Англи хэл дээр.

Урьд төрлийн ул мөрүүд

Ау Лак, Хятад, Англи хэл дээр.

Хайрын домгийн мөрөөр

1, 2, 3 (CD, аудио хуурцаг) Ау Лак хэл дээр.

Жинхэн хайр:

Хятад, Англи хэл дээр.

Хуучин цаг үе

Ау Лак, Хятад, Англи хэл дээр.

Цаг хугацааны чанадад (CD, DVD)

Ау Лак хэл дээр.

Анхилам сайхныг мэдрэх (CD)

Ау Лак хэл дээр.

Энэ өдөр, тэр өдөр (CD)

Ау Лак хэл дээр.

Шөнийн зүүд (CD)

Ау Лак хэл дээр.

Там аа гэж! (CD)

Ау Лак хэл дээр.

Үүрд хадгалаарай (CD)

Ау Лак хэл дээр.

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн зохиож дуулсан дуу
(CD, DVD)**

Ау Лак, Англи, Хятад хэл дээр.

Хайрын дуу (CD, DVD)

Ау Лак, Англи, Хятад хэл дээр.

Эрдэнийн хэлхээ (CD, DVD)

Их Багш Ау Лакийн алдартай шүлгүүдийг Ау Лак хэл дээр уншсан шүлэг, дуу.

Алтан бадамлянхуа (CD, DVD)

Ау Лакийн шүлэг дуу.

Аудио болон видео хуурцаг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекцийн DVD, MP4, MP3, дуу болон дүрс бичлэгийн хуурцгуудыг дараах хэлээр үзэж сонирхох боломжтой: Араб, Армени, Ау Лак, Болгар, Кантониз, Камбож, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Англи, Финь, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвеги, Мандарин, Польш, Португал, Перс, Орос, Румынь, Сингал, Словени, Испани, Швед, Тай, Турк болон Зулу хэл дээр үзэх боломжтой. Хүсвэл та бүхэнд эдгээрийн каталогийг илгээж болно. Бидэнтэй шууд харилцахыг урьж байна.

Та бүхэн манай каталоги болон Их Багшийн хамгийн сүүлд хэвлэгдсэн бүтээлүүдийн товч агуулга зэргийг <http://www.smchbooks.com> хаягаар орж татаж авна уу.

Захиалга өгөх хаяг: <http://www.theCelestialShop.com> буюу The Supreme Master Ching Hai International Association Publishing Co., Ltd., Taipei, Formosa, Утас: (886) 2-23759688 / Факс: (886) 2-23757689,

И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org

Postal Account: The Supreme Master Ching Hai International Association Publishing Co., Ltd.

Бидэнтэй хэрхэн холбогдох вэ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

P.O. Box 9, Hsihu Miaoli Hsien (36899), Formosa, R.O.C.

P.O.Box 730247, San Jose, CA 95173-0247, U.S.A.

Суприм Мастер Телевиз

Info@SupremeMasterTV.com

Утас: 1-626-444-4385 / Факс: 1-626-444-4386

<http://www.suprememastertv.com/>

Номын Баг:

divine@Godsdirectcontact.org

Факс: 1-240-352-5613 / 886-949-883778

(Их Багшийн номыг бусад хэл үрүү орчуулах ажилд та оролцож болно.)

Мэдээний групп

и-мэйл: lovenews@Godsdirectcontact.org

Асуулт хариултын баг:

lovewish@Godsdirectcontact.org

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын
Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани.**

Тайпэй, Формоса.

smchbooks@Godsdirectcontact.org

Утас: 886-2-23759688 /Факс: 2-23757689

<http://www.smchbooks.com>

S.M. Celestial Co., Ltd.

smcj@mail.sm-cj.com

Утас: 886-3-4601391 /Факс: 3-4602857

<http://www.sm-cj.com>

Онлайн Дэлгүүр

<http://www.thecelestialshop.com>

<http://www.edenrules.com/>

БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ

“Loving Hut” Олон Улсын Цагаан Хоолны Сүлжээ

info@lovinghut.com

Утас: (886) 3-468-3345 / Факс: (886) 3-468-5415

<http://www.lovinghut.com/tw/>

Loving Food- Эрүүл амьдралын хэв маягын төлөө

<http://www.lovingfood.com.tw>

Үлгэр дэвтрийг төлбөргүй татаж авах

Агшин зуур билиг нээгдэх түлхүүр (80 гаруй хэл дээр)

<http://sb.godsdirectcontact.net> (Формоса), (АНУ)

<http://www.direkter-kontakt-mit-gott.org/download/>

[index.htm](http://www.direkter-kontakt-mit-gott.org/download/index.htm) (Австрали)

Гуань Инь ВЕБ сайтууд

Бурхантай шууд холбогдох —Төгс Гэгээрсэн Их Багш

Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт дэх

хаяг: [http://www.Godsdirectcontact.org.tw/eng/links/links.](http://www.Godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm)

[htm](http://www.Godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm)

Оюун санааны дадал бясалгалын НУУЦ хялбар аргууд

Монгол дахь анхны хэвлэл: 2016 оны 11 сар

Зохиогч:

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Эрхлэн гаргасан:

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн

Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани
Хаяг: No.236 Sungshan Road, Taipei, Formosa, R.O.C.
www.smchbooks.com

Утас 886-02-23759688 /Факс: 886-02-23757689


И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org

Зохиогчийн эрх: Зохиогчийн бүх эрхийг
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай эдэлнэ.
2016 он.

Зохиогч болон эрхлэн хэвлүүлэгчээс зөвшөөрөл авсны
дараа уг номыг аливаа хэлбэрээр ашиглаж болно.

Одоо ингээд бодоход миний Үнэнийг оноосонд ямар нэг нууц гэх юм үгүй аж. Надад байгаагаас дан ганц чин сэтгэл л байлаа. Оюун санааны зам мөрт зориг шулуудсан миний сэтгэлд бодогдох юм, шаардах зүйл, санагдах хүн огт байгаагүй...

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



Үнэнийг дээдэд барихуй
Багшдаа бүрэн итгэхүй
Дияаны үеэр сэтгэлийн уяагүй төвлөр
Оюун санааны хөтөч Багш нарын дэргэд байхын ач тус
Даруу төлөв байдал Үнэн Ёсонд ойр
Чин ариун сэтгэлтэн илүү түргэн дэвшдэг
Тайвшрал
Аз жаргалтай бай
Гэр бүлээ хайрла
“Би” үзэл ба Аялгууны бясалгал